



Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс

ХҮНИЙ ЭРХ

ОНОЛ, АРГА ЗҮЙН СЭТГҮҮЛ

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

“Хүний эрх, эрх чөлөөг орон даяар,
цаг ямагт, хүн бүрд”

(24 дэх жилдээ)

2025/02

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс

ХҮНИЙ ЭРХ

Онол, арга зүйн сэтгүүл

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

“Хүний эрх, эрх чөлөөг орон даяар,
цаг ямагт, хүн бүрд”

(24 дэх жилдээ)

2025/02

ХҮНИЙ ЭРХ сэтгүүл

2025/02(66)

Улсын бүртгэлийн дугаар 244

24 дэх жилдээ

Дугаарыг эрхлэн гаргасан:

Б.Энхболд *Ерөнхий редактор
Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн,
Хууль зүйн доктор, дэд профессор*

Э.Мөнхзул *Нарийн бичгийн дарга
Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын Хүний эрхийн
боловсролын хэлтсийн ахлах референт*

Сэтгүүлд нийтлэгдсэн бүтээл нь
Хүний эрхийн Үндэсний Комиссын бодлогыг илэрхийлэхгүй,
зөвхөн зохиогчийн үзэл бодол болно.

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

ISSN:2617-927X

ISSN:2617-9288 (цахим)

АГУУЛГА

ӨГҮҮЛЭЛ, НИЙТЛЭЛ

Д.Сүнжид

Хамтын эрх- хариуцлага 5

А.Алтанзул

Төрийн албан хаагчийн үндсэн эрхийг хамгаалах нь:
хууль тогтоомжийн хэрэгжилт 17

Б.Энхболд, Н.Одонтуул

Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний эрх зүйн
зохицуулалт, үр нөлөөг дээшлүүлэх арга зам 34

Э.Цэрэнханд

Хүүхдийг хууль ёсны асран хамгаалагчид шилжүүлэн
өгөх, тусдаа амьдардаг эцэг, эхтэй нь албадан уулзуулах
шийдвэр гүйцэтгэх ажиллагаа 64

Б.Болороо

Чимээгүй хашгираан 76

Т.Анхбаяр

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хоригдлын
үсийг хусах практик ба хүний эрхийн асуудал..... 87

МОНГОЛ ХЭЛЭЭР ЗӨВХӨН МАНАЙ ХУУДАСНАА

Фернандо Пирие

Эрх зүйн антропологи. Хууль ба төр 107

ЗОЧНЫ ЯРИА

Ц.Санчир

Монгол хүний язгуур чанар..... 132

CONTENT

ARTICLES

Sunjid.D

Collective rights - Responsibility..... 5

Altanzul.A

Implementation of Legislation to Protect the
Fundamental Rights of Civil Servants..... 17

Enkhbold.B, Odontuul.N

Legal Regulation of Compulsory Medical Measures and
Ways to Enhance Their Effectiveness 34

Tserenkhand.E

Enforcement Procedures for Transferring a Child
to a Lawful Guardian and for Compulsory Visitation
with a Non-Custodial Parent..... 64

Boloroo.B

Silent scream..... 76

Ankhubayar.T

The Practice of Head Shaving of Detainees in the
Court Decision Enforcement Agency and Its
Human Rights Implications 87

ONLY IN MONGOLIAN

Fernanda Pirie

The Anthropology of Law. Law and the State..... 107

GUEST INTERVIEW

Sanchir.Ts

The Foundational Essence of Mongolian Identity 132



Д. СҮНЖИД

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга,
Хууль зүйн ухааны доктор (Dr.Jur)

“ХАМТЫН ЭРХ – ХАРИУЦЛАГА”¹

Өнгөрсөн

Одоогийн нөхцөл байдал, сорилт бэрхшээл

Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ

Хүний эрх гэдэг нь хүн бүр төрсөн цагаасаа эдлэх ёстой үндсэн, салшгүй эрх, эрх чөлөөний илэрхийлэл бөгөөд эрх – үүрэг – хариуцлагын нэгдэл юм. Жил бүрийн 12 дугаар сарын 10-ны өдрийг олон улсын хэмжээнд хүний эрхийн өдөр болгон тэмдэглэн өнгөрүүлдэг бөгөөд дэлхийн улс орнууд хүний эрх, эрх чөлөөний нөхцөл байдлын талаар хүрсэн ололт амжилт, сорилт бэрхшээлийг тунгаан хэлэлцэж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар ажил хэрэгч яриаг өрнүүлдэг нь тогтсон жишиг юм. Манай улсын хувьд Монгол Улсын Хүний эрхийн үндэсний байгууллага байгуулагдсан цагаас хойш энэхүү өдрийг тогтмол тэмдэглэн өнгөрүүлж, хүний эрхийн асуудлаар төр, иргэний нийгэм, олон нийтийн санал, шүүмжийг сонсож, хэлэлцүүлж ирсэн уламжлалтай гэдгийг онцлон тэмдэглэж байна. Энэхүү үйл ажиллагааг дэмжиж оролцдог бүх талууддаа талархал илэрхийлье.

Би өнөөдрийн форумд Хүний эрхийн үндэсний байгууллагын түүхэн үүрэг, Монгол Улс дахь хүний эрхийн нөхцөл байдал, сорилт бэрхшээл, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч танилцуулах болно.

¹ Хүний эрхийн Үндэсний Комиссоос зохион байгуулсан “Хүний эрхийн үндэсний форум-2025” арга хэмжээн дээр тавьсан илтгэл.

I. ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ БАЙГУУЛЛАГЫН ТҮҮХЭН ЗАМНАЛ

1992 онд баталсан Монгол Улсын Үндсэн хуулийн Хоёрдугаар бүлгийн Арван зургадугаар зүйлд хүний эрх, эрх чөлөөг хуульчлан баталгаажуулсан бөгөөд хүний эрх, эрх чөлөөг хангах нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн гэж заасан. Хүний эрх, эрх чөлөөг хангах, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг төр иргэнийхээ өмнө хариуцна гэж баталгаажуулсан. Хэдийгээр төр хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах үүрэг хүлээдэг ч хөндлөнгийн хяналт чухал болохыг хүлээн зөвшөөрч, хүний эрхийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий хараат бус хөндлөнгийн байгууллагыг байгуулан ажиллуулдаг механизм олон улсад бий болжээ.

Энэ жишиг, олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн хүрээнд, Монгол Улсын Их Хурлаас 2000 оны 12 дугаар сарын 07-ны өдөр Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийг баталж, 2001 оны 02 дугаар сарын 02-ны өдөр буюу Комиссын анхны гурван гишүүн тангараг өргөснөөр Нэгдсэн Үндэстний Байгууллагын Парисын зарчимд нийцсэн Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ, конвенцоор баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтэд хяналт тавьж, хүний эрхийг хамгаалах, хангах, хөхиүлэн дэмжих чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан Хүний эрхийн үндэсний байгууллага байгуулагдсан түүхтэй.

Хүний эрхийн Үндэсний байгууллага байгуулагдсанаар хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, төрөөс хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангах үүргээ биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих, хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүний эрхийн хэрэгжилтийг сайжруулах төдийгүй эрхээ шаардах, зөрчигдсөн эрхийг хамгаалах үндэсний бие даасан механизм бүрдсэн юм.

Хүний эрхийн Үндэсний Комисс нь олон улсад тогтолцоонд албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн, олон улсын хүний эрхийн зарчмын дагуу ажилладаг үндэсний институт болтлоо хөгжихөд Нэгдсэн Үндэстний Байгууллага, Ази, Номхон далайн бүс нутгийн хүний эрхийн үндэсний байгууллагуудын чуулган, Засгийн газар хоорондын болон хөгжлийн туслалцааны байгууллагууд зэрэг олон талын дэмжлэг, хамтын ажиллагаа томоохон нөлөө үзүүлсэн юм.

Монгол Улсад Хүний эрхийн үндэсний байгууллага байгуулагдсанаас хойш өдгөө 25 жил улирч, хүний эрхийг хамгаалах тогтолцооны үндэс суурийг амжилттай тавьж, институцийн хувьд бэхэжсэн, тогтвортой байгууллага болон төлөвшжээ. Өнгөрсөн хугацаанд хүний эрхийн салбарт анхаарч ажилласан үндсэн асуудлууд, дэвшүүлсэн санал зөвлөмж, тэдгээрийн хэрэгжилтийг үнэлж цэгнэх, ирээдүйн бодлого, алсын хараагаа тодорхойлох 25 жилийн ой ирэх жил тохиох гэж байна. Тухайлбал,

- Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2013 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 13 дугаар тогтоолоор Хүний эрхийн Үндэсний

Комисс аймаг бүрт төлөөлөлтэй болж, хуульд заасан чиг үүргээ үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх боломж бүрдсэн.

- Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр баталснаар Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын үйл ажиллагааг бие даасан, хараат бусаар явуулах нөхцөлийг улам бүр бэхжүүлж, хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтэд хяналт тавих статус, чиг үүргийг өргөжүүлж, Комиссын гишүүний тоог 7 болгон нэмэгдүүлж, жендэрийн тэнцвэрт байдлыг хангах, Комиссын гишүүнийг нээлттэй сонголоор сонгон шалгаруулах процессоор ил тод явуулдаг болж, Комиссын гишүүдээс гомдол, мэдээлэл хүлээн авч, шалган, шийдвэрлэх, хяналт шалгалт хийх бүрэн эрхийнхээ хүрээнд Комиссын гишүүний шаардлага, зөвлөмж заавал биелэгдэх зохицуулалтыг хуульчилсан нь хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чухал алхам болсон.
- Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүд хорих анги, цагдан хорих байр, тусгаарлах байр, асрамж, халамж, сэтгэцийн эрүүл мэндийн төв, цэргийн анги байгууллага зэрэг хаалттай байгууллагуудад хүний эрхийн тогтмол хяналтыг хийж, ямар нэгэн хязгаарлалтгүйгээр тухайн объектод нэвтэрч, хүний эрхийн зөрчлийг илрүүлэх, зөрчлийг таслан зогсоох үйл ажиллагааг хэрэгжүүлэх механизм бүрдсэн.
- Улсын Их Хурлаас 2021 онд хүний хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, аюулгүй байдлыг хангахтай холбоотой харилцааг зохицуулах Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг баталснаар Ази тивд Монгол Улс Хүний эрх хамгаалагчийг хамгаалах тогтолцоог бий болгосон анхны улс юм.

Ингэснээр Хүний эрхийн Үндэсний Комисс Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтэд хяналт тавьж, хүний эрхийг хамгаалах, дэмжих чиг үүргийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ бие даасан механизмууд болох Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа, Хүний эрх хамгаалагчийн эрхийг хамгаалах, Хүний хувийн мэдээлэл хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа нь Хүний эрхийн үндэсний байгууллагын хөгжлийн түүхэнд нэгэн шинэ хуудсыг нээлээ.

II. КОМИССЫН ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨГ ХАМГААЛАХ ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД

Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл, үр дүн: Хүний эрхийн Үндэсний Комисс 2002 оноос эхлэн судалгаа, дүн шинжилгээ, хяналт шалгалт, иргэдээс ирүүлсэн гомдол, мэдээлэл, төрийн болон иргэний

нийгмийн байгууллагуудын тайлан, статистик мэдээлэлд үндэслэн Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 удаагийн илтгэлийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн барьсан. Эдгээр илтгэлүүдэд Монгол Улсын хүний эрхийн нөхцөл байдал, иргэний болон улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын эрхүүдийг бүхэлд нь хамруулсан бөгөөд зарим эрхийг тухайн үеийн нөхцөл байдал, тулгамдсан асуудал, зөрчигдөж буй байдалд үндэслэн давтан тусгасан юм. Тухайлбал, Ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхийн хүрээнд 23, эрүүл аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийн хүрээнд 19, халдашгүй, чөлөөтэй байх эрхийн хүрээнд 17, эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхийн хүрээнд 15, сурч боловсрох эрхийн хүрээнд 13, шүүхэд гомдол гаргах, зөрчигдсөн эрхээ сэргээлгэхтэй холбоотой эрхийн хүрээнд 13 удаа тус тус илтгэлд тусгаж, Улсын Их Хурлаар шийдвэр гаргуулахаар хүргүүлсэн байна. Харин мэдээлэл хайх, хүлээн авах, соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх, шашин шүтэх, эс шүтэх эрхийн хүрээнд 1-2 удаа илтгэлд тусгажээ.

Улсын Их Хурал байнгын хороо болон үндсэн хуралдаанаараа Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлийг хэлэлцэж, хүний эрхийг хангахад чиглэсэн бодит ажил хэрэг болсон бодлого, шийдвэрүүдийг гаргаж байв. Тухайлбал,

- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын II нэмэлт болох цаазаар авах ялыг халах тухай протоколд Монгол Улс нэгдэн орох асуудлыг удаа дараа гарган тавьсны үндсэн дээр 2012 оны 3 дугаар сарын 13-ны өдөр уг пактын II нэмэлт протоколд нэгдэн орж, цаазаар авах ялын бодлогыг халсан цаазын ялгүй орон болоход, 2009 онд Монгол Улс Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцыг соёрхон батлахад, 2016 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай бие даасан хууль батлагдахад хувь нэмрээ оруулсан.
- Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй бүх хэлбэрийг устгах бодлого, үнэлэх шалгуур үзүүлэлт болон хэрэгжилтийг хянах тогтолцоог бий болгох, хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг шийдвэрлэх, хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл байдлыг анхаарах талаар 21 дэх илтгэлдээ тусган, санал хүргүүлснийг Улсын Их Хурлын 2022 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 49 дүгээр тогтоолоор баталсан.
- Үндэсний их баяр наадмын хурдан морины уралдаан болон хүйтний улиралд хурдан морины уралдаан зохион байгуулсны улмаас хурдан морины уралдаанч хүүхдийн амь нас хохирсон, бэртэж гэмтсэн, улмаар хөгжлийн бэрхшээлтэй болох явдал гарсаар байгааг илтгэлдээ тусгаж, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 57 дугаар тогтоолд зааснаар жил бүрийн 11 дүгээр сарын 01-ний өдрөөс

05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээ зохион байгуулахыг хориглосон шийдвэрийг гаргасан.

- Монгол Улсад эрүүдэн шүүхийг хориглох тогтолцоо илүү тодорхой болж, хүчирхийлэл, эрүүдэн шүүлт, хаалттай байгууллагуудын хүний эрхийн нөхцөл байдлыг ил болгож, төрийн анхаарлыг хандуулж чадсан бөгөөд төрөөс Эрүүдэн шүүхийн эсрэг нэмэлт протоколын дагуу Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний механизмыг Хүний эрхийн Үндэсний Комиссын дэргэд байгуулсан.
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль шинэчлэгдэхэд өгсөн дүгнэлт, судалгаа, хүүхдийн хүчирхийллээс хамгаалах, хөдөлмөрлөх эрхийн асуудлаар төрд өгсөн зөвлөмж, бодлогын нөлөөлөл, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан хүрээлэн буй орчны хүртээмжийг сайжруулах үнэлгээ, зөвлөмж нь бодит биеллээ олсон зэргийг жишээлэн дурдая.

Хуулийн төсөлд санал өгөх, үр дүн: Комисс хууль тогтоомж, эрх зүйн актын төслийг хүний эрхийн үндсэн зарчимд нийцэж буй эсэхэд үнэлгээ хийж, шаардлагатай саналыг хүргүүлдэг тогтолцоог өнгөрсөн 25 жилийн хугацаанд амжилттай төлөвшүүлж, бэхжүүлжээ. 2001 оноос хойш хийсэн 168 судалгаа, боловсруулсан 2,226 санал нь хууль тогтоомжийг хүний эрхийн зарчимд нийцүүлэхэд бодит нөлөө үзүүлсэн бөгөөд зөвхөн сүүлийн таван жилд 72 судалгаа, 888 саналыг холбогдох байгууллагад хүргүүлснээс 2020 онд 17 хууль тогтоомжид 189, 2021 онд 27 хууль тогтоомжид 255, 2022 онд 16 хууль тогтоомжид 122, 2023 онд 16 хууль тогтоомжид 128, 2024 онд 37 хууль тогтоомжид 185, 2025 онд 44 хууль тогтоомжид 198 санал хүргүүлсэн нь Комиссын үйл ажиллагааны ач холбогдол, үр нөлөөг илэрхийлж байна.

Ганцхан жишээ дурдахад, сүүлийн 5 жилийн хугацаанд, Улсын Их Хуралд хүргүүлсэн Комиссын санал, зөвлөмжийн мөрөөр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 180 орчим зүйл хэсэгт нэмэлт өөрчлөлт орж, сэжигтнийг хойшлуулшгүйгээр баривчлах, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ, хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, өмгөөллийн үйл ажиллагааны баталгааг хангах, мэтгэлцэх зарчмыг бэхжүүлэх, нотлох баримтыг шинжлэн судлах, хохирогчийн эрхийг хамгаалах, шүүхийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах зэрэг зарчмын шинжтэй зохицуулалтыг олон улсын жишигт нийцүүлэн тусгаж, хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлээд байна.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд хүний эрх, эрх чөлөөний хязгаарлалтад тавигдах шаардлагыг тусгах саналыг хүргүүлж, Улсын Их Хурлын 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдөр Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

хуулийг баталж, тухайн хуулийн төслөөр хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах тохиолдолд “үндэсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөө, нийгмийн хэв журмыг хамгаалах зайлшгүй шаардлага бүхий байх, ялгаварлан гадуурхаагүй байх, хязгаарлалт нь зорилгодоо хүрэхэд тохирсон, боломжит бага түвшинд байх” шаардлагыг хангасан байх зохицуулалтыг оруулсан нь цаашид хууль тогтоомжийг батлан гаргахад хүний эрхийн агуулгыг заавал тусгахад ач холбогдолтой зохицуулалт болсон юм.

Гомдол мэдээлэл шалгасан байдал: 25 жилийн хугацаанд хүний эрх, эрх чөлөө, зөрчигдсөн эрхийг сэргээлгэхээр иргэдээс нийт 13,269 гомдол, мэдээллийг хүлээн авч шийдвэрлэсэн байх ба энэ хугацаанд Комиссын гишүүд гомдол, мэдээллийн мөрөөр болон өөрийн санаачилгаар 2,104 удаагийн хяналт шалгалт хийж, Комиссын гишүүний 530 шаардлага, 666 зөвлөмжийг холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав. Үүнээс сүүлийн 5 жилийн хугацаанаас өмнөхтэй харьцуулахад, 4,425 гомдол, мэдээлэл хүлээн авч, шалгаж шийдвэрлэсэн нь нийт Комисст ирүүлсэн гомдол, мэдээллийн 37 хувийг эзэлж, шударга шүүхээр шүүлгэх, халдашгүй чөлөөтэй байх, хөдөлмөрлөх эрх зөрчигдсөн гомдол, мэдээлэл дийлэнх хувийг эзэлж байна. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль 2020 онд шинэчлэн батлагдсанаас хойш Комисст хандсан иргэдийн гомдол, мэдээллийн тоо 70,1 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа нь нэг талаас иргэдийн хүний эрхийн талаарх мэдлэг, ойлголт дээшилж, эрхээ шаардаж байгаа гэж болох ч нөгөө талаас хүний эрхийн зөрчил буурахгүй байна гэж дүгнэхээр байна.

Хяналт шалгалт: Сүүлийн 5 жилийн хугацаанд Комисс 775 удаагийн хяналт шалгалт хийсэн нь 25 жилийн хугацааны нийт хяналт шалгалтын 36,7 хувийг, Комиссын гишүүний 320 зөвлөмж, Комиссын гишүүний 155 шаардлага нь нийт зөвлөмж, шаардлагын 48 хувийг эзэлж байна. Тухайлбал, 2021 оноос хойш улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй Ерөнхий боловсролын сургуулийн 193 дотуур байр, цэргийн анги байгууллагад 46 удаа, мөрдөн шалгах байгууллагын мэдүүлэг авах болон ярилцлага хийх өрөөний стандарт, үйл ажиллагаанд 109 удаагийн хяналт шалгалт зохион байгуулжээ.

Төлөөлөн нэхэмжлэл гаргасан байдал: 2002 оноос хойш төрийн байгууллага, албан тушаалтны буруутай үйл ажиллагааны улмаас хохирсон иргэнийг төлөөлж төрөөс хохирлыг гаргуулахаар нийт 4,8 тэрбум төгрөгийг буруутай этгээдээс нэхэмжилснээс 557 сая гаруй төгрөгийг ханган шийдвэрлэсэн, 19 нэхэмжлэгчид сэтгэл санааны хохиролд 247 сая гаруй төгрөгийг олгохоор шийдвэрлэсэн нь иргэдийн эрхийг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээлгэх, хохирлыг нөхөн төлүүлэх, хууль хэрэгжилтийг хангасан ажил болжээ. Энэхүү шүүхэд төлөөлөн нэхэмжлэл гаргах Комиссын гишүүний хуулиар олгогдсон бүрэн эрх нь бүс нутагтаа сайн туршлагад тооцогдож байна.

Комиссоос зорилтот бүлэг, цөөнхийн эрхийг хамгаалахад байнга

анхаардаг. Ялангуяа хүүхэд, охид эмэгтэйчүүд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, үндэсний цөөнх, залуучууд, малчид, алслагдсан бүсэд амьдарч буй иргэд, өрх толгойлсон хүмүүс, ажилгүй, орлогогүй, эрх нь хязгаарлагдсан хүмүүс зэрэг нийгмийн тодорхой бүлэгт онцгойлон анхаарч, Засгийн газарт зөвлөмж, хяналт, бодлогын зөвлөгөө, дэмжлэг үзүүлж хамтран ажиллаж, бодит нөлөөлөл үзүүлж байна.

Хүний эрхийн боловсролыг дэмжих чиг үүргийн хүрээнд: Эрхээ мэддэг, бусдын эрхийг хүндэтгэдэг, хариуцлагатай иргэнийг төлөвшүүлэх, эрхээ шаардах чадварыг бий болгох, хүний эрхийн соёлыг нийгмийн бүх түвшинд түгээн дэлгэрүүлэх, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр төр болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж, иргэд, олон нийтэд чиглэсэн хүний эрхийн боловсрол олгох үйл ажиллагааг тасралтгүй, тогтмол зохион байгуулж байна. Комисс байгуулагдсан цагаасаа эхлэн хүний эрхийн боловсролыг дэмжих, түгээх чиг үүргийн хүрээнд 4,441 удаагийн 12,452 цагийн сургалтад 233,014 оролцогчийг хамруулсан байна. Үүнээс сүүлийн 5 жилийн хугацаанд 1,882 удаагийн 3,624 цагийн сургалтад 98,851 оролцогчид хамрагджээ.

Хүний эрхийн боловсрол олгох тогтолцоог төгөлдөржүүлэх, технологийн дэвшилд тулгуурлан богино хугацаанд олон хүнд шинэ мэдлэг хандлага төлөвшүүлэхэд анхаарч байна. Комисс ЕБС-ийн сурах бичгийн агуулгад хүний эрхэм чанар, хүний эрх, эрх чөлөө, ардчилал, тэгш байдал, хууль дээдлэх ёс зэрэг боловсролын сууринд байх ёстой үнэт зүйлийг тусгах, “Хүний эрхийн түгээмэл тунхаглал манай ангид”, “Үндсэн хууль манай сургуульд”, “Хүүхэд бүр ялагч- хүүхэд бүр хамгаалагч”, “Хүний эрхийн хамгаалагчийг хэн сайн мэдэх вэ” зэрэг олон нийтийн арга хэмжээг тогтмол зохион байгуулж, төрийн байгууллагын хэмжээнд хүний эрхийн сургагч багшийн тогтолцоог нэвтрүүлээд байна. Хүний эрхийн боловсролын Дэлхийн хөтөлбөрийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх Зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлж, үр дүнг тооцох ажлыг эхлүүлээд байна.

Олон талт хамтын ажиллагааны хүрээнд: Хүний эрхийн Үндэсний Комисс нь олон улсын болон бүс нутгийн хүний эрхийг хамгаалах тогтолцооны хүрээнд амжилттай ажиллаж байна. Тухайлбал, НҮБ-ын Хүний эрхийн гэрээний хороодод Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтийн талаар 12 удаагийн хөндлөнгийн илтгэл хүргүүлснээс гадна олон улсын хүний эрхийн байгууллагуудын гишүүнчлэлд идэвхтэй ажиллаж байна. Олон улсын төвшинд манлайлал үзүүлэх, илүү сайн ирээдүйг бий болгох зорилгор 2025 онд “Идэвхтэй насжилт: Ахмадад ээлтэй нийгмийг бүтээх нь” сэдэвт Ази, Номхон далайн бүсийн форумыг Улаанбаатар хотноо зохион байгуулж, НҮБ-ын Ахмад настны эрхийн бие даасан конвенц батлуулахад түлхэц боллоо. Форумын оролцогчдын зөвшилцлөөр “Улаанбаатарын Уриалга”-ыг батлан гаргаж, холбогдох олон улсын байгууллага, оролцогч улсуудад илгээлээ.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах бодлогын талаар: Хүний эрхийн Үндэсний Комисс нь Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу уг хуулийн хэрэгжилтэд хяналт тавих үүргийг хэрэгжүүлж ирлээ. Комиссоос “Хүний эрх ба технологи” олон нийтийн, нээлттэй хяналт шалгалтыг 11 салбарын 40 орчим асуудлын хүрээнд явуулж урьдчилсан дүгнэлтийг танилцуулаад байна. Эдгээр ажлыг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Австрали Улсын Элчин сайдын яам, олон улсын болон үндэсний эрдэмтэн, судлаачдын дэмжлэгтэйгээр гүйцэтгэж, УИХ-аар шийдвэр гаргуулахаар Комиссын 24 дэх илтгэлд тусгасан. Уг илтгэлийн мөрөөр гарсан УИХ-ын 2025 оны 77 дугаар тогтоолоор Засгийн газраас авч хэрэгжүүлэх арга хэмжээг 8 заалтаар үүрэг болгов.

Иргэний нийгмийн зөвлөл: Иргэний нийгмийн зөвлөл нь Хүний эрхийн Үндэсний Комиссын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хүний эрхийг хамгаалах, нийгмийн оролцоог нэмэгдүүлэх чухал институц болжээ. Зөвлөл нь олон талын төлөөлөлтэйгээр хууль, эрдэм шинжилгээ, нийгмийн салбарын мэдлэг, туршлагыг Комиссын үйл ажиллагаанд нэгтгэж, зөвлөмж, судалгаа, сургалт, мэдээлэл түгээх, нөлөөллийн үйл ажиллагаанд оролцох зэрэг чиг үүргийг хэрэгжүүлж, нийгмийн идэвх, оролцоог нэмэгдүүлж байна.

III. МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮНИЙ ЭРХИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ СОРИЛТ, ШИЙДВЭРЛЭХ АСУУДАЛ

Монгол Улс хүний эрхийг хангах, хамгаалах, дэмжих чиглэлээр тасралтгүй үйл ажиллагаа явуулж, олон арга хэмжээ авч байгаа хэдий ч бодит үр дүн, ахиц дэвшил гаргах, хүрсэн төвшингөөсөө ухрахгүй байх хүчин чармайлт нэн чухал байна. Дэлхийн улс орнуудын хэмжээнд үүсэж буй зөрчил, эдийн засгийн таагүй байдал, байгаль цаг уурын өөрчлөлт зэргээс шалтгаалж хүний эрхийн нөхцөл байдалд олон сорилтууд тулгарч байгаа нь манай улсын хувьд ч хамааралтай асуудал юм.

“Дэлхийн шударга ёсны төсөл”-өөс жил бүр гаргадаг “Эрх зүйт ёсны индекс”-ээр Монгол Улс 2025 оны байдлаар 143 орноос 67 дугаарт, бүс нутгийн хэмжээнд 15 улс орноос 8 дугаарт эрэмбэлэгджээ. Шударга шүүхээр шүүлгэх болон хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх эрхийн хэрэгжилттэй холбогдуулан Эрх зүйт ёсны индексийн үндсэн болон дэд шалгуур үзүүлэлтүүдийг авч үзвэл Монгол Улс нь иргэний шүүхийн шударга байдлын үнэлгээгээр 0.54 оноогоор 66, эрүүгийн шүүхийн шударга байдлын үнэлгээгээр 0.48 оноогоор 60, Засгийн газрын эрх мэдлийн хязгаарлалтын үнэлгээгээр 0.53 оноогоор 70, Авлигын түвшингийн үнэлгээгээр 0,42 оноогоор 89, Засгийн газрын ил тод байдлын үнэлгээгээр 0.49 оноогоор 79, суурь эрхийн үнэлгээгээр 0.56 оноогоор 69 дүгээрт тус тус эрэмбэлэгдсэн байна. Монгол Улс “Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний индекс”-ийн шалгуур болох улс төр, эдийн засаг,

хууль тогтоомж, нийгэм, аюулгүй байдлын нийлбэр үзүүлэлтээр 2021 онд 71.03 оноогоор 180 улсаас 68 дугаарт эрэмбэлэгдэж байсан. Гэвч 2025 онд бүх үзүүлэлтээр огцом ухарч 52.34 оноогоор 180 улсаас 102-т эрэмбэлэгджээ.

Монгол Улсын хэмжээнд ядуурлын түвшин 27,8 хувьтай байгаа нь иргэдийн амьдралын чанарт сөргөөр нөлөөлж байна. Өөрөөр хэлбэл, иргэдээ ядуурлаас гаргах, өрхийн орлогыг нэмэгдүүлэх, цалин хөлсийг хүрэлцэхүйц болгох зэрэг эдийн засаг, нийгэм соёлын эрхэд бодитой өөрчлөлт гарахгүй байгаа нь хүний эрхийн зөрчлийн суурь шалтгаан болж байгаад санаа зовниж байна.

Хүүхэд, охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл болон гэр бүлийн хүчирхийллийн тоо буурахгүй байх, уур амьсгалын өөрчлөлт, үер, ой хээрийн түймэр, ган зуд, хүний эрхийн мэдрэмжгүй хот төлөвлөлт, утаа, агаарын бохирдол, замын түгжрэл зэрэг нь хүний аюулгүй байх, амьд явах, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхэд шууд нөлөөлөл үзүүлж, бизнесийн үйл ажиллагаанаас үүдэлтэй хүний эрхийн зөрчлүүд гарч байгаа нь бодлогын түвшинд онцгойлон анхаарах шаардлагатайг илэрхийлж байна.

Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, баталгаажуулах, монгол хүний амьдралын чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн нэн чухал хуулиудыг батлан гаргах ажил удаашралтай байгаад шүүмжлэлтэй хандаж байна. Улсын Их хурлын хоёр бүрэн эрхийн хугацаа, хэд хэдэн чуулганыг дамжин нэн шаардлагатай хуулиуд хэлэлцэхгүй, удаашралтай байна. Тухайлбал, Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль, Жагсаал цуглаан хийх эрх чөлөөний тухай хууль, Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хууль, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, Гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн хохирол нөхөн төлүүлэхэд чиглэсэн хууль, Шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангуулахад чиглэсэн хууль, иргэдийн эдийн засгийн баталгааг бүрдүүлэх зэрэг гол гол хуулиудыг нэн тэргүүнд батлах шаардлага байна.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын илтгэлийн мөрөөр гарсан Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийг бүрэн хангах шаардлага байна. Бид хүний эрх, эрх чөлөөний талаарх тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга замыг тодорхойлж чадаж байна. Төрийн байгууллага, албан тушаалтан бүр хүний эрхийн талаар ярьж, хэлэлцэж байгаа ч бодит ажил хэрэг болгох тал дээр хүссэн үр дүн гарахгүй, тунхаг шинжтэй, аргацаасан байдлаар явж байгааг шүүмжилж байна. Энэ байдлыг засаж, бодит ажил хэрэг болгох асуудал тулгамдаад байна.

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлийг хэлэлцээд хүний эрх, эрх чөлөөг хангаж, хамгаалах чиглэлээр баталсан УИХ-ын тогтоолын биелэлтийг авч үзвэл, 2019 оны 62 дугаар тогтоолын хэрэгжилт 58.5 хувь, 2021 оны 67 дугаар тогтоолын хэрэгжилт 71.4 хувь, 2022 оны 49 дүгээр тогтоолын хэрэгжилт 62.3 хувь, 2023 оны 35 дугаар тогтоолын

хэрэгжилт 42.5 хувь, 2024 оны 37 дугаар тогтоолын хэрэгжилт 51.0 хувийн гүйцэтгэлтэй буюу хэрэгжилт хангалтгүй гэсэн үзүүлэлттэй, Улсын Их Хурлын Тамгын Газрын үнэлгээгээр дээрх тогтоолуудын биелэлтийг 1-21 хувьтай буюу, хангалтгүй хэмээн дүгнэсэн байна. Тогтоолд туссан боловч хэрэгжээгүй асуудлыг авч үзвэл, хүний эрхийг хангаж, хамгаалахад чиглэсэн тогтолцооны шинжтэй суурь асуудлыг шийдвэрлэхгүй орхигдуулж байна. Тухайлбал, сэтгэцийн эмгэгтэй хүний асрамжийн газар байгуулах, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах, боловсролын тэгш бус байдлыг бууруулах, эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх зэрэг суурь асуудлыг шийдэж чадахгүй байна. Үүнээс үзэхэд Улсын Их Хуралд хүргүүлсэн Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлийн хэрэгжилт хангалтгүй, хянах механизм сул гэж дүгнэж байна. Иймд Комиссын Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлийг хэлэлцэн баталсан УИХ-ын тогтоолын биелэлтийг дараагийн ээлжит илтгэлийг хэлэлцэхээс өмнө дүгнэх, эргэх холбоог тодорхойлсон эрх зүйн зохицуулалтыг бий болгох шаардлагатай.

Хүний эрхийг хангах, хамгаалах байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоо, хяналт тэнцлийг хангах эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлага байна. Хүний эрхийг хамгаалах байгууллагуудад итгэх олон нийтийн итгэл нэмэгдүүлэх шаардлага байгааг судалгааны дүгнэлтүүд харуулж байна. Тухайлбал, гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгааны дүгнэлтээс үзэхэд, шүүхээр үйлчлүүлсэн иргэдийн 37.1 хувь, прокурорын байгууллагаар үйлчлүүлсэн ирэдийн 42.9 хувь, Цагдаагийн байгууллагаар үйлчлүүлсэн иргэдийн 63 хувь нь тус тус сэтгэл ханамжгүй байгаа талаар дурджээ. Комиссоос хийсэн судалгаа, иргэний нийгмийн байгууллагуудын дүгнэлтүүдээс үзэхэд хүний эрхийг хамгаалах байгууллагуудын үйл ажиллагаа уялдаа холбоо хангалтгүй, иргэний зөрчигдсөн эрхийг сэргээхэд бие биенээ нөхөж ажиллах чадваргүй байгааг дурдсан. Цаашид Үндсэн хуулийн цэцэд хүний үндсэн эрхийн маргааныг хянан шийдвэрлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх, Прокурорын хараат бус бие даасан байдлыг хангах эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хариуцлагын тогтолцоог сайжруулах, Хүний эрхийн Үндэсний Комиссын гомдол хянан шийдвэрлэх ажиллагааг боловсронгуй болгох, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх, хүний эрх хамгаалагч, хувийн мэдээлэл хамгаалах механизмуудын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах, шүүхийн шийдвэр заавал биелдэг байх, иргэний зөрчигдсөн эрхийг сэргээх, мөрдөн шалгах ажиллагааг богино хугацаанд шуурхай явуулах чадавхыг сайжруулах зэрэг асуудал нэн тэргүүнд хүлээгдэж байна. Түүнчлэн Хүний эрхийн олон улсын гэрээг хэрэгжүүлэх, Засгийн газрын үйл ажиллагааны салбар дундын уялдаа холбоог хангах, гэрээний хэрэгжилтийн талаар НҮБ-ын хүний эрхийг хамгаалах тогтолцоонд хүргүүлэх тайлан боловсруулах ажлыг удирдан зохион байгуулах чиг үүрэг бүхий оновчтой, үр нөлөөтэй бүтцийг Засгийн газрын түвшинд бий болгох асуудлыг ч судалж шийдвэрлэх шаардлагатай.

Зорилтот бүлгийн эрх, хөгжил, хамгааллын бодлогыг сайжруулж, хэрэгжилтийн үр нөлөөг дээшлүүлэх арга хэмжээ авах нь чухал байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаарх үндэсний хууль тогтоомжийн зохицуулалтыг хүний эрхийн зарчим, хэм хэмжээнд нийцүүлэн боловсронгуй болгож, тэдний эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг баталгаатай эдлүүлэх, нийгмийн харилцаанд бие даан саадгүй оролцоход чиглэсэн нийгмийн үйлчилгээний болон дэд бүтцийн хүртээмжийг түгээмэл зарчимд нийцүүлэх ёстой. Мөн ахмад настанд үзүүлэх урт болон богино хугацааны тусламж үйлчилгээний загвар, бодлого, стандартыг сайжруулж, олон нийтийн оролцоо, хувийн хэвшлийн санаачилгад тулгуурлан хөгжүүлэх асуудлыг нэн даруй шийдвэрлэх шаардлагатай. Төрийн байгууллагаас аливаа шийдвэр гаргахдаа зарим бүлгийн иргэдийн эрхийг тухайлбал, хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ажил мэргэжил эзэмшээгүй залуучууд, зарим бүлгийн эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, бэлгийн, хэлний, үндэстний цөөнхүүд, цэрэг, малчид, гадаадад амьдарч буй иргэд, тодорхой төрлийн гэмт хэргийн хохирогчид, хоригдогч, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид, хүний эрх хамгаалагчдын эрхийг хангах, хамгаалах, зөрчигдсөн тохиолдолд эрхийг сэргээж чадаж буй эсэхэд байнга анхаарч, тухайлсан хэрэгцээ, шаардлагыг бодитой үндэслэх шаардлагатай.

Монгол Улсын цахим хөгжлийн бодлого, хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтийг үнэлж, шинэ тутам хүний эрхийн асуудалд анхаарлаа хандуулах шаардлага тулгарч байна. Технологийн хурдацтай хөгжил нь хүний хувийн мэдээлэлд халдах, халдашгүй чөлөөтэй байх эрхийг хязгаарлах, нууцаар мөрдөн мөшгих, тагнан чагнах эрсдэлийг нэмэгдүүлэхээс гадна хүн амын дийлэнх хэсэг, ялангуяа хүүхэд залуусыг цахим донтолт, мөрийтэй тоглоомд татан оруулах эрсдлийг нэмэгдүүлж байна. Мөн жендэрт суурилсан хүчирхийлэл үйлдэх шинэ сувгуудыг бий болгож, хүчирхийллийн арга хэлбэр өөрчлөгдөж байгааг Комиссын судалгаа дүгнэлтүүд харуулж байна. Тиймээс хүний хувийн мэдээлэл хамгаалах, хяналт тавих эрх зүйн орчныг улам боловсронгуй болгож, хиймэл оюуны үндэсний стратегийг боловсруулах, цахим технологи ашиглан үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх, хариу арга хэмжээ авах цогц бодлого гаргах шаардлага тулгарч байна.

Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд нутгийн захиргааны болон аж ахуйн нэгж, байгууллагын хүний эрхийг хангаж байгаа байдал, хэрэгжүүлж буй арга хэмжээний биелэлтийг үнэлэх, тайлагнах чиг үүрэг бүхий нэгжийг байгуулах асуудлыг шийдвэрлэх. Аймаг, дүүрэг бүр хүний эрхийн нөхцөл байдлын үнэлгээ хийж, шаардагдах төсөв, дэд бүтцийг бүрдүүлэх байдлаар хариуцсан нутаг дэвсгэртээ хүний эрхийг хангаж хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай. Ялангуяа, уул уурхайн хайгуулын үйл ажиллагаа,

газар чөлөөлөх, хот төлөвлөлт, нүүлгэн шилжүүлэлт эхлэхээс өмнө тухайн нутгийн иргэдтэй зөвлөлдөх талаарх хуулийн зохицуулалтыг чөлөөтэй, урьдчилан мэдээлж, зөвшөөрөл авах (Free Prior Informed Consent) олон улсын зарчимд нийцүүлэх, тус зарчмын дагуу үүргээ хэрэгжүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагын зохицуулалтыг бий болгоход анхаарах нь зүйтэй.

Хүний эрхийг хамгаалах, дэмжих ажилд иргэний нийгмийн оролцоо нэмэгдүүлэх шаардлага байна. Монгол Улсын дунд болон урт хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулж, хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах чиглэлээр иргэний нийгмийн байгууллагыг дэмжих, хамтран ажиллах цогц төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх бодлого гаргахыг уриалж байна. Ялангуяа, төрийн зарим чиг үүргийг нээлттэй, шударга сонгон шалгаруулалтын дүнд төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэхэд анхаарах нь чухал байна. Түүнчлэн, хүний эрхийн боловсролыг дэмжих, хөндлөнгийн мониторинг, дүн шинжилгээний ажилд өргөн хэмжээнд оролцуулах боломжийг судлах хэрэгжүүлэх нь олон талын ач холбогдолтой юм.

Эцэст нь тэмдэглэхэд, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссоос Хүний эрхийг хангах үндэсний 2 дугаар хөтөлбөрийг бүх талуудын оролцоотойгоор 7 зорилго, 45 зорилт, 276 арга хэмжээ бүхий бүтэцтэйгээр боловсруулж, Засгийн газарт хүргүүлсэн боловч батлахгүй байхаар шийдвэрлэж, бусад хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичигт зарим хэсгийг тусгаад байгаа юм. Цаашид тус хөтөлбөрийн төсөлд туссан арга хэмжээ бүрийг анхааралтай судлан хэрэгжүүлэх шаардлагатай болохыг зөвлөж байна.

Анхаарал тавьсан та бүхэнд баярлалаа.





А.АЛТАНЗУЛ

Удирдлагын академийн эрх зүйн тэнхимийн багш,
доктор, дэд профессор

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ҮНДСЭН ЭРХИЙГ ХАМГААЛАХ НЬ: ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

IMPLEMENTATION OF LEGISLATION TO PROTECT THE FUNDAMENTAL RIGHTS OF CIVIL SERVANTS

Хураангуй: Төрийн албан хаагч нийтийн ашиг сонирхлыг хамгаалж, ард түмэндээ үйлчлэх үүрэгтэй тул тэдний хувьд эрх гэхээс илүү үүрэг, хариуцлага нэгдүгээрт тавигддаг. Өнөөдөр байнгын үйлчлэлтэй 500 орчим хуулийн 170 гаруй хуульд төрийн албан хаагчийн үүрэг, хориглох зүйлийг тусгасан. Эндээс Монгол Улсад төрийн албан хаагчийн хуулиар хүлээсэн үүрэг, хязгаарлалт, зан харилцааны хориглолтой холбоотой 43 хууль, нийтлэг зохицуулалт бүхий 10 гаруй ёс зүйн дүрэм үйлчилж байна. Тодруулбал, төрийн албан хаагчийн тодорхой эрхүүд хатуу хязгаарлалтад ордог гэсэн үг. Түүнчлэн Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.1-т: төрийн албан хаагчийн хувьд хуулиар тогтоосон иргэний эрх, эрх чөлөөний хязгаарлалтыг үг, үйлдлээр эсэргүүцэх, бусдыг өдөөн турхирахыг ёс зүйн зөрчилд тооцдог. Гэхдээ төрийн алба хаших явцад төрийн албан хаагчийн үндсэн эрхийг хөндсөн зөрчлүүд сүүлийн үед цөөнгүй гарч байна. Хэдийгээр тодорхой эрхүүдээ хуулиар хязгаарлуулдаг ч тухайн албан хаагчийн үндсэн эрхийн хамгаалалт сайн байх аваас тэдний төрд чин үнэнчээр зүтгэх, ард түмэндээ үйлчлэх зорилго бүрэн хангагдана. Төрийн албан хаагчийн эрхийг хамгаалж буй хууль тогтоомжийн хэрэгжилтийн өнөөгийн байдлыг гаргахын

тулд төрийн албан хаагчдаас авсан санал асуулга болон холбогдох шүүхийн шийдвэрт шинжилгээ хийлээ.

Түлхүүр үгс: төрийн албан хаагч, үндсэн эрх, эрхийн зөрчил, түүнээс урьдчилан сэргийлэх эрх зүйн тогтолцоо

Abstract: For a civil servant, whose duty is to protect the public interest and serve the people, duties and responsibilities take precedence over rights. "Currently, more than 170 out of about 500 laws in force define the duties and restrictions of civil servants."

In Mongolia, 43 laws and over 10 codes of ethics are currently in force, governing the legal duties, restrictions, and ethical conduct of civil servants.

Consequently, the rights of civil servants are limited by specific legal restrictions established by law. For instance, under Article 8.2.1 of the Law on Civil Servants' Ethics, a civil servant commits an ethical violation if they, through words or actions, oppose the legally established restrictions on civil rights and freedoms, or incite others to such opposition. However, during their tenure in public service, civil servants often experience violations of their fundamental rights. While some rights are limited by law, the effective fulfillment of the duty to serve the government and the public depends on the proper protection of civil servants' fundamental rights.

This article aims to evaluate the current implementation status of laws protecting the rights of civil servants by conducting a survey among civil servants and analyzing relevant court rulings.

I. УДИРТГАЛ

Төрийн албан хаагчийн эрх гэдэг нь хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд өөрийн үүргээ гүйцэтгэх явцад эдлэх боломжтой, давуу талуудыг хэлнэ.¹ Төрийн албан хаагчийн үндсэн эрхийг Монгол Улсын Үндсэн хуульд заасан үндсэн эрхээр тодорхойлж байна.

Төрийн албан хаагчийн эрхийн талаарх онол хандлагууд нь төр, иргэн хоёрын харилцаа, хүний эрхийн ойлголт зэргийг үндэслэн хөгжсөн байдаг. Тэдгээр онол, хандлагуудаас дараах хэлбэрүүдийг авч үзвэл:

- Үүргийг чухалчилсан хандлага: Энэ хандлагаар төрийн албан хаагч нь зөвхөн хуульд тодорхойлсон хүрээнд эрх эдэлдэг гэж үздэг. Тэдний эрх нь: Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн хуулиар хамгаалагдсан байдаг. Энэ хандлага нь төрийн албан хаагчийн эрх, үүрэг, хариуцлагын тэнцвэрийг чухалчилдаг. Ялангуяа ром-германы эрх зүйн бүлийн улсад хамаарах улсууд тухайлбал, ХБНГУ, Франц зэрэг орнуудад

¹ en.wikipedia.org/, n.d.

төрийн албан хаагчдын эрх, үүргийг төрийн албаны тусгай хуулиар маш нарийн зохицуулдаг. Энэ хандлагаар төрийн албан хаагчийн эрх нь үүргийнхээ дараа эрэмблэгддэг хатуу зарчимтай гэж хэлж болно.

- Жам ёсны эрхэд суурилсан хандлага: Энэ хандлагаар төрийн албан хаагч нь жирийн иргэнтэй адил үндсэн эрхүүдийг эдлэх ёстой гэж үздэг. Үүнд: үг хэлэх, эвлэлдэн нэгдэх эрх, хувийн нууцын хамгаалалт гэх мэт эрхүүд багтана. Энэ нь хүний эрхийн түгээмэл зарчимд нийцсэн хандлага юм. Англо-саксоны эрх зүйн бүлд багтах Канад, АНУ-д төрийн албан хаагчид нь ердийн иргэнтэй адилхан үндсэн эрхүүдээ эдэлдэг. Үүнийг илүү либералчлагдсан гэж хэлж болно.
- Нийгмийн баталгаанд суурилсан хандлага: Төр өөрийн албан хаагчдын тодорхой эрхийг хязгаарлахын хэрээр нийгмийн баталгааг өндөр байлгах ёстой гэж үздэг. Энэ хандлагаар БНСУ, Япон зэрэг Азийн улс орнуудын хууль тогтоомжид түлхүү харагддаг.²
- Олон улсын эрх зүйн хандлага: Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ILO)³ НҮБ-ын конвенциудын хүрээнд төрийн албан хаагчийн хөдөлмөрлөх эрх, эвлэлдэн нэгдэх эрх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх зэрэг олон улсын стандартууд ч туссан байдаг.

Монгол Улсын төрийн албан хаагчийн эрхийн суурь зохицуулалтыг “Төрийн албаны тухай хууль”-ийн 38, 61 дүгээр зүйлүүдээр тус тус зохицуулсан.

II. ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ҮНДСЭН ЭРХИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ

Төрийн албан хаагчийн эрхийг Үндсэн хуульд заасан дараах үндсэн эрхүүдтэй уялдуулан авч үзье. Үүнд:

- Амьд явах, халдашгүй дархан байх эрх
- Эрх бүхий байгууллагад гомдол гаргах эрх

Эдгээр төрийн албан хаагчийн эрхүүд өнөөдөр практикт хамгийн их зөрчигдөж байж болзошгүй гэж зохиогч урьдчилан таамаглал дэвшүүлэн судалгаа хийсэн болно. Судалгааны явцад энэ өгүүлэлд дурдагдсан эрхүүдээс гадна төрийн албан хаагчийн үзэл бодлоо илэрхийлэх эрх хөндөгдсөн ба гэхдээ уг өгүүлэлд энэ удаа бичээгүй, дараагийн өгүүлэлд дэлгэрэнгүй дурдах болно.

Амьд явах, халдашгүй дархан байх эрх

Монгол Улсын Үндсэн хууль, хүний эрхийн олон улсын гэрээ, дотоодын бусад хууль тогтоомжуудаар хамгаалагдсан суурь эрхүүдийн нэг юм. Энэ эрх

² Зохиогчийн дэвшүүлсэн ангилалт.

³ Iryna Dyshleva. Rights and Duties of Public Servants. https://www.researchgate.net/publication/334533005_Rights_and_Duties_of_Public_Servants

нь төрийн албан хаагч ч бай, энгийн иргэн ч бай ялгаагүй, бүх хүнд ижил тэгш хамаарна. Гэхдээ төрийн албан хаагч бол төрийн нэрийн өмнөөс ажил үүргээ гүйцэтгэж байгаа этгээд тул хуулиар үүрэг болгоогүй ч амь биеэ үл хайрлан чин үнэнчээр зүтгэх итгэл үнэмшил төрийн албан хаагчдад байдаг.

Тухайлбал, Монгол Улсын иргэн цэргийн жинхэнэ албанд орохдоо: “Монгол Улсын иргэн Би Монгол Улсын Үндсэн хуулиар хүлээсэн иргэний цэргийн үүргээ үнэнчээр биелүүлж, өвөг дээдсийнхээ ариун гал голомт болсон Монгол Улсынхаа халдашгүй дархан байдлыг амь бие үл хайрлан батлан хамгаалахаа эх орон, төр, ард түмэндээ андгайлан тангараглая. Би ард түмнийхээ үндэсний эв нэгдэл, Монгол цэргийн шилдэг уламжлалаа эрхэмлэн хүндэтгэж, цэргийн эрдэмд шамдан боловсорч, улсын нууцыг найдвартай хадгалж, Монгол Улсын хууль, цэргийн дүрмийг чанд сахин биелүүлэхээ батлан тангараглая. Эх орноо батлан хамгаалагч дайчин Би өргөсөн тангаргаасаа няцваас төрийн хууль ёсны цээрлэл хүлээнэ.” гэж цэргийн тангараг өргөдөг.⁴

Төрийн албан хаагчийн амьд явах эрх, халдашгүй дархан байх эрхийг зөрчдөг дараах гурван ойлголт байна. Үүнд:

1. Төрийн албан хаагчийн биед халдах
2. Төрийн албан хаагчийг заналхийлэх
3. Төрийн албан хаагчийг доромжлох

“Төрийн албан хаагчийн биед халдах” гэдэг нь Монгол Улсын Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээлгэхүйц үйлдэл бөгөөд энэ нь албан үүргээ гүйцэтгэж байгаа төрийн албан хаагчид бие махбодын халдлага үйлдэх, зодох, гэмтэл учруулах, эсвэл хүч хэрэглэхээр заналхийлэх зэрэг үйлдлийг хэлнэ. Өнөөдөр Монгол улсад төрийн тусгай алба хаагчийн биед халдах нь гэмт хэрэг, зөрчилд тооцогдоно.

Зөрчлийн тухайд:

Зөрчлийн тухай хуулийн 15 дугаар бүлэгт “Төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааны эсрэг зөрчил” гэсэн бие даасан бүлэг бий. Уг хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-д Төрийн албан тушаалтны шийдвэрийг үл биелүүлэх, үйл ажиллагаанд нь саад учруулах гэсэн хэсэгт “Хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлж байгаа төрийн албан хаагчийг хүч хэрэглэхгүйгээр эсэргүүцсэн, эсхүл доромжилсон бол хүнийг хоёр зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж заасан.

“Хууль сахиулах чиг үүрэг” гэж цагдаа, дотоодын цэрэг, тагнуул, гааль, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, төрийн тусгай хамгаалалтын албаны болон авлигатай тэмцэх, хил хамгаалах, гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн байгууллагын алба хаагчийн хуульд заасан чиг үүргийг ойлгоно гэсэн төрийн

⁴ Цэргийн албаны тухай хуулийн 5 дугаар зүйл, 2016 он.

тусгай албан хаагчдад уг зохицуулалт хамаарна. Мөн тус хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-т “Шүүгчийн хараат бус байдалд нөлөөлөхийг оролдох” гэсэн зөрчилд шүүгчийн хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахад аливаа хэлбэрээр нөлөөлөх, доромжлох, халдах, эсэргүүцэхийг оролдсон, эсхүл шүүх, шүүгчийн аюулгүй байдлын журам зөрчсөн бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно гэсэн бол 15.6-д “Прокурорыг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд саад учруулах зөрчилд “хуулиар хүлээсэн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь прокурорт санаатайгаар саад учруулсан, эсхүл доромжилсон, эсхүл эрх чөлөөнд нь халдсан бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно гэж тус тус заажээ. Гэхдээ практикт, зөрчлийг шалгаж шийдвэрлэх явцад алба хаагчийг зодсон, чулуугаар шидсэн, шороо цацсан, нулимсан, хувцас, цагдаагийн эд зүйл (энгэрийн камер, гар чийдэн, дохиур мод зэрэг) эвдсэн тохиолдлыг шалгахгүй өнгөрөөх нь түгээмэл гэж хэлж болохоор байна. Хохирсон алба хаагчдын ердөө 14.3 хувь нь л хохирлоо нөхөн төлүүлсэн дүн гарчээ. Аюулгүй байдлыг хангах талаар олон талын арга хэмжээ авч байгаа боловч тэр нь дэс дараа, уялдаа холбоо муутай, сургалтын чанар, өгөөж хангалтгүй байна.⁵

Харин төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийг чиг үүрэгтэй нь холбоотой биед халдсан үйлдэлд тусгайлан хариуцлага хүлээлгэх заалт Зөрчлийн тухай хуульд байхгүй. Өгүүлэл бичигч Удирдлагын академийн магистр Э.Ануутай хамтран 2024 оны 9 сараас 2025 оны 2 сард хүртэлх хугацаанд нийт 300 албан хаагчаас санал асуулга болон ярилцлагын аргаар судалгаа авсан. Энэ судалгааны хүрээнд төрийн захиргаа болон үйлчилгээний албан хаагчидтай ярилцлага хийхэд:

Шигтгээ 1.

Би төрийн өмчийн ЕБС-д багшилдаг. Өнөөдөр багш нар сурагчдад шаардлага тавихад эцэг, эхчүүд нь ирж хэл амаар доромжлох энүүхэнд болсон. Мөн зарим багш нарын биед халдсан тохиолдол ч гарсан. Энэ талаар цагдаад мэдэгдэх гэхээр удирдлагын зүгээс олон нийтэд шуугиан болгоод яахав гээд орхидог.

Төрийн үйлчилгээний албан хаагчтай хийсэн ярилцлагаас

Гэмт хэргийн тухайд:

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын хорин гуравдугаар бүлэг “Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг”-т хамаарах 23.1 дүгээр зүйлд “Хууль сахиулагчийг эсэргүүцэх” гэмт хэрэг буюу тус заалтын 1-д: Хууль

⁵ Доктор Н.Лхагвасайхан “Цагдаагийн алба хаагчийн албан үүргээ гүйцэтгэх үеийн аюулгүй байдал”, докторын зэрэг хамгаалсан бүтээл, 2023 он.

сахиулагчийг албан үүргээ биелүүлэхтэй нь холбогдуулан хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлж эсэргүүцсэн бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ гэж заасан. Практикт энэхүү зүйл, заалтын хүрээнд тулгамдаж буй асуудал нэлээд байдаг талаар алба хаагчдын зүгээс ярьдаг бөгөөд хууль хэрэгжиж эхлээд жил гаруйн хугацаанд буюу 2018 онд тус зүйл ангийн хүрээнд үйлдсэн 85 гэмт хэрэг шинээр бүртгэгдэж, 154 гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан бол 2019 онд 97 гэмт хэрэг шинээр бүртгэгдэж, 189 гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа, 2020 онд 198 гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа, 2021 онд 241 гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа тус тус явуулснаас үзэхэд энэхүү зүйлд заасан гэмт хэргийн гаралт жил ирэх тутам өсөж байгаа нь харагдаж байна. Мөн тухайн бүлгийн хүрээнд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд шалгагдаж буй нийт гэмт хэргийн 24–30 орчим хувийг, шинээр бүртгэгдэж буй нийт хэргийн 27–36 хувийг Эрүүгийн хуулийн 23.1 дүгээр зүйлд заасан гэмт хэрэг эзэлж байгаа тухай судалгаанд дүгнэсэн байна.⁶

Түүхчилж харвал: 1950-2022 оны хооронд албан үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан 115 цагдаагийн алба хаагч байна. 1950-1960 онд 1, 1961-1970 онд 5, 1971-1980 онд 10, 1981-1990 онд 14, 1991-2000 онд 18, 2001-2010 онд 23, 2011-2022 онд 44 алба хаагч хохирчээ. Цагдаагийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэж байхдаа бусдад буудуулж, галт зэвсэгт өртөж нас барсан 7, хутгалуулж хүйтэн зэвсэгт өртсөн 9, тархинд цус харвах, зүрх зогсох өвчний улмаас 8, зам тээврийн ослоор 43, бусад тохиолдлоор 48 алба хаагч амь эрсэдсэн байна.⁷

ХЭҮК-ын Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлд дурдсанаар: Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын алба хаагчдын аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авах шаардлагатай байна. 2022 онд албан үүргээ гүйцэтгэх явцдаа гэмт хэргийн шинжтэй 210 үйлдэлд 238 алба хаагч, зөрчлийн шинжтэй 4 үйлдэлд 4 алба хаагч тус тус өртөж хохирчээ. Гэмт хэргийн шинжтэй үйлдэлд өртөж хохирсон 238 алба хаагчаас 3 албан хаагч золгүй байдлаар, 5 алба хаагч зам тээврийн ослоор нас барсан бол шинжээчийн дүгнэлтээр 2 алба хаагчийн биед хүнд, 4 алба хаагчийн биед хүндэвтэр, 27 алба хаагчийн биед хөнгөн гэмтэл тогтоогдож, 18 алба хаагчийн гэмтэлд шинжээчийн дүгнэлт гараагүй, 178 алба хаагчийн биед гэмтэл тогтоогдоогүй байна.

⁶ Б. Түмэндэмбэрэл, Х.Буянбат, О.Энххүслэн. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 23.1 дүгээр зүйл буюу Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаварт хийсэн дүн шинжилгээ. Нээлттэй Нийгэм Форум, 2023 он.

⁷ Доктор Н.Лхагвасайхан “Цагдаагийн алба хаагчийн албан үүргээ гүйцэтгэх үеийн аюулгүй байдал”, докторын зэрэг хамгаалсан бүтээл, 2023 он.

Дээр дурдсанчлан төрийн захиргаа болон үйлчилгээний албан хаагчдын биед халдах зэрэг үйлдлийг Эрүүгийн хуульд тусгайлан гэмт хэрэг гэж тооцдоггүй тэдний бие махбодод халдвал бусад иргэний адил амь нас, эрүүл мэндэд халдах гэмт хэргийн зүйлчлэлийг хэрэглэдэг.

Шигтгээ 2.

Би ... дүүргийн нэг цэгийн үйлчилгээнд ажилладаг төрийн захиргааны албан хаагч. Янз бүрийн ухамсартай иргэд төрийн үйлчилгээ авдаг ба зарим нь гар утсаа гаргаж бичлэг хийж нийтийн сүлжээнд тавина гэж хашхирдаг. Хэдийгээр хууль дүрэм зөрчиж болохгүй гэж тангараг өргөдөг ч иргэд ажлаа хэвийн хийхэд хүндрэл учруулдаг тул төрийн албанаас гарах, өөр ажилд шилжих талаар бодох болсон.

Төрийн захиргааны албан хаагчтай хийсэн ярилцлагаас

“Төрийн албан хаагчийг заналхийлэх гэдэг нь” гэдэг нь хэн нэгэн иргэн, этгээд төрийн албан тушаалтан, албан хаагчид ямар нэгэн хэлбэрээр дарамт үзүүлэх, айлган сүрдүүлэх, эсвэл хууль бус үйлдэл хийлгэх зорилгоор сүрдүүлэх үйлдлийг хэлдэг. Жишээлбэл: төрийн албан хаагчийг албан үүргээ биелүүлж байхад нь хүч хэрэглэнэ гэж сүрдүүлэх, түүнийг гүтгэх, нэр төрд нь халдах, бичлэг, зураг ашиглан дарамт үзүүлэх, тухайн албан хаагчийн эсвэл гэр бүлийн гишүүдийн аюулгүй байдалд хохирол учруулна гэж заналхийлэх зэрэг үйлдлүүд багтана. Ийм заналхийлэл нь албан үүргээ шударгаар гүйцэтгэж буй төрийн албан хаагчдыг хууль ёсны үйл ажиллагаанаас нь ухраах, буруугаар нөлөөлөх зорилготой байдаг тул хуулиар хориглодог.

Шигтгээ 3.

Би төрийн захиргааны албан хаагчаар 30 жил ажиллаж байна. Энэ хугацаанд төрийн албанд хоёргүй сэтгэлээр зүтгэсэн. Анх ажилд орж буй үед хүмүүс төрийн албан хаагчдыг ихэд хүндэлдэг байсан. Гэтэл сүүлийн үед төрийн албан хаагч гэхээр авлига авдаг, муу хүмүүс гэх хандлага нийгэмд их болжээ. Яахав үнэхээр хэдэн улс төрийн голдуу албан хаагчид, тэдний томилгооны хүмүүс төрийн албаны нэр хүндлийг гутааж байгаа нь үнэн. Харин бүх албан хаагчдыг хамруулж ойлгож болохгүй. Биднийг доромжиллоо гээд бид хаана ч ханддаггүй. Төрийн албаны тэвчих ёстой гэдэг үүргээ ухамсарлаад ажилладаг.

Төрийн захиргааны албан хаагчтай хийсэн ярилцлагаас

“Төрийн албан хаагчийг доромжлох” гэдэг нь тухайн төрийн албан хаагчийн нэр хүнд, албан тушаалтай холбоотой тэднийг үгээр эсвэл үйлдлээр гутаан доромжлох үйлдэл юм. Иргэд, удирдах албан тушаалтнаас төрийн албан


хаагчдыг үгээр доромжлох, нэр хүндийг гутаах үйлдэл хэвийн үзэгдэл болсныг сүүлийн үеийн хэвлэл мэдээлэл, олон нийтийн хэрэгслээс харж болно. Хамгийн гол төрийн албан хаагчид өөрсдийн нэр төрөө хамгаалах талаар эрх бүхий байгууллагад хандах эрхээ төдийлөн хэрэгжүүлдэггүй байна.

Төрийн албан хаагчийг доромжлох тухайд дээр дурдсанчлан хууль сахиулагчийг доромжилсон үйлдэлд Зөрчлийн тухай хууль үйлчилнэ.

III. ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ


Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.4-т албан үүргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан хүчирхийлэх, заналхийлэх, доромжлох, гүтгэх болон бусад хууль бус үйлдэл, үйл ажиллагаанаас төрийн албан хаагч, түүний гэр бүлийн гишүүнийг тухайн ажиллаж байгаа байгууллага, эсхүл цагдаагийн байгууллагаар хамгаалуулна гэж заасан. Судалгааны үр дүнгээс товч танилцуулбал:

Зураг.1 Албан тушаалын ангилал тус бүрээр




Судалгаанд иргэдэд төрийн үйлчилгээг шууд хүргэдэг төрийн жинхэнэ албан хаагчдыг хамруулсан. Үүнд төрийн тусгай албанд ажилладаг цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, шүүхийн ажилтнууд, мөн төрийн үйлчилгээг захиргааны журмаар хүргэдэг байгууллага, нэг цэгийн үйлчилгээний төвийн ажилтнууд, түүнчлэн төрийн захиргааны албан хаагч, багш, эмч нарыг голлон түүвэрлэн авсан.

Зураг 2. Төрийн алба хаших хугацаанд Таныг байгууллагын дарга, бусад удирдах албан тушаалтны зүгээс үг хэлээрээ доромжилсон тохиолдол гарч байсан уу?




Судалгаанд “Удирдах албан тушаалтны зүгээс үг хэлээр доромжлох үйлдэл гарч байсан уу?” гэсэн асуултад оролцогчдын 90 орчим хувь нь “тийм” гэж хариулсан байна. Түүнчлэн “3-аас дээш удаа тохиолдсон” гэж хариулсан оролцогчид дийлэнх буюу 128 хүн байв. Эдгээр 128 албан хаагчийн хүн ам зүйн үзүүлэлтийг авч үзэхэд ажилласан жил, хүйс, албан тушаалын ангиллын хувьд хол зөрүү гарсангүй.

Зураг 3. Төрийн алба хаших хугацаанд Таныг иргэд, хуулийн этгээдийн зүгээс үг хэлээрээ доромжилсон тохиолдол гарч байсан уу?



Судалгаанд “Иргэдийн зүгээс үг хэлээр доромжлох үйлдэл гарч байсан уу?” гэсэн асуултад оролцогчдын 90 гаруй хувь нь “тийм” гэж хариулсан. Үүнээс “2-оос дээш удаа тохиолдсон” гэж хариулсан оролцогчид дийлэнх буюу 130 хүн байв. Нийт “тийм” гэж хариулсан 272 албан хаагчийг хүн ам зүйн үзүүлэлтээр авч үзэхэд ажилласан жил, хүйс, албан тушаалын ангиллын хувьд мөн адил хол зөрүү гарсангүй.

Зураг 4. Төрийн алба хаших хугацаанд Таныг болон гэр бүлийн гишүүдийг иргэн, хуулийн этгээдийн зүгээс заналхийлсэн тохиолдол гарч байсан уу?



Судалгаанд “Иргэдийн зүгээс заналхийлсэн тохиолдол гарч байсан уу?” гэсэн асуултад оролцогчдын 80 орчим хувь нь “үгүй” гэж хариулсан байна. Харин “нэг удаа” гэж 12 хүн, “2–3 удаа” гэж 7 хүн, “3-аас дээш удаа” гэж 10 хүн хариулжээ. Заналхийлэлд өртсөн гэж хариулсан оролцогчдыг авч үзэхэд ихэвчлэн эрэгтэй, төрийн тусгай албанд ажилладаг, 10-аас дээш жил ажилласан албан хаагчид байв.


Эрх бүхий байгууллагад гомдол гаргах эрх

Албан хаагч өөрийн эрх зөрчигдсөн гэж үзвэл дараах шатлалын дагуу гомдол гаргаж болно. Үүнд:

- Байгууллагын дотоод нэгж албанд
- Төрийн албаны зөвлөлд гомдол гаргах
- Хүний эрхийн Үндэсний Комисст гомдол гаргах
- Шүүхэд нэхэмжлэл гаргах
- Бусад арга хэрэгслээр эрхээ хамгаалуулах

Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.4-т төрийн албан хаагч, түүний гэр бүлийн гишүүнийг тухайн ажиллаж байгаа байгууллага, эсхүл цагдаагийн байгууллагаар хамгаалуулна гэсэн заалтын хэрэгжилт ямар байгааг судалгаанд оролцогчдоос асуусан.

Зураг 5. Танай байгууллага Таны аюулгүй байдлыг хангах талаар ямар арга хэмжээ авч байсан бэ?



Судалгаанд оролцогсдын 50 гаруй хувь нь байгууллагын зүгээс тодорхой арга хэмжээ аваагүй эсвэл дээд шатны байгууллагад мэдэгдсэн гэсэн хариултыг өгсөн байна. Харин төрийн захиргааны албан хаагчдын дунд байгууллагаас аюулгүй байдлыг хангах чиглэлээр ямар нэгэн арга хэмжээ аваагүй гэсэн хариулт дийлэнх хувийг эзэлжээ.

Төрийн албаны зөвлөлийн 2024 оны тайлант хугацаанд иргэн, төрийн албан хаагчдаас эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж, зөрчигдсөн тухай 417 гомдол ирүүлсэн нь Төрийн албаны зөвлөлд ирүүлсэн нийт өргөдөл, гомдлын 46.3 хувийг эзэлж байна. Төрийн албан хаагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж, зөрчигдсөн тухай гомдлыг агуулгаар нь авч үзвэл сонгон шалгаруулж, томилох үйл ажиллагаатай холбоотой болон сахилгын шийтгэл, ажлаас чөлөөлсөнтэй холбоотой өргөдөл, гомдол дийлэнх хувийг эзэлж байна. Хууль ёсны эрх, ашиг сонирхол хөндөгдөж, зөрчигдсэн гэж үзэж гомдол гаргасан төрийн жинхэнэ албан хаагчийг төрийн захиргааны түшмэлийн ангиллаар нь авч үзвэл эрхэлсэн түшмэл 2, ахлах түшмэл 17, дэс түшмэл 19 байна.

Хүний эрхийн Үндэсний Комиссын Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 14-23 дахь илтгэлүүдэд төрийн албан хаагчийн хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтийн талаар тусгасан байна. Тус газраас 2021 онд хийсэн Хөдөлмөрийн хүрээний дарамт хүчирхийллийн судалгааны тайлангаас

үзэхэд судалгаанд оролцогсдын 80 гаруй хувь нь ажлын байрны дарамт, хүчирхийллийг “хүний эрхийн зөрчил” гэж ойлгож байгаа ч түүнийг хөдөлмөрийн харилцааны бусад зөрчлөөс ялгахгүй байна. Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, дүрэмд ажлын байрны дарамт, хүчирхийллийн талаарх заалт байгаа эсэхийг 5 хүн тутмын 2 буюу 40.4 хувь нь “мэдэхгүй”, 27.6 хувь нь байгууллагын дотоод журамд нь дээрх зохицуулалт “байхгүй” гэж хариулсан. Ажилтныг үг хэлээр доромжлох, загнах, дорд үзэж харьцах зэрэг ажлын байрны дарамт, хүчирхийллийг удирдах арга барилын алдаа, ёс зүй, зан харилцааны асуудал гэж үзэж хариуцлага тооцохгүй байх, хамгаалж, хөнгөрүүлж авч үзэх хандлагатай байна. “Төрийн захиргааны албан хаагчдын дундах Ажлын байрны бэлгийн дарамтын мэдлэг, хандлага болон тархалтын байдлын судалгаа”-нд оролцсон албан хаагчдын 77.6 хувь ажлын байрны бэлгийн дарамт хүчирхийллийг хүний эрхийн зөрчил мөн гэжээ.

Шүүх 2020-2025 оны хугацаанд төрийн тусгай албан хаагчийн үндсэн эрхэд халдсан 552 хэргийг хянан шийдвэрлэсэн байна. Харин төрийн захиргаа, үйлчилгээний албан хаагчдын талаарх судалгаа байхгүй. Учир нь хууль тогтоомжоор эдгээр албан тушаалын ангиллын дагуу тусгайлан эрх зүйн хамгаалалт байхгүй.


Бусад арга хэрэгслээр эрхээ хамгаалуулах: Төрийн үйлчилгээний албан хаагчид эрх, ашиг сонирхлоо хамгаалуулах зорилгоор үйлдвэрчний эвлэл болон мэргэжлийн холбоодод хандах боломжтой. Эдгээр төрийн бус байгууллага, холбоод нь дараах үйл ажиллагааг зохион байгуулдаг.

Үүнд:

- Төрийн бүх ангиллын албан хаагчдын эрх ашгийг хамтад нь хамгаалдаг.
- Хууль бус халагдал, дарамт, цалингийн асуудлаар хэлэлцээ хийж хамгаалалт үзүүлдэг.
- Хамтын хэлэлцээр байгуулж, ажил хаялт зохион байгуулах замаар эрх хамгаалдаг.

ОИХ.МН
СУДАЛГААНЫ САН

Зураг 6. Удирдах албан тушаалтны зүгээс гарч байсан хууль бус үйлдлүүдийн талаар танд асуудал гарч байсан бол гомдлоо хаана гаргаж байсан бэ?




Төрийн албан хаагчид удирдах албан тушаалтны талаарх гомдлоо хаана ч гаргаж байгаагүй гэсэн хариултыг 244 албан хаагч өгчээ. Үүнээс удирдах албан тушаалтны зүгээс биед халдах болон доромжлох үйлдэл гарч байгаагүй гэж хариулсан 34 албан хаагчийг хасаж үзвэл, ямар нэгэн байдлаар өртөж байсан албан хаагчдын 80 гаруй хувь нь гомдлоо хаана ч гаргаж, хандаагүй байна. Эдгээр оролцогчдоос “Яагаад эрх бүхий байгууллагад хандаагүй вэ?” гэсэн нээлттэй асуултад дараах хариултуудыг өгсөн байна.

1. Хаана хандахаа сайн ойлгоогүй, мэдлэг дутагддаг
2. Байгууллагынхаа нэр хүндийг өөрийн нэрээс илүүд тавьсан
3. Ажлын шаардлагын нэг хэлбэр гэж хүлээж авсан
4. Удирдах албан тушаалтан учир өөдөөс нь үг хэлж тайлбар тавьж болохгүй хэл амаар доромжлуулаад өнгөрдөг
5. Хандсан тохиолдолд шийдвэр удирдлагын талд шийдвэрлэгдэх эсвэл гомдол гаргасан гэж удирдах албан тушаалтны дарамт шахалтаас эмээсэн учраас
6. Хэлээд нэмэргүй гэж үзсэн
7. Энэ талаар албан хаагчдыг хамгаалдаг хууль тогтоомж байхгүй гэж үзсэн учраас
8. Тэвчих ёстой гэж бодсон

Судалгаанд оролцогсдын 50 орчим хувь хаяа гэж хариулсан бол бид эрхээ яривал ёс зүйн зөрчилд холбогдоно гэсэн хариултыг 128 хүн хариулжээ. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд төрийн албан хаагчдад иргэний эрхийн хязгаарлалтаас давсан үг хэл, үзэл бодлоо илэрхийлбэл ёс зүйн зөрчилд тооцдог юм. Төрийн албан хаагчид удирдах албан тушаалтнуудынхаа талаар дээд шатны төрийн байгууллагадаа 37 хүн хандсан нь бусад төрийн байгууллагад гаргасан тооноос илүү байна. Харин дээд шатны байгууллагадаа хандахаар дараа даргыгаа матсан гэж илүү их дарамт ирдэг тул тэр бүрд гомдол гаргаад явдаггүй гэж нээлттэй асуултад таван албан хаагч хариулсан байна.


Зураг 7. Хэрэв дээр дурдсан иргэдийн зүгээс гарч байсан хууль бус үйлдлүүдийн талаар танд асуудал гарч байсан бол гомдлоо хаана гаргаж байсан бэ?



Иргэдийн зүгээс гарч буй хууль бус үйлдлүүдийн талаар хандаагүй гэж хариулсан төрийн албан хаагчдаас яагаад эрх бүхий байгууллагуудад хандаагүй вэ? гэсэн нээлттэй асуултад дараах хариултуудыг өгсөн байна.


1. Ачаалал их байдаг учир үүний араас хөөцөлдөх зав байхгүй.
2. Иргэний хувьд сэтгэцийн хувьд асуудалтай хүн байсан учраас хэлээгүй
3. Байнга тохиолддог тул тэр бүрд гомдол гаргаад явдаггүй
4. Иргэдийн сэтгэлзүй маш хүнд уур бухимдал ихтэй учир зүггүй хашхичдаг зарим хүмүүс байдаг
5. Адгийн зарга 10 хоногтой ажлаа алдана гэж үзсэн
6. Алба хаагчийг өмөөрөх байгууллага байхгүй

Зураг 8. Та эрх чинь зөрчигдсөн тохиолдолд бусад албан хаагчидтай чөлөөтэй ярилцаж чаддаг уу?



Судалгаанд оролцогсдын 50 орчим хувь хааяа гэж хариулсан бол бид эрхээ яривал ёс зүйн зөрчилд холбогдоно гэсэн хариултыг 128 хүн хариулжээ. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд төрийн албан хаагчдад иргэний эрхийн хязгаарлалтаас давсан үг хэл, үзэл бодлоо илэрхийлбэл ёс зүйн зөрчилд тооцдог нь тэдний эрхээ хамгаалахад саад учирдаг гэж төрийн албан хаагчид тайлбарлаж байлаа.

Зураг 9. Төрийн албан хаагчийн эрхийг хамгаалах эрх зүйн орчин хангалттай бүрдсэн үү?



Судалгаанд оролцогсдын 116 нь дунд зэрэг гэж хариулсан ба хангалттай бүрдээгүй гэх агуулгаар хариултыг багцалбал нийт 300 албан хаагчдын 273 нь үгүй гэж хариулсан байна.

Хууль сахиулагчийн биед халдаж зодоход гэмтэл учирч болохыг ухамсарлаж мэдсээр атлаа хохирогчтой зүй бус харьцаж, улмаар түүний биед халдаж, нүүрэн тус газарт нэг удаа мөргөж түүний биед дээд уруулын салстын зулгаралт, цус хуралт, баруун дээд 1-р шүдний гэмтэл бүхий хөнгөн хохирол санаатай учруулсан үйлдэлд торгох ял оногдууллаа. Энэ ялыг төрийн албан хаагчдад учруулсан байдалтай харьцуулбал ял шийтгэх хөнгөдсөн байна гэж үзлээ.

Мөн энэ судалгаанд төрийн албан хаагчийн үндсэн эрхийг зөрчсөн буюу биед нь халдаж хүчирхийлэх, доромжлох, заналхийлэх зөрчилд хууль зүйн хариуцлагын хувьд зөвхөн Эрүүгийн хуульд, тухайлбал хууль сахиулагчийн гэж тусгайлан зохицуулсан байдаг тул хууль сахиулагчийн биед халдсан, заналхийлсэн 2022-2024 онуудын Эрүүгийн анхан шатны шүүхийн 43 шийдвэрт шинжилгээ хийлээ.

Дүн шинжилгээгээр төрийн тусгай албан хаагчийн биед халдах, доромжлох үйлдэлтэй холбоотой хэрэгт шүүхээс ихэвчлэн торгох ял оногдуулж байна. Мөн гэмт хэрэг, зөрчил гарсан газар дээр очиж ажиллах, эргүүл хийх, жагсаал, цуглааны үеэр хэв журам сахиулах, замын хөдөлгөөн зохицуулах зэрэг үүргээ гүйцэтгэх үед тэдний аюулгүй байдал нь хамгийн их алдагдаж, эрсдэлд өртдөг байна.

IV. ДҮГНЭЛТ

Өнөөдөр олон нийтийн цахим хэрэгслээр төрийн алба хаагчийг гүтгэсэн, доромжилсон, нэр төрд нь халдсан зүйл нийтэлж, нэвтрүүлэх нь эрс өсөж байгаа нь тэдний аюулгүй байдал алдагдах нэг хүчин зүйл болж байна. Төрийн албан хаагч тангараг өргөдөг тул тэдэнд олон нийтийн зүгээс үүрэг, хариуцлагатай ажиллаж байхыг шаарддаг. Төрийн албан хаагчийн үндсэн эрхийн хамгаалалт ялангуяа төрийн захиргааны албан хаагчдын амьд явах, халдашгүй дархан байх эрхийн хамгаалалтыг бусад иргэнтэй адилтган үзэж буй төрийн албан хаагчийнхаа аюулгүй байдлыг хамгаалах баталгааг төр хангалтгүй биелүүлж байна гэж дүгнэж байна.

Хэдийгээр удиртгал хэсэгт дурдсан жам ёсны эрхийн хандлагаар авч үзвэл ийнхүү адилтган үзэх нь буруу биш боловч манай улсын хувьд төрийн албан хаагчийн нийгмийн баталгаа, цалин хөлс, улс төрөөс ангид байх зэрэг баталгааны хувьд учир дутагдалтай, иргэдийн эрх зүйн ухамсар сул байдаг учраас төрийн албан хаагчийн эрхийг хамгаалах эрх зүйн орчинг сайжруулах шаардлагатай байна. Иймд дараах саналыг гаргаж байна. Үүнд:

Нэг. Эрүүгийн болон Зөрчлийн хуульд зөвхөн хууль сахиулагч гэхгүйгээр төрийн албан хаагч гэж томъёлох

Хоёр. Төрийн албан хаагчийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой тусгайлсан бүлэг Төрийн албаны тухай хуульд оруулах эсхүл Төрийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль гэж бие даасан хууль батлах

Гурав. Төрийн албан хаагчийн эрхээ хамгаалах тогтолцоо, гомдлоо гаргахад удирдах ажилтны дарамтаас ангид байх тогтолцоо бүрдүүлэх буюу Төрийн албаны Зөвлөл, Ёс зүйн Хороо, хөдөлмөрийн маргаан таслах комисс зэргийн бүрэн эрхэд тодорхой зааж өгөх зэрэг саналтай байна.

V. НОМ ЗҮЙ

Эх сурвалж:

1. А.Алтанзул, Ч. Энхбаатар, Р. Мухийт, С. Ганцэцэг. Төрийн албан хаагчийн ёс суртахууны эрх зүйн зохицуулалтад хийсэн шинжилгээ. Удирдлагын академи. 2023. Улаанбаатар.
2. В.Амарсайхан. Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал. 2023. Улаанбаатар.
3. Н.Лхагвасайхан. Цагдаагийн албан хаагчийн аюулгүй байдлын баталгаа. 2023. Улаанбаатар.

Цахим эх сурвалж

4. Dyshleva, Iryna Rights and Duties of Public Servants. 2019. https://www.researchgate.net/publication/334533005_Rights_and_Duties_of_Public_Servants

UIH.MN
СУДАЛГААНЫ САН



Б. ЭНХБОЛД

ХЭҮК-ын гишүүн, доктор, дэд профессор



Н. ОДОНТУУЛ

Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүхийн шүүгч, доктор

ЭМНЭЛГИЙН ЧАНАРТАЙ АЛБАДЛАГЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ҮР НӨЛӨӨГ ДЭЭШЛҮҮЛЭХ АРГА ЗАМ

LEGAL REGULATION OF COMPULSORY MEDICAL MEASURES AND WAYS TO ENHANCE THEIR EFFECTIVENESS

Хураангуй

Энэхүү эрдэм шинжилгээний өгүүлэл нь эрүүгийн эрх зүйд хэрэглэгддэг эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний эрх зүйн үндэс, хэрэгжилтийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлыг судлан шинжилж, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох санал, дүгнэлт боловсруулахад чиглэнэ. Судалгааны хүрээнд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний үндэсний эрх зүйн зохицуулалт, эрүүгийн болон холбогдох бусад хууль тогтоомжийн уялдаа холбоо, хэрэгжилтийн үр нөлөөг онол, практикийн түвшинд дүн шинжилгээ хийсэн.

Судалгаанд фокус ярилцлага, санал асуулга, ажиглалтын арга болон баримт бичгийн шинжилгээний аргыг ашигласан бөгөөд эрүүгийн хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн 30 шүүгч, 30 прокурор, СЭМҮТ-ийн 10 эмч, ажилтан, ШШГЕГ-ын харьяа хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны

40 алба хаагч зэрэг нийт 110 хүнийг хамруулсан. Мөн хорих ял эдэлж буй 130 орчим хоригдлын дунд ажиглалтын судалгаа хийж, 101 шүүхийн шийдвэр, СЭМҮТ-д албадан эмчлүүлэгч этгээдийн 117 хувийн хэрэг, холбогдох тайлан мэдээ, статистик мэдээлэл, 200 орчим сэтгэцийн шинжилгээний дүгнэлтийг түүвэрлэн судалсан.

Судалгааны үр дүнд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний эрх зүйн зохицуулалт болон хэрэгжилтэд тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, хэрэгжилтийн үр нөлөөг дээшлүүлэх чиглэлээр санал, зөвлөмж боловсруулсан болно.

Цаашид шүүх сэтгэц эмгэг судал, эрүүгийн процессын эрх зүй, шүүхийн шийдвэр гүйцэтгэл, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны хүрээнд дагнасан судалгаа хийх шаардлага хүлээгдэж байгааг онцлон тэмдэглэж байна.

Abstract

This research article aims to identify the legal foundations of compulsory medical measures applied within criminal law, examine existing theoretical and practical challenges, and develop recommendations to improve the effectiveness of their implementation. The study analyzes the national legal framework governing compulsory medical measures, the interrelation between criminal law and other relevant legislation, and evaluates the current implementation practices from both theoretical and practical perspectives.

The research employed a combination of methods including focus group discussions, surveys, observation, and document analysis. The participants included 30 judges from courts of first instance and appellate courts, 30 prosecutors supervising the execution of sentences, 10 doctors and staff members from the National Center for Mental Health, and 40 officers from the non-custodial sentence enforcement units of the General Executive Agency of Court Decisions, totaling 110 participants. Additionally, observational research was conducted among approximately 130 inmates serving prison sentences. The study also analyzed 101 court decisions on the application of compulsory medical measures, 117 individual enforcement case files of persons undergoing compulsory treatment at the National Center for Mental Health, relevant institutional materials, statistical data, reports from the National Human Rights Commission and courts since 2012, as well as around 200 psychiatric assessment conclusions related to inmates.

The findings identify key challenges in the legal regulation and implementation of compulsory medical measures and provide recommendations aimed at improving the legal framework and enhancing the effectiveness of their application.

It is highlighted that there is an increasing need for specialized research in the

areas of forensic psychiatry, criminal procedure law, the enforcement of court decisions, and procedures for investigating and resolving administrative offenses.

Түлхүүр үг

эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ, эрүүгийн эрх зүй, сэтгэцийн эмгэг, албадан эмчилгээ, шүүхийн шийдвэр гүйцэтгэл

Keywords

compulsory medical measures, criminal law, mental disorder, compulsory treatment, enforcement of court decisions

I. УДИРТГАЛ

Эрүүгийн эрх зүйд гэмт хэрэг үйлдсэн боловч сэтгэцийн эмгэгийн улмаас өөрийн үйлдлийн бодит шинж чанар, нийгмийн аюултай байдлыг ухамсарлах, эсхүл түүнийг удирдах чадваргүй этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхийн оронд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх эрх зүйн зохицуулалт байдаг. Энэ нь нэг талаас нийгмийн аюулгүй байдлыг хангах, нөгөө талаас тухайн этгээдийн эрүүл мэндийг хамгаалах, эмчилгээ, сэтгэл заслын тусламж үзүүлэх зорилготой эрх зүйн онцлог зохицуулалт юм.

Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжид эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрөл, хэрэглэх үндэслэл, шүүхийн шийдвэр гаргах журам зэргийг тодорхой хэмжээнд зохицуулсан боловч практикт хэрэгжүүлэх явцад эрх зүйн зохицуулалтын тодорхой бус байдал, байгууллагуудын уялдаа холбоо, хэрэгжилтийн үр нөлөө зэрэг асуудал тулгарч байна.

Иймээс эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, тулгамдаж буй асуудлыг тодорхойлон, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох санал боловсруулах нь эрүүгийн эрх зүйн онол, практикийн хувьд чухал ач холбогдолтой юм.

II. Хэрэг хариуцах хязгаарлагдмал чадвартай хүнд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх үндэслэлийг бүрдүүлэх

Эрүүгийн хуулийн 6.3, 7.4 дүгээр зүйлийн холбогдох хэсгүүдэд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх үндэслэлийг гэмт хэрэг үйлдсэн хүний “хэрэг хариуцах чадваргүй байдал” гэж хуульчилсан. Мөн хуулийн 6.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Сэтгэцийн эмгэг, оюун ухааны хомсдлын улмаас өөрийн үйлдлийн бодит шинж чанар, аюултай байдлыг ухамсарлах, удирдан жолоодох чадваргүй болсныг хэрэг хариуцах чадваргүйд тооцно” гэж заасан бөгөөд хэрэг хариуцах хязгаарлагдмал чадварын тухай асуудлыг эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх үндэслэлд хамааруулаагүй юм.

Монгол Улс дахь хүн амын сэтгэцийн эрүүл мэндийн өнөөгийн байдал, согтууруулах ундаа, мансууруулах бодисын хэрэглээ, сөрөг үр дагавраас шалтгаалан гэмт хэрэг үйлдэх эрсдэл нэмэгдэж байгаа өнөө үед эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх үндэслэлд хэрэг хариуцах хязгаарлагдмал чадварын тухай асуудлыг хөндөх нь зүй ёсны асуудал билээ.

Хэрэг хариуцах хязгаарлагдмал чадвар¹ гэдэг нь хэрэг хариуцах чадварыг бүрэн үгүйсгэхгүй боловч гэмт хэрэг үйлдсэн этгээдийн өөрийн үйлдлийн бодит мөн чанарыг ухамсарлах, үйлдлээ удирдах, жолоодох чадварт тодорхой хэмжээгээр нөлөөлж байгаа бодит хүчин зүйлээр нөхцөлдсөн сэтгэцийн эмгэг байдал, өөрчлөлт, процесс юм.² Жишээ нь: согтууруулах ундаа, мансууруулах бодис байнга хэрэглэх, бэлгийн гаж дон, зуршил болон бусад сэтгэцийн эмгэг өөрчлөлтүүд үүнд хамаардаг.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн зарим хэсгүүдэд хэрэг хариуцах хязгаарлагдмал чадвартай хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг ялгамжтай тогтоохоор заасан хэдий ч эрүүгийн хариуцлага хүлээлгэх, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх нийтлэг үндэслэл болгон хуульчлаагүй юм.

Зарим эрдэмтдийн хийсэн судалгаагаар хүний амь бие, эрүүл мэнд, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг үйлдэгчдийн 65-70 хувь нь сэтгэцийн ямар нэгэн өөрчлөлттэй байдаг гэжээ.³ Монгол Улсын хэмжээнд хорих ял эдэлж байгаа ялтны сэтгэцийн байдлыг авч үзвэл, сүүлийн 5 жилийн байдлаар ШШГЕГ-ын харьяа 401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлэгт тусламж үйлчилгээ авсан 14709 хоригдлоос сэтгэцийн тулгамдсан асуудалтай хоригдол 7960 буюу нийт эмчлүүлэгчдийн 54.1 хувийг эзэлж байна. Үүнээс 770 буюу 5.2 хувь нь сэтгэцийн эмгэгтэй болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэгт ял шийтгэгдсэн өвчтөн, 7209 буюу 49.0 хувь нь ямар нэгэн байдлаар гадаад шалтгаантай сэтгэл зүйн байдал тогтворгүй болсон өвчтөн үйлчлүүлсэн байна.⁴ Сэтгэцийн эмгэгтэй болон тулгамдсан асуудалтай хоригдол жилд дунджаар 3-4 удаа давтан эмчлүүлдэг” гэж дурджээ.⁵

Хорих ангид явуулсан хэсэгчилсэн судалгаанаас үзэхэд Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйл “Хүнийг алах”, Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт

¹ Хэрэг хариуцах хязгаарлагдмал чадварын тухай үзэл баримтлал 19 дүгээр зуунд сэтгэл судлал, шүүх-сэтгэц гэм судлалын шинжлэх ухааны хөгжлийн үр дүнд эрүүгийн эрх зүйд шинээр орж иржээ.

² С.Жанцан, Монгол Улсын эрүүгийн эрх зүйн онол /Гэмт хэргийн тухай сургааль/. I боть. Уб., 2009, 438 дахь тал.

³ Курс уголовного права. Обшая часть. МГУ. 1999. С.278.

⁴ Б.Гомбо, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Дотоод хэргийн их сургууль, Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, Нийслэлийн прокурорын газар хамтран зохион байгуулсан “Сэтгэцийн эмгэгтэй хүний нийгэмд аюултай үйлдэл: Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэхэд тулгамдсан асуудал” салбар дундын анхдугаар зөвлөгөөнд танилцуулсан илтгэл.Уб., 2021.

⁵ Б.Гомбо, “Хорих ял шийтгүүлсэн хоригдлуудын сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал”. Гэмт явдалтай тэмцэх асуудал сэтгүүл.Уб., 2021.№79. 41 дэх тал.

заасан “бага насны хүүхдийг хүчиндэх” гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн хүмүүсийн 15 орчим хувь нь сэтгэцийн өөрчлөлттэй, өөрийнхөө үйл хөдлөлийг хянах чадваргүй, бие эрхтний хөгжил муу байгаа нь ажиглагдсан бөгөөд хорих ангийн сэтгэл зүйч, нийгмийн ажилтантай хийсэн ярилцлагаас бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэг үйлдсэн хүмүүс ихэвчлэн сэтгэцийн эмгэгтэй байдаг гэжээ.⁶ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 27.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.4 дэх заалтад “Бүх насаар хорих ял оногдуулж болох гэмт хэргийн яллагдагчийн сэтгэцийн байдлыг тодорхойлох” гэж заасан. Түүвэр судалгаанаас үзэхэд “Хүнийг алах” болон “Хүчиндэх гэмт хэрэг” үйлдсэн хүний сэтгэцийн байдлыг тодорхойлоход сэтгэцийн эмгэгтэй, оюун ухааны хомсдолтой боловч хэрэг хариуцах чадвартай гэсэн дүгнэлт цөөнгүй гардаг байна. Энэ тохиолдолд шүүхээс ял оногдуулахын зэрэгцээ эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэсэн тохиолдол байхгүй, хорих ял эдэлж байхад нь сэтгэцийн эмчилгээ хийдэг практик тогтоогүй байна.

Хэрэг хариуцах хязгаарлагдмал чадварыг тайлбарлах өөр нэг хандлага нь гэмт хэрэг үйлдсэн хүний хэрэг хариуцах чадвартай холбон тайлбарлахаас илүүтэйгээр гэмт хэрэг үйлдэх үеийн сэтгэл санааны байдал гэсэн субьектив талын шинжид хамааруулан судалсан онолын бүтээл цөөнгүй байна. Тухайлбал, Г.Гантөмөр гэмт хэрэг үйлдэх үеийн сэтгэл санааны байдал нь гэмт этгээдийн өөрийн нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүй, түүний улмаас учрах хор уршигтаа харьцах сэтгэхүйн харьцааны агуулгад хамаарах бөгөөд гэмт хэргийн бүрэлдэхүүний субьектив талын нэмэгдэл шинж болдог гэж тайлбарлажээ.⁷

Эрүүгийн эрх зүйн эрдэмтэн, судлаачдын дунд гэмт хэрэг үйлдэх үеийн гэмт этгээдийн сэтгэл санааны байдлыг гэмт хэргийн бүрэлдэхүүний субьектив талын агуулгад хамааруулах эсэх асуудал нэг мөр шийдэгдээгүй байна. С.Жанцан, Г.Гантөмөр нар гэмт хэрэг үйлдэх үеийн гэмт этгээдийн сэтгэл санааны байдал /эмоци/-ыг субьектив талын шинж болгон авч үзсэн бол⁸ С.Нарангэрэл түүнийг гэмт хэргийн бүрэлдэхүүний субьектив талын агуулгад хамааруулаагүй байна.⁹ Тухайлбал, Г.Гантөмөр хэрэг хариуцах хязгаарлагдмал чадварыг “...гэмт хэргийн бүрэлдэхүүний субьектив талын агуулгад хамааруулж, түүний нэг нэмэлт шинж болгон авч үзэх нь зүйтэй бөгөөд ийм шаардлага Эрүүгийн хуулийн тусгай ангийн заалтаас бий болж байна”¹⁰ гэж дүгнэсэнтэй бид санал нэгдэж байна.

⁶ ШШГЕГ-ын харьяах 457 дугаар нээлттэй хаалттай, хорих анги, ШШГЕГ-ын харьяа 433 дугаар хаалттай хорих ангийн хоригдол болон алба хаагчдын дунд хийсэн социологийн судалгааны дүгнэлтээс.Уб., 2023.

⁷ Г.Гантөмөр, Гэмт хэргийн бүрэлдэхүүний ерөнхий онол, Уб., 2011. 161 дэх тал.

⁸ С.Жанцан, Монгол Улсын эрүүгийн эрх зүйн онол /Гэмт хэргийн тухай сургааль/. I боть. Уб., 2009. 546-550 дахь тал, Г.Гантөмөр, Гэмт хэргийн бүрэлдэхүүний ерөнхий онол.Уб., 2011. 234-238 дахь тал

⁹ С.Нарангэрэл, Монгол Улсын эрүүгийн эрх зүй. Ерөнхий анги.Уб., 1999. 166-189 дэх тал

¹⁰ Г.Гантөмөр, Гэмт хэргийн бүрэлдэхүүний ерөнхий онол.Уб., 2011. 236 дахь тал.

Эрүүгийн хуулийн 10.2, 10.5, 11.2 дугаар зүйлд заасан 3 гэмт хэргийн хувьд субъектив талын заавал байх үндсэн шинж нь гэмт хэрэг үйлдэх үеийн гэмт этгээдийн сэтгэл санааны байдал байхаар хуульчилжээ. Эрүүгийн хуулийн 10.2 дугаар зүйлд заасан “Санаа сэтгэл хүчтэй цочрон давчдаж хүнийг алах гэмт хэрэг”, мөн хуулийн 11.2 дугаар зүйлд заасан “Санаа сэтгэл хүчтэй цочрон давчдаж хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулах гэмт хэрэг” өөрт нь, ойр дотны хүнд нь хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, хүндээр доромжлогдсон, эрхшээл дарамтад оруулсан хохирогчийн зүй бус үйлдлийн улмаас сэтгэл санааны гэнэтийн цочролд хоромхон зуур автаж, сэтгэцийн хэвийн байдал алдагдсан үед, Эрүүгийн хуулийн 10.5 дугаар зүйлд заасан “Эх нярай хүүхдээ алах” гэмт хэрэг эх нь сэтгэл санааны гүнзгий хямралтай байх үед үйлдэгдсэн байхаар тус тус заажээ.¹¹

Энэ тохиолдолд л гэмт хэрэг үйлдэх үеийн гэмт этгээдийн сэтгэл санааны байдал нь дээрх 3 гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектив талын заавал байх үндсэн шинж болох ба гэмт хэрэг үйлдэх үеийн сэтгэл санааны байдлаар нь хүнийг алах (Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйл), хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах (Эрүүгийн хуулийн 11.1 дүгээр зүйл) зэрэг төсөөтэй гэмт хэргээс ялгаж, зүйлчилнэ.

Гэмт хэрэг үйлдэх үеийн гэмт этгээдийн сэтгэл санааны байдал нь Эрүүгийн хуулийн тусгай ангид тодорхой гэмт хэргийн бүрэлдэхүүнд хууль тогтоогчоос урьдчилан зааж өгөөгүй тохиолдолд субъектив талын нэмэгдэл шинж болох ба энэ нөхцөлд гэмт хэргийн бүрэлдэхүүнд нөлөөлөхгүй, зөвхөн гэмт хэрэг үйлдсэн этгээдэд шүүхээс ялыг ялгамжтай оногдуулахад харгалзан үзэх нөхцөл байдал болдог нь дүгнэгдэж байна.

Харьцуулсан судалгаанаас үзэхэд хэрэг хариуцах хязгаарлагдмал чадварын тухай ойлголтыг зөвхөн гэмт хэрэг үйлдэх үеийн гэмт этгээдийн сэтгэл хөдлөлийн байдлаас өргөн хүрээнд авч үзжээ. Тухайлбал, ОХУ, БНКУ, БНФУ, ХБНГУ, Япон, Испани зэрэг орнуудын эрүүгийн хуульд хэрэг хариуцах хязгаарлагдмал чадварыг хуульчилж өгсөн байна. Харин АНУ, Англид энэ талаар хуульчилж өгөөгүй боловч шүүхийн практикт аль хэдийнээс хэрэгжиж иржээ.¹²

ОХУ-ын Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 22 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Гэмт хэрэг үйлдэх үедээ сэтгэцийн эмгэгийн улмаас өөрийн үйлдлийн бодит шинж чанар түүний нийгмийн хор аюулыг бүрэн хэмжээгээр ухамсарлаж буюу удирдаж чадахгүй этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Хэрэг хариуцах чадвартай байдлыг үгүйсгэхгүй сэтгэцийн өөрчлөлттэй байдлыг шүүх ял оногдуулахдаа болон эмнэлгийн шинж чанартай албадлагын арга

¹¹ Г.Гантөмөр, Гэмт хэргийн бүрэлдэхүүний ерөнхий онол.Уб., 2011. 237 дахь тал.

¹² Уголовное право России. М., 1999. С.161.

хэмжээ хэрэглэхдээ харгалзан үзнэ”¹³ гэж ерөнхий нөхцөл байдлыг заажээ. Тус хуулийн 97 дугаар зүйлд Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх үндэслэлийн В-д “Хэрэг хариуцах чадвартай сэтгэцийн өвчтэй этгээд гэмт хэрэг үйлдсэн”, Д-д “Арван дөрвөн насанд хүрээгүй хүүхдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдсэн арван найман нас хүрсэн, эрүүл мэндийг үгүйсгэхгүй бэлгийн дур хүслийн эмгэг (педофили) өвчтэй” хүн гэж нарийвчлан заасан бол БНКУ-ын Эрүүгийн хуульд үүнтэй төстэй зохицуулалтыг тусгажээ. Харин БНКиру-ын Эрүүгийн хуулийн 20 дугаар зүйлд “Эрүүл боловч тодорхой оюуны саатлын улмаас өөрийн үйлдлийн бодит мөн чанарыг ойлгож, ухамсарлах чадваргүй байсан хүнийг хэрэг хариуцах чадваргүйд тооцно. Уг нөхцөл байдал нь гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага оногдуулахад харгалзан үзэх үндэслэл болох бөгөөд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх шалгуур болно”¹⁴ гэж заасан нь хэрэг хариуцах хязгаарлагдмал чадварын агуулгыг тусгажээ.

Францын Эрүүгийн хууль¹⁵-ийн 122.1 дүгээр зүйлд “...Гэмт хэрэг үйлдэх үедээ өөрийн үйлдлийг ойлгож ухамсарлах, эсхүл удирдах чадварыг бууруулсан сэтгэцийн өөрчлөлт, эмгэгтэй байсан этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.¹⁶ Гэхдээ шүүх энэ нөхцөл байдлыг ял оноох, түүнийг эдлүүлэх дэглэм журмыг тогтоохдоо харгалзана...” гэж заасан бол Герман улсын Эрүүгийн хуулийн 21 дүгээр зүйлд “...Хэрэв гэмт хэрэг үйлдэх үед энэ хуулийн 20 дугаар зүйлд заасан шалтгааны улмаас гэмт этгээдийн өөрийн үйлдлийн хууль зөрчсөнийг ойлгох чадвар буурсан бол 49 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу ялыг хөнгөрүүлж болно...”¹⁷ гэж, Испанийн эрүүгийн хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “...Гэмт хэрэг үйлдэх үедээ түр зуурын сэтгэцийн сааталд орсон боловч тухайн хууль бус үйлдлийн үр дагаврыг урьдаас ойлгох чадвартай байсан хүнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөхгүй” гэж хэрэг хариуцах хязгаарлагдмал чадварыг хуульчилжээ.¹⁸

Бид хэрэг хариуцах хязгаарлагдмал чадвар, түүний шалгуурыг эрүүгийн хуульд тусгаж, зарим төрлийн гэмт хэрэгт тухайлбал, хүнийг алах, бага насны хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл, мансууруулах бодис сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой хэрэг үйлдсэн хэрэг хариуцах чадвартай боловч сэтгэцийн эмгэгтэй хүмүүст ял оногдуулахын зэрэгцээ албадан эмчлэх арга хэмжээг хэрэглэх үндэслэлийг хуульчлах шаардлагатай гэж үзэж байна.

Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг гэм буруутай хүнд ял эдэлж

¹³ Уголовный кодекс РД. М., 2000.С.7.

¹⁴ <https://cis-legislation.com/Criminal code of the Kyrgyz Republic>

¹⁵ <https://eige.europa.eu/gender-based-violence/resources/france/french-penal-code-general-criminal-law>

¹⁶ Г.Гантөмөр, Гэмт хэргийн бүрэлдэхүүний ерөнхий онол.Уб., 2011. 161 дэх тал.

¹⁷ Уголовный кодекс Испаний. 2002.

¹⁸ Уголовный кодекс Испаний. 1998. С.2-3.

байхад болон эдэлсний дараа тодорхой хугацаанд үргэлжлүүлэн хяналттайгаар хэрэгжүүлэх нь дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, сэтгэцийн эмгэгээс шалтгаалсан гэмт зан байдлыг засах зэрэг эерэг үр нөлөөтэй бөгөөд эрүүгийн хариуцлагын зорилгыг бүрэн хангах ач холбогдолтой юм. Хэрэг хариуцах хязгаарлагдмал чадварыг хуульчлах нь гэмт хэрэг үйлдсэн хүнийг ял завших боломжийг гаргуулахгүй байх үүднээс шүүх сэтгэц эмгэг судлалын шинжилгээг дагнан хийх хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, холбогдох аргачлалыг боловсронгуй болгох шаардлагатай.

III. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрөл, дэглэм, хугацааг хуулиар тодорхойлох

Эрүүгийн хуулийн 6.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүх гэмт хэрэг үйлдсэн хүнд энэ хуулийн ерөнхий ангид заасан үндэслэл, журмын дагуу тусгай ангид заасан төрөл, хэмжээний дотор эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ” гэж, мөн хуулийн 7.4 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрөл, дэглэм, хугацааг шинжээчийн дүгнэлтийг харгалзан шүүх тогтооно” гэж, ЭХХШТХ-ийн 19.3 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрөл, хугацааг шинжээчийн дүгнэлт, прокурорын саналыг үндэслэн шүүх тогтооно.”¹⁹, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 190 дүгээр зүйлийн 190.1 дэх хэсэгт “гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхээр шийдвэрлэсэн бол шүүх албадлагын арга хэмжээг ямар төрлийн эмнэлэгт хэрэгжүүлэхийг тогтоолдоо заана.” гэж тус тус заасан нь хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийг хамгаалсан зохицуулалт хэдий ч шүүхийн практикт хэрэглэхэд хүндрэлтэй асуудал гарсаар байна.

Хугацаа тогтоох: Судалгаанаас үзэхэд, цөөн тохиолдолд шинжээч эмч шүүхийн хэлэлцүүлэгт оролцож эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх хугацааны талаар санал гаргасан байх ба ихэнх тохиолдолд шүүх өөрийн санаачилгаар албадан эмчлэх хугацааг тогтоосон бол зарим шүүхийн шийдвэрт албадан эмчлэх хугацааг тогтоогоогүй байна. 2022 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Шүүхийн сэтгэц эмгэг судлалын клиникт 39 хүнд шүүхийн шийдвэрийн дагуу эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэн албадан эмчилж байгаа хэдий ч дээрх 39 хүний 13 буюу 33.3 хувьд нь ямар хугацаагаар албадан эмчлэхийг шүүх шийдвэртээ тусгаагүй бол 26 хүнд 1 сараас 8 жил хүртэл хугацаагаар уг арга хэмжээг хэрэглэхээр шүүхийн шийдвэрт тогтоожээ.

¹⁹ //Төрийн мэдээлэл эмхэтгэл.УБ., 2017. №23.

Тохиолдол-1. Шүүгдэгч О нь сэтгэцийн шизоффе́ктив эмгэгийн холимог хэлбэр, дэмийрэл өвчтэй байх үедээ 2017.11.14-ний өдөр Дархан-Уул аймгийн Дархан сумын 8 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах Сэтгэцийн эмнэлэгт ажил үүргээ гүйцэтгэж байсан сувилагч О-г шалтгаангүйгээр цохиж эрүүл мэндэд нь хөнгөн хохирол учруулсан гэмт хэрэг үйлдсэн. Шүүхээс О-д эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд 2 сарын хугацаагаар эмчлүүлэхээр шийдвэрлэсэн.²⁰

Түүнчлэн шүүхийн шийдвэрээр тогтоосон хугацаанд сэтгэцийн байдал нь засрал сайжрал олоогүй, эдгэрээгүй бол тухайн этгээдэд хэрэглэсэн эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний хугацааг хэрхэн тогтоож, ямар хугацаагаар сунгах нь тодорхойгүй байна. Тухайлбал: шүүхээс хугацааг тогтоогоогүй 13 хүнийг засрал сайжрал олоогүй үндэслэлээр 5-20 жилийн хугацаагаар тус байгууллагад үргэлжлүүлэн албадан эмчилж байна²¹.

Эрүүгийн хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний хугацааг шинжээчийн дүгнэлтийг харгалзан шүүх тогтооно гэж ерөнхий байдлаар хуульчилсан нь хууль ёсны байх зарчмыг зөрчиж байгаа ба хүний эрхийг хамгаалах, шүүхийн шийдвэрийг тодорхой хугацаанд хянах үр нөлөөтэй тогтолцоо биш юм. Өөрөөр хэлбэл, хүний эрхийг хязгаарлаж, тодорхой орчинд хяналттайгаар байлгах хугацааг зөвхөн хуулиар нарийвчлан тогтоох, тогтоох боломжгүй бол мэргэжлийн байгууллагын (эмнэлгийн) дүгнэлтээр тухай бүр хянан хэлэлцэж байх ёстой.

Гадаад орны туршлага, хууль тогтоомжийн харьцуулсан судалгаанаас үзэхэд эрүүгийн хуульд албадан эмчлэх арга хэмжээний төрлөөс хамаарч хугацааг харилцан адилгүй тогтоосон практик цөөнгүй байна. ХБНГУ-ын Эрүүгийн хуульд албадан эмчлэх арга хэмжээний агуулгыг багтаасан олон төрлийг хуульчилсан бөгөөд тус бүрд тодорхой хугацаа заасан. Тухайлбал, Эрүүгийн хуулийн 61 дүгээр зүйлд 1/ Сэтгэцийн эмнэлэгт хэвтүүлэх 2/ Донтох өвчнийг эмчлэх эмнэлэгт хэвтүүлэх; 3/ Хамгаалах зорилгоор цагдан хорих; 4/ Зан үйлийн хяналт тогтоох гэжээ. Тус хуулийн 67d дүгээр зүйлд яллагдагчийг эмчлэх зорилгоор цагдан хорих арга хэмжээ авахаар зохицуулсан нь манай улсад нэвтрүүлэхүйц практик юм. Тус зүйлийн 1 дэх хэсэгт “Сэтгэцийн эмгэгтэй хүний аюулгүй байдлыг хангах, эмчлэх зорилгоор хэрэгжүүлсэн цагдан хорих арга хэмжээний хугацаа хоёр жилээс хэтэрч болохгүй, мөн зүйлийн 6 дахь хэсэгт зайлшгүй шаардлагаар зургаан жил хүртэл хугацаанд цагдан хоригдсон

²⁰ Шийтгэх тогтоол. Дархан-Уул аймаг дахь СДЭХАШШ. 2017.12.28. №02., Шийтгэх тогтоол. Говь-Алтай аймаг дахь СДШ. 2018.8.02. №76., Шийтгэх тогтоол. Баянхонгор аймаг дахь СДЭХАШШ. 2018.6.26. №147.

²¹ Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 1/564 дүгээр албан бичиг.

этгээдийн нөхцөл байдлыг харахад цаашид сэтгэл санаа болон бие махбодын ноцтой хохирол бүхий буюу хохирогчид сэтгэл санааны болон бие махбодын ноцтой хохирол учруулах гэмт хэрэг үйлдэх шинжгүй, аюулгүй байгаа тохиолдолд арга хэмжээг үргэлжлүүлэх нь зохимжгүй” гэж зааснаас дүгнэхэд албадан эмчлэх арга хэмжээний хугацаа дээд тал нь зургаан жил байх агуулга харагдаж байна. Мөн тус хуулийн 67e дүгээр зүйлд сэтгэцийн шинжилгээ хийх зорилгоор сэтгэцийн эмнэлэгт байлгах хугацаа нэг жил, хамгаалах зорилгоор цагдан хорих газарт нэг жил, сэтгэцийн эмнэлэгт хэвтүүлэх арга хэмжээ арван жилийн хугацаатай байхаар тогтоож, уг арга хэмжээ дууссан бол есөн сар тутамд хянан хэлэлцэнэ гэж заажээ. Түүнчлэн хэрэг хариуцах чадваргүй, хязгаарлагдмал чадамжтай хүмүүсийн хувьд албадан эмчлэх арга хэмжээний үргэлжлэх дээд хэмжээг тодорхой хугацаагүйгээр сунгаж болох ч үйлдсэн гэмт хэрэгт оногдуулах хорих ялын дээд хэмжээнээс хэтэрч болохгүй гэсэн агуулгыг тусгажээ. Мөн гэмт хэрэг үйлдсэн хүнд зан үйлийн хяналт тогтоох гэсэн албадан эмчлэх арга хэмжээний төрлийг хуульчилсан бөгөөд ял эдэлж дууссан сэтгэцийн эмгэгтэй, зайлшгүй эмчлүүлэх шаардлагатай этгээдэд 2-5 жилийн хугацаагаар тогтоохоор тус тус заасан нь албадан эмчлэх арга хэмжээний төрөл, түүнийг тогтоосон явдал юм.

Бүгд Найрамдах Грек Улсын Эрүүгийн хуульд албадан эмчлэх арга хэмжээг тухайн төрлийн гэмт хэрэгт оногдуулах ялын дээд ялын 50 хувиас илүүгүй хугацаагаар, Эстон Улсын эрүүгийн хуульд эмчлэх хугацаа 18 сараас багагүй, 3 жилээс ихгүй байна гэж тус тус заажээ.


Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хүний эрхийн зарчим хэм хэмжээнд нийцүүлэх нэг шаардлага нь уг арга хэмжээний төрлийг тодорхойлж, хэрэглэх хугацааг сэтгэцийн өвчний онцлогт тохируулан тогтоох, мөрдөн байцаалтын шатанд тухайн этгээдийг сэтгэцийн байдлыг ажиглах, аюулгүй байдлыг хангах үүднээс тусгаарлах арга хэмжээг авах зохицуулалтыг хуульчлах шаардлагатай.

Тогтоосон хугацааг хянан хэлэлцэх: Шүүх сэтгэц эмгэг судлалын практикт сэтгэцийн өвчний улмаас хэрэг хариуцах чадваргүй болсон этгээдийн сэтгэцийн эмгэг хэзээ засарч сайжрахыг шинжээчийн дүгнэлтээр урьдчилан тогтоох боломжгүй гэж үздэг. Харин албадан эмчилгээний хугацааг эмчлэгч эмч тухайн өвчний эмчилгээний тактик, үр дүн, оношилгоо эмчилгээний стандарт, удирдамж, өвчтөний биеийн байдлаас хамаарч тогтоох нь түгээмэл юм. Ихэнх улсад 6 сар тутам шинжээчийн дүгнэлтийг үндэслэн албадан эмчилгээг үргэлжлүүлэх, дуусгавар болгох, хугацаа сунгах эсэхийг шүүх хянан шийдвэрлэдэг байна. Тухайлбал: ОХУ, БНКУ, БНКиру, Япон Улс, Бельгийн Хаант Улс, Израил Улсад 6 сар тутам, Грек Улсад 2 жил тутамд шинжээчийн дүгнэлтийг үндэслэн эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг үргэлжлүүлэх, сунгах, зогсоох асуудлыг шийдвэрлэх зохицуулалтыг эрүүгийн хуульд тусгажээ.

Монгол Улсын эрүүгийн хуульд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэсэн тохиолдолд тогтоосон хугацааг хянах зохицуулалтыг хуульчлаагүй юм. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 190 дүгээр зүйлийн 190.10 дахь хэсэгт эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, түүнд хяналт тавих журмыг хууль зүйн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална” гэж заасан бөгөөд уг журамд эмнэлгийн чанартай арга хэмжээний хугацааг хянах зохицуулалтыг тусгасан. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайд нарын 2017 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн А-240/А369 дугаартай “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, түүнд хяналт тавих журам”-ын 4.1-д “албадан эмчлүүлэгчийн сэтгэцийн байдлыг магадлан шинжилгээний комисс нь хагас жилд нэг удаа өвчний явцын талаар хэлэлцэж дүгнэлт гаргана. Хэрэв шаардлагатай тохиолдолд аль ч үед магадлан шинжилгээний Комиссыг хуралдуулж болно” гэж заажээ.

Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүний сэтгэцийн байдал, өвчний талаар дүгнэлт гаргах хугацааг эрх бүхий албан тушаалтны баталсан журмаар зохицуулж байгаа нь хүний эрхийг хязгаарлахад тавигдах шаардлагад нийцэхгүй гэж дүгнэж байна. Тиймээс эрүүгийн хуулийн 7.4 дүгээр зүйлийн холбогдох хэсэгт эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүний сэтгэцийн эмгэгийн талаар 1 жил тутам дүгнэлт гаргах талаар холбогдох зохицуулалтыг тусгах нь зүйтэй.

Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг зогсоох: 2015 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 7.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй байсны улмаас эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүний хэрэг хариуцах чадваргүй байдал арилсан бол шүүхээс уг албадлагын арга хэмжээг зогсоох тухай шийдвэр гаргана.” гэж, мөн 5 дахь хэсэгт “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүн хөөн хэлэлцэх хугацаанд эмчлэгдсэн, хэрэг хариуцах чадваргүй байдал нь арилсан бол шүүхээс түүнд оногдуулсан ялаас эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан нэг хоногийг хорих ялын нэг хоногоор тооцон хасаж үлдсэн ялыг эдлүүлнэ.” гэж тус тус заасан.



Тохиолдол-2. Шүүгдэгч Б нь 2020.01.12-13-нд шилжих шөнө өөрийн гэртээ гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн болох 18 насанд хүрээгүй 16 нас 9 сартай охин У-ийн хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэн хүчиндсэн гэмт хэрэг үйлдсэн. Шүүхээс²² түүнд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Шүүх сэтгэц эмгэг судлалын клиникийн тусгай тасагт 1 жил 6 сарын хугацаагаар сэтгэл заслын эмчилгээ хийлгэх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авч шийдвэрлэсэн.

Улмаар Б-ийн сэтгэцийн байдал албадан эмчилгээний үр дүнд тогтвортой, засрал сайжралын байдалд орсон, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг цаашид үргэлжлүүлэх шаардлагагүй болсон нь Шүүх сэтгэц эмгэг судлалын шинжээч эмч нарын дүгнэлтээр тогтоогдсон тул уг арга хэмжээг зогсоож, ял оногдуулах үндэслэлтэй байна гэж шүүх дүгнэж шүүгдэгч Б-д Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг журамлан тусгай ангийн 12.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1, 2.3 дахь заалтад зааснаар 2 жилийн хугацаагаар хорих ял шийтгэж шийдвэрлэжээ.²³

Гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадвартай байсан боловч хэрэг шалган шийдвэрлэх үед хэрэг хариуцах чадваргүй болсны улмаас эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүний хэрэг хариуцах чадваргүй байдал арилсан бол шүүхээс уг албадлагын арга хэмжээг зогсоож ял оногдуулах асуудлыг шийдвэрлэнэ гэсэн заалтыг хэрэглэхэд бэрхшээл үүсч байна.

Тухайлбал, дээрх албадлагын арга хэмжээг зогсоох асуудлыг тогтоол биелүүлж байгаа газрын шүүх харьяалан шийдвэрлэх боловч албадлагын арга хэмжээ авагдсан этгээдийн үйлдсэн гэмт хэргийг шийдвэрлэх асуудлыг албадан эмчлэх арга хэмжээг хэрэгжүүлж байгаа газрын шүүх хамтад нь нэг дор шийдвэрлэх боломжгүй тул энэ талаар зохицуулалтыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуульд нэмж тусгах шаардлага бий болж байна.

Гэмт хэрэг үйлдэж эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүний хэрэг хариуцах чадваргүй байдал арилаагүй боловч эмчилгээний үр дүнд сэтгэцийн байдал засарч сайжирсан бол уг арга хэмжээ хэрэглэхийг зогсоож асран хамгаалагчийн асрамжид асрамжлуулахаар өгөх хуулийг төсөөтэй хэрэглэн шийдвэрлэж байна.

²² Шийтгэх тогтоол. Дорнод аймаг дахь СДЭХАШШ. 2020.05.25. №155.

²³ Шийтгэх тогтоол. Дорнод аймаг дахь СДЭХАШШ. 2020.11.10. №155А.

²⁴ Шийтгэх тогтоол. Дархан-Уул аймаг дахь СДЭХАШШ. 2017.12.28. №02., Шийтгэх тогтоол. Говь-Алтай аймаг дахь СДШ. 2018.08.02. №76., Шийтгэх тогтоол. Баянхонгор аймаг дахь СДЭХАШШ. 2018.06.26. №147.

²⁵ Шүүгчийн захирамж. БЗДЭХАШШ. 2019.11.29. №361.

Тохиолдол-3. Шүүгдэгч А нь 2018.3.3-ны өдөр төрсөн эцэг Ө-г хутгалж, эрүүл мэндэд нь хөнгөн хохирол учруулах гэмт хэрэг үйлдсэн. Шүүхээс түүнд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж, Сэтгэцийн эмгэг судлалын тусгай тасагт 1 жилийн хугацаагаар эмчлүүлэхээр шийдвэрлэсэн.³² Прокуророос А-ийн өвчний байдал болон эрүүл мэндийн байдал нь засарч сайжирсан, сэтгэцийн байдал албадан эмчилгээний үр дүнд засралын байдалд орсон болох нь шинжээчийн дүгнэлтээр тогтоогдсон, уг арга хэмжээг цаашид үргэлжлүүлэх шаардлагагүй гэсэн үндэслэлээр эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг зогсоох тухай дүгнэлт үйлдэн ирүүлснийг шүүх хүлээн авч, А-д авсан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг зогсоож, түүнийг асран хамгаалагч, эх Ц-д халамжлуулах, А-г сэтгэцийн эрүүл мэндийн байгууллагын хяналтад байлгахыг Ц-д даалгаж шийдвэрлэсэн.³³

Дээрх тохиолдлоос дүгнэхэд шүүх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг зогсоож, асран хамгаалагчид шилжүүлэн өгчээ. Энэхүү шийдвэр нь Эрүүгийн хуулийн 1.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэхгүй” байх гэсэн зарчмыг зөрчсөн бөгөөд ийм тохиолдол шүүхийн практикт цөөнгүй байгааг анхаарах нь зүйтэй. Иймд хууль тогтоомжийг нэг мөр хэрэглэх үүднээс эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг зогсоох эрх зүйн үндэслэлийг боловсронгуй болгох шаардлага тулгарч байна.

Учир нь Эрүүгийн хуулийн 7.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй байсны улмаас эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүний хэрэг хариуцах чадваргүй байдал арилсан бол шүүхээс уг албадлагын арга хэмжээг зогсоох тухай шийдвэр гаргана” гэж заажээ.

Дээр дурдсан тохиолдолд шүүх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүний хэрэг хариуцах чадваргүй байдал бүрэн арилаагүй байхад уг арга хэмжээг зогсоож шийдвэрлэжээ. Хэрэг хариуцах чадваргүй байдал арилах тухай ойлголтыг манай улсын зарим хуульч эрдэмтдийн тодорхойлж байснаас үзэхэд тухайн хүний сэтгэцийн эмгэг эдгэрсэн гэсэн агуулгаар тайлбарлажээ. Тухайлбал, Г.Гантөмөр нар “Сэтгэцийн эмгэг, оюун ухааны хомсдол эдгэрсэн гэж өвчтөний сэтгэцийн байдал тогтвортой сайжирч, өөрийн үйлдэл, эс үйлдэхүй, түүнээс үүсэх үр дагаврыг зөвөөр ойлгох, ухамсарлах, үйл ажиллагаагаа удирдан жолоодох чадвартай болсон байхыг хэлнэ”²⁶ гэжээ. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 19.3 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх явцад прокурор хяналт тавьж, уг арга хэмжээг зогсоох, хугацааг

²⁶ Г.Гантөмөр нар. “Эрүүгийн эрх зүй”, ерөнхий анги, сурах бичиг, УБ., 2020, 428 дахь тал.

сунгах, тухайн шүүгдэгч эдгэрсэн нь эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдвол эрүүгийн хариуцлага хүлээлгэх эсэхийг шүүхээр шийдвэрлүүлнэ.” гэж заасан.

Харин Анагаахын шинжлэх ухааны үүднээс хэрэг хариуцах чадваргүй байдлыг үүсгэдэг зарим төрлийн сэтгэцийн эмгэгүүд арилах боломжгүй гэж үздэг. Тухайлбал, Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний үр нөлөөг сайжруулах, холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар СЭМҮТ-ийн Удирдлагын зөвлөлөөс ХЗДХЯ-д хүргүүлсэн саналд “Оюуны хомсдол, шизофрени зэрэг эмгэгийн үед хэрэг хариуцах чадваргүй байдал арилахгүй (эдгэхгүй, төгс эмчлэгдэхгүй) учраас шүүхээс уг албадлагын арга хэмжээг зогсоох тухай шийдвэр гарах боломжгүй нөхцөл байдал үүсч байгааг дурджээ.²⁷

Шүүх дээр дурдсан тохиолдлыг шийдвэрлэхдээ Эрүүгийн хуулийн 7.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан “Гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй байсан хүний сэтгэцийн байдал нь өөртөө, бусдад аюул учруулахааргүй бол шүүх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхгүйгээр сэтгэцийн эрүүл мэндийн холбогдох байгууллагад эмчлүүлэх, асран хамгаалагчид халамжлуулахаар шилжүүлж болно” гэсэн заалтыг хэрэглэсэн нь мөн эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэж буй явдал юм. Энэ зохицуулалтын агуулга нь хуульд заасан үндэслэл байгаа тохиолдолд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэхгүйгээр асран хамгаалагчид нь халамжлуулахаар шилжүүлэхэд чиглэсэн зохицуулалт байхад уг арга хэмжээг зогсоох, асран хамгаалагчид халамжлуулахаар өгөхтэй холбоотой харилцаанд хэрэглэсэн нь хууль буруу хэрэглэж буй явдал юм.

Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг зогсоох үндэслэлийг Эрүүгийн хуульд “хэрэг хариуцах чадваргүй байдал арилсан” гэж, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд “эдгэрсэн” гэсэн нэр томъёогоор ялгаатай хуульчилжээ. Бидний үзэж байгаагаар хэрэг хариуцах чадваргүй байдал арилсан гэдэг ойлголтыг сэтгэцийн эмгэг бүрэн эдгэрсэн гэх агуулгаар тайлбарлах боломжтой гэж үзэж байна. Харин зарим төрлийн сэтгэцийн эмгэг засрал сайжрал авдаг хэдий ч хэрэг хариуцах чадваргүй хэвээр байдаг. Тийм өвчин эмгэгтэй хүнд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх эсэх, засрал сайжрал олж өөртөө болон бусдад аюул учруулахааргүй болсон тохиолдолд уг арга хэмжээг зогсоох эрх зүйн орчинг бүрдүүлэх нь зүйтэй.

Төрөл, дэглэм: Монгол Улсын хэмжээнд шүүхээс “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ” хэрэглэхээр шийдвэрлэсэн хүнийг Эрүүл мэндийн яамны харьяа Сэтгэцийн эрүүл мэндийн Үндэсний төвд албадан эмчилж байгаа бөгөөд 2015 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 7.4 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт “эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний

²⁷ СЭМҮТ-ийн Ерөнхий захирлын албан бичиг.

төрөл, дэглэмийг... шинжээчийн дүгнэлтийг харгалзан шүүх тогтооно” гэж, мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 190 дүгээр зүйлийн 190.1 дэх хэсэгт “гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхээр шийдвэрлэсэн бол шүүх албадлагын арга хэмжээг ямар төрлийн эмнэлэгт хэрэгжүүлэхийг тогтоолдоо заана”²⁸ гэж хуульчилсан нь уг арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллага, алба хаагчдын аюулгүй байдал, хөдөлмөрийн нөхцөл байдлыг хүндрүүлж байна.

Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэхдээ гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэмт этгээдийн хувийн байдлыг харгалзан ямар төрлийн эмнэлэгт эмчлэх талаарх зохицуулалт хуульчлагдаагүйгээс анхан шатны шүүх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхдээ түүнийг хэрэгжүүлэх эмнэлгийн төрлийг хуульд заагаагүй нэр томьёо хэрэглэн тогтоох, гэмт хэрэг үйлдсэн хэрэг хариуцах чадваргүй хүний хувийн байдалд тохироогүй тасагт хэвтүүлэн эмчлэх зэрэг доголдол үүсэж, хуулийг төсөөтэй хэрэглэх явдал гарч байна. Тухайлбал, албадан эмчлэх байгууллагыг “Донтох эмгэгийн клиник”, “Сэтгэцийн эмгэг судлалын хуулийн тасгийн энгийн зэрэглэлийн тасаг”, “Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн энгийн дэглэмд”, “Сэтгэцийн эрүүл мэндийн байгууллагын энгийн тасаг”, “Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Сэтгэц эмгэг судлалын ердийн эмнэлэг”²⁹ гэж тус тус заажээ. Түүнчлэн шүүх хүнд гэмт хэрэг үйлдсэн хүнийг ердийн тасагт, хөнгөн гэмт хэрэг үйлдсэн этгээдийг тусгай тасагт албадан эмчлэхээр тогтоосон байх бөгөөд ямар үндэслэлээр ердийн болон тусгай тасагт албадан эмчлэхээр шийдвэрлэснийг шүүхийн шийдвэрт тусгаагүй байх жишээтэй.

Тохиолдол-4. Шүүгдэгч Н нь үлдэц шизофрени, бие хүний шизофрени илэрхий эмгэг байдал өвчтэй байх үедээ буюу 2001.09.19-ний өдөр СЭК эмнэлгийн хурцын тасагт хэвтэж эмчлүүлж байхдаа өвчтөн Д-ийн толгой руу орны төмрөөр цохиж санаатай алсан гэмт хэрэг үйлдсэн. Шүүх Н-ыг эрүүгийн хариуцлагаас чөлөөлж, сэтгэл мэдрэлийн ердийн эмнэлэгт байлгах эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхээр³⁰,

²⁸ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2017 он, www.legalinfo.mn

²⁹ Шийтгэх тогтоол. Өвөрхангай аймаг дахь. 2017.11.22. №152., Шийтгэх тогтоол. Мөн шүүхийн 2017.12.11. №167., Шийтгэх тогтоол. Орхон аймаг дахь СДЭХАШШ. 2021.01.22. №31., Шийтгэх тогтоол. Ховд аймаг дахь СДЭХАШШ. 2019.07.22. №124., Шүүгчийн захирамж. ХУДЭХАШШ. 2018.10.17. №1339.

³⁰ Шүүхийн тогтоол. Нийслэлийн шүүх. 2002.3.01. №14.

Тохиолдол-5. Мөн шүүгдэгч Б нь солиорлын шинж тэмдэгтэй гүнзгий сэтгэл гутрал бүхий хоёр туйлт сэтгэл цочирдох эмгэг өвчтэй байх үедээ 2006.2.22-ны өдөр төрсөн эцэг Ю-г цээж болон ар нуруу, зүүн бугалгад нь тус тус хутгалж, хоолойг нь огтолж онц харгис хэрцгийгээр алсан гэмт хэрэг үйлдсэн. Шүүх Б-г эрүүгийн хариуцлагаас чөлөөлж, сэтгэц эмгэг судлалын тусгай тасагт эмчлүүлэх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхээр³¹,

Тохиолдол-6. Мөн шүүгдэгч Б нь шизофренийн хий үзэгдэл дэмийрлийн хам шинж өвчтэй байх үедээ эгч М-г хутгалж зэвсэг хэрэглэн танхайрах гэмт хэрэг үйлдсэн. Шүүх 2008 оны 7 сарын 03-ны өдөр Б-г эрүүгийн хариуцлагаас чөлөөлж, сэтгэц эмгэг судлалын тусгай эмнэлэгт эмчлүүлэх албадлагын арга хэмжээ авахаар³² тус тус шийдвэрлэжээ.

Тохиолдол-7. Шүүгдэгч Ч нь согтуурсан үедээ 2018.2.12-ны өдөр иргэн Б-г толгойн тус газар нь модоор цохиж, эрүүл мэндэд нь хөнгөн хохирол учруулах гэмт хэрэг үйлдсэн. Шүүхээс түүнд сэтгэл заслын эмчилгээ хийлгэх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг “Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн сэтгэцийн эмгэг судлалын хуулийн тасгийн энгийн зэрэглэлтэй тасаг” 6 сарын хугацаагаар хэрэглэхээр шийдвэрлэсэн.³³

Монгол Улсад Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг тухайн этгээдийн сэтгэцийн байдал, үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээг харгалзан сэтгэцийн эмгэг судлалын эмнэлгийн төрлийг тогтоож байсан сайн туршлага бий. Тухайлбал, 2002 оны Эрүүгийн хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэгт “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ оногдуулах шаардлагатай гэж шүүх үзвэл тухайн этгээдийн сэтгэцийн байдал, үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээг харгалзан албадлагын арга хэмжээний төрлийг тогтооно” гэж, мөн зүйлийн 2, 3 дахь хэсэгт эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрлийг сэтгэцийн эмгэг судлалын ердийн болон тусгай эмнэлэгт байлгахаар хуульчилж байсныг дурдаж болно.

Гадаад орны туршлагаас үзэхэд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрлийг шинжээчийн дүгнэлтийг үндэслэн шүүх тогтоодог зохицуулалт бараг байхгүй байгааг анхаарч засах шаардлагатай. ОХУ-д 1/ Эмнэлгийн албадан хяналтад эсхүл сэтгэл мэдрэлийн эмчийн хяналтад байлгах; 2/ Сэтгэцийн эмгэг судлалын ердийн эмнэлэгт байлгах 3/ Сэтгэцийн

³¹ Шүүхийн тогтоол. Баянзүрх дүүргийн шүүх. 2006.04.10. №158.

³² Шүүхийн тогтоол. Баянзүрх дүүргийн шүүх. 2008.07.03. №341.

³³ Шийтгэх тогтоол. Өвөрхангай аймаг дахь СДЭХАШШ. 2018.05.30. №87.

эмгэг судлалын тусгай эмнэлэгт байлгах 4/ Сэтгэцийн эмгэг судлалын хүч нэмэгдүүлсэн хяналттай эмнэлэгт байлгах гэсэн дөрвөн төрлийг тодорхойлсон бол БНКУ-д дээр дурдсан төрлөөс гадна “Бэлгийн хүчирхийлэл үйлдэх донтой этгээдэд химийн албадан эмчилгээ хийх” гэсэн төрлийг тусгайлан заажээ. БНКриУ-д 1) сэтгэцийн эмчийн хяналт дор амбулаториор албадан эмчлэх; 2) сэтгэцийн эмнэлэгт ердийн хяналт дор эмчлэх; 3) сэтгэцийн эмнэлэгт эрчимжүүлсэн хяналт дор эмчлэх; 4) сэтгэцийн эмнэлэгт онцгой хяналт дор эмчлэх төрлийг тус тус хуульчилжээ. ХБНГУ-д 1/ Сэтгэцийн эмнэлэгт хэвтүүлэх; 2/ Донтох өвчнийг эмчлэх эмнэлэгт хэвтүүлэх; 3/ Хамгаалах зорилгоор цагдан хорих; 4/ Зан үйлийн хяналт тогтоох төрлийг хуульчилсан бол Бүгд Найрамдах Чех улсад 1/ хорих ангид хамгаалах эмчилгээг хийх, 2/ эмнэлгийн байгууллагад эмчилгээ хийх гэсэн төрлүүдийг хуульчилжээ.

Одоогийн Эрүүгийн хуулийн 7.4 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрөл, дэглэм, хугацааг шинжээчийн дүгнэлтийг харгалзан шүүх тогтооно”, мөн зүйлийн 6 дахь хэсэгт “Хэрэг хариуцах чадвартай байхдаа ял шийтгүүлсэн ялтны сэтгэцийн эмгэгийг эмчлэх зайлшгүй шаардлагатай тохиолдолд шүүх амбулаторийн албадан хяналтад, эсхүл сэтгэцийн эмгэг судлаачаар эмчлүүлэх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэж болно” гэж зааснаас үзэхэд шүүхээс тухайн хүнд холбогдох хэргийг анхлан шийдвэрлэхэд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэхэд эмнэлгийн төрөл, дэглэмийг заагаагүй бол ял эдэлж байхдаа хэрэг хариуцах чадваргүй болсон хүнд хэрэглэх уг арга хэмжээний төрлийг тодорхойлсон байна гэж дүгнэгдэхээр байна.

Цаашид эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэхдээ үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэмт этгээдийн хувийн байдлыг харгалзаж ямар төрлийн эмнэлэгт эмчлэх талаарх зохицуулалтыг Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэг мөр нарийвчлан зохицуулах нь Эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэх боломжийг хязгаарлах, алба хаагчдын аюулгүй байдлыг хангах, хүний эрхийн аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлэхэд ач холбогдолтой юм.

Тиймээс бид эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх, төрөл дэглэмийг дараах байдлаар эрүүгийн хуульд хуульчлах санал дэвшүүлж байна. Үүнд:

1. сэтгэцийн эмчийн хяналт дор амбулаториор албадан эмчлэх;
2. сэтгэцийн эмнэлэгт ердийн хяналт дор эмчлэх;
3. сэтгэцийн эмнэлэгт эрчимжүүлсэн хяналт дор эмчлэх;
4. сэтгэцийн эмнэлэгт онцгой хяналт дор эмчлэх зэрэг болно.

Сэтгэцийн эмчийн хяналт дор амбулаториор албадан эмчлэх гэдэгт сэтгэцийн эрүүл мэндийн байдал нь тогтвортой бөгөөд хөнгөн хэлбэрийн сэтгэцийн

өвчтэй хүмүүсийг сэтгэцийн эмчийн хяналт дор амбулаториор албадан эмчилж, тэдгээрийн өвчнийг даамжрахаас сэргийлж, нийгэмд аюултай гэмт үйлдэл хийхээс нь сэргийлэх арга хэмжээг ойлгоно. Уг арга хэмжээг хорих ял эдэлж байгаа байгууллагад болон гадуур хэрэглэх боломжтой байдлаар зохицуулж болно.

Сэтгэцийн эмнэлэгт ердийн хяналт дор эмчлэх гэдэгт гэмт этгээдийн сэтгэцийн эрүүл мэндийн байдал, нийгэмд аюултай хууль бус үйлдлийнх нь шинж чанарыг харгалзан эмнэлэгт албадан хэвтэн эмчлэх арга хэмжээг ойлгоно.

Сэтгэцийн эмнэлэгт эрчимжүүлсэн хяналт дор эмчлэх гэдэгт сэтгэцийн өвчтэй бөгөөд хүнийг алахаас өөр нийгэмд аюултай гэмт хэрэг үйлдсэн, бусад хүнд хохирол, хор уршиг учруулахааргүй этгээдийг эрчимжүүлсэн хяналт дор албадан хэвтэн эмчлэх арга хэмжээг ойлгоно.

Сэтгэцийн эмнэлэгт онцгой хяналт дор эмчлэх гэдэгт сэтгэцийн өвчтэй бөгөөд хүнд гэмт хэрэг үйлдсэн, нийгэмд аюултай этгээдийг онцгой хяналт дор албадан хэвтэн эмчлэх арга хэмжээг ойлгоно.

IV. Согтуурах болон мансуурах бодист донтой хүнд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Согтуурсан, мансуурсан үедээ гэмт хэрэг үйлдсэн хүн согтуурах, мансуурах донтох эмгэгтэй болох нь тогтоогдвол түүнд оногдуулсан ял дээр нэмж эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэж болно.” гэж заасан.

Сүүлийн 10 жилийн хугацаанд согтуурах, мансуурах донтой хүнд эрүүгийн хуульд заасны дагуу ял оногдуулахын зэрэгцээ давхар эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, эсхүл хорих ангийн байрлалд эмчлүүлэхээр шийдвэрлэсэн тохиолдол байхгүй ч хорих ял эдэлж байгаа хүмүүсийн дунд мансуурах эмгэгтэй хүн цөөнгүй байна. Харин ямар учир шалтгааны улмаас мансуурах бодист донтсон, түүнээс шалтгаалсан сэтгэцийн эмгэгтэй хүнд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглээгүй нь сонирхол татаж байна.

Судалгаанаас үзэхэд ШШГЕГ-ын харьяа 401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлэгт тусламж үйлчилгээ авсан сэтгэцийн тулгамдсан асуудалтай хүний 618 буюу 11.2 хувь нь сэтгэцийн эмгэгтэй болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэгт ял шийтгэгдсэн өвчтөн байсан. Судалгаанаас үзэхэд хорих ял шийтгэгдсэн сэтгэцийн эмгэг, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээтэй хоригдлын тоо жил бүр өссөн хандлагатай байна. Тухайлбал, тус хорих ангид эмчлүүлсэн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэгт ял шийтгэгдсэн өвчтөн 2017 онд 168, 2018 онд 163, 2019 онд 204, 2020 онд 47, 2021 онд 11 хүн байжээ.³⁴

³⁴ Б.Гомбо, “Хорих ял шийтгүүлсэн хоригдлуудын сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан

Дээрх нөхцөл байдлуудаас дүгнэхэд Эрүүгийн хуулийн 7.4 дүгээр зүйл, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 19 дүгээр бүлэгт заасан “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх” тухай зохицуулалтыг эргэн харж, хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, холбогдох тушаал, журмуудыг шинэчлэх шаардлагатай байна.

V. Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуульд заасан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх үндэслэл, төрөл дэглэмийг ялгамжтай тогтоох

Эрүүгийн хуулийн 7.4 дүгээр зүйлд гэмт хэрэг үйлдсэн хүнд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх үндэслэл, журмыг тодорхойлсон бол Зөрчлийн тухай хуулийн 2.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Сэтгэцийн эмгэгийн улмаас өөрийн үйлдлийн бодит шинж чанар, аюулыг ухамсарлах, өөрийн үйлдлээ удирдан жолоодох чадваргүй хүнийг хэрэг хариуцах чадваргүйд тооцно” гэж, мөн зүйлийн 3 дахь хэсэгт “Зөрчил үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй байсан хүнд шийтгэл оногдуулахгүйгээр хуульд заасан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж болно.”³⁵ гэж тус тус заажээ. Эндээс эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг гэмт хэрэг үйлдсэн хүн төдийгүй зөрчил үйлдсэн хүнд хэрэглэж болохоор харагдаж байна. Зөрчил үйлдсэн хүний хэрэг хариуцах чадваргүй байдал, уг арга хэмжээг хэрэглэх процессын зохицуулалтыг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар зохицуулахаар хуульчилжээ. Зөрчлийн тухай хуулийн 4.4 дүгээр зүйлд Албадан эмчлэх гэсэн нэр томъёог хэрэглэсэн бөгөөд тус зүйлийн 1 дэх хэсэгт “Зөрчил үйлдсэн хүн донтох сэтгэцийн эмгэгтэй болох нь эмнэлгийн дүгнэлтээр тогтоогдсон бол шүүх түүнийг албадан эмчилгээнд хамруулахаар шийдвэрлэж болно”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Албадан эмчлэхтэй холбогдсон харилцааг хуулиар зохицуулна” гэж заажээ.

Зөрчлийн тухай хуульд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх үндэслэл нь “хэрэг хариуцах чадваргүй байдал” гэж хуульчлаад уг арга хэмжээг тодорхойлсон тус хуулийн 4.4 дүгээр зүйлд зөвхөн “донтох” эмгэгийг хуульчилсан нь зөрчилдөөнтэй байдлыг үүсгэж байна. Түүнчлэн шүүхийн практикт зөрчил үйлдсэн хүнд “эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ” хэрэглэх, “албадан эмчлэх арга хэмжээ” хэрэглэх ойлголтуудыг ялгаатай байдлаар хэрэгжүүлж байгаа нь дараах тохиолдлуудаас дүгнэгдэж байна.

асуудал”. Гэмт явдалтай тэмцэх асуудал сэтгүүл.УБ., 2021.№79. 41 дэх тал.

³⁵ //Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2017.№24.

Тохиолдол-8. Зөрчилд холбогдогч З нь 2019.1.22-ны өдөр Баянгол дүүргийн 22 дугаар хорооны нутаг дэвсгэрт иргэн Н-ийн халааснаас “Эл Жи Экс” загварын гар утсыг, нууцаар, хүч хэрэглэхгүйгээр, хууль бусаар хулгайлан авч 180.000 төгрөгийн хохирол учруулсан зөрчил үйлджээ. Шүүх Зөрчлийн тухай хуулийн 2.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар зөрчилд холбогдогч З-д шийтгэл ногдуулахгүйгээр эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авч, Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний төвийн энгийн тасагт эмчлэхээр,³⁶

Тохиолдол-9. Зөрчилд холбогдогч Б нь 2021.12.15-ны өдөр Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар хороонд байрлах задгай тоотод иргэн Ц-д бэлгийн дарамт учруулах зөрчил үйлджээ. Шүүх Зөрчлийн тухай хуулийн ерөнхий ангийн 2.3 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасныг баримтлан тусгай ангийн 6.26 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан шийтгэл оногдуулахгүйгээр чөлөөлж, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг 3 сарын хугацаагаар Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Шүүх сэтгэц эмгэг судлалын клиникт эдлүүлэхээр,³⁷

Тохиолдол-10. Зөрчилд холбогдогч Д нь 2022.7.30-ны өдөр Орхон аймаг Баян-Өндөр сум Яргуйт багт байрлах “Энэл” дэлгүүрт иргэн Э-ийн биед халдах зөрчил үйлджээ. Шүүх Зөрчлийн тухай хуулийн ерөнхий ангийн 4.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар албадан эмчилгээнд хамруулах албадлагын арга хэмжээг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд хэрэгжүүлэхээр³⁸ тус тус шийдвэрлэсэн.

Дээрх тохиолдлуудаас үзэхэд “эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ”-г хэрэглэхдээ Зөрчлийн тухай хуулийн 2.3 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсгийг, “албадан эмчлэх” арга хэмжээг хэрэглэхдээ тус хуулийн 4.4 дүгээр зүйлийг удирдлага болгож байгаа процессын зохицуулалтын хувьд аль аль тохиолдолд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хэм хэмжээг ашиглаж байна. Бидний үзэж байгаагаар Зөрчлийн тухай хуулийн 2.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан “эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ” нь зөрчилд хүлээлгэх хариуцлагын нэг хэлбэр бөгөөд албадлагын арга хэмжээнээс тусдаа ойлголт биш юм.

Учир нь Зөрчлийн тухай хуулийн 1.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Зөрчил, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулах шийтгэл, албадлагын арга хэмжээний төрөл, хэмжээг энэ хуулиар тогтооно” гэж заагаад шийтгэлийн

³⁶ Шийтгэвэр. Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх. 2019.04.01. №271.

³⁷ Шийтгэвэр. Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх. 2022.03.10. №563.

³⁸ Шийтгэвэр. Орхон аймаг дахь Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх. 2022.09.01. №750.

төрөл хэмжээг Гуравдугаар бүлэгт, албадлагын арга хэмжээний төрөл хэмжээг Дөрөвдүгээр бүлэгт тус тус заасан. Түүнчлэн зөрчил хянан шийдвэрлэсэн дээрх шийдвэрт зааснаар гэмт хэрэг үйлдэж эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүнтэй ижилхэн дэглэм нөхцөлд уг арга хэмжээг хэрэгжүүлж байгааг хүний эрхийн зөрчил гэж үзнэ.

2015 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш улсын хэмжээнд Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс зөрчил үйлдсэн 3 хүнд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхээр шийдвэрлэсэн байх ба хууль хэрэглээний талаар зөв практик тогтоогүй байна. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Шүүх зөрчил хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахад энэ хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан нийтлэг журмыг удирдлага болгоно.” гэж, мөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 19.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Сэтгэцийн хувьд хэрэг хариуцах чадваргүй, сэтгэцийн эмгэг, эрүүл мэндийн тулгамдсан асуудалтай хүн гэмт хэрэг үйлдсэн, эсхүл гэмт хэрэг үйлдсэний дараа сэтгэцийн өвчнөөр өвчилсний улмаас хэрэг хариуцах чадваргүй болсон яллагдагч, шүүгдэгчид эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхдээ энэ хуульд заасан ердийн журмаас гадна энэ бүлэгт заасан тусгай журмыг удирдлага болгоно.” гэж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 190 дүгээр зүйлийн 190.1 дэх хэсэгт “Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхээр шийдвэрлэсэн бол шүүх албадлагын арга хэмжээг ямар төрлийн эмнэлэгт хэрэгжүүлэхийг тогтоолдоо заана.” гэж тус тус заасан байх боловч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 19 дүгээр бүлэгт заасан журмыг зөвхөн гэмт хэрэг үйлдсэн яллагдагч, шүүгдэгчид хэрэглэхээр заасан тул зөрчил шалган шийдвэрлэхэд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг удирдлага болгох боломжгүй. Тиймээс зөрчлийн шинжтэй үйлдэлд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх журмыг хуульчилж гэмт хэрэг үйлдсэн хүнтэй ижилхэн орчин нөхцөлд уг арга хэмжээг эдлүүлж байгаа практикийг засах шаардлагатай.

VI. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх орчин нөхцөл, аюулгүй байдлыг хангах

Судалгаагаар Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 39 хүн албадан эмчлүүлж байгаагаас 35.9 хувь буюу 14 нь эмэгтэй, 64.1 хувь буюу 25 нь эрэгтэй, тэднийг хүйсийн хувьд тус тусад нь өөр тасагт эмчлэх, мөн нэг өрөөнд 4-6 хүн байрлаж эмчлэгдэж байгааг эмнэлгийн стандарт, журамд нийцүүлэн эмчлүүлэгчийн Үндсэн хуульд заасан аюулгүй орчинд байж, эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж үйлчилгээ авах эрхийг хангах боломжтой нөхцөлийг

бүрдүүлэх шаардлагатай.³⁹

Монгол Улсын хэмжээнд Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Шүүхийн сэтгэц эмгэг судлалын клиник нь шүүхийн шийдвэрээр хэрэг хариуцах чадваргүй хүнд авсан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэн, тусламж үйлчилгээг үзүүлдэг бөгөөд байрны хүртээмж, стандартын шаардлага хангасан өрөө, тасалгаагүйгээс албадан эмчлэгдэж буй хүний эрх зөрчигдөж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 190 дүгээр зүйлийн 190.4 дэх хэсэгт “Албадан эмчлүүлж байгаа этгээдийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, эмнэлэг, цагдаагийн байгууллага хамтран хэрэгжүүлнэ”⁴⁰ гэж хуульчилсан. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2017 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн А-240/А/369 дүгээр тушаалаар баталсан “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, түүнд хяналт тавих журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.4 дэх хэсэгт “Албадан эмчлүүлж байгаа этгээдийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, эмнэлгийн болон цагдаагийн байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ”, 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт “Албадан эмчлүүлэгчийн зүгээс гарч болзошгүй хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын болон харуул хамгаалалтын арга хэмжээг тус журмын 1.4-т тусгагдсан байгууллагууд хамтран авч хэрэгжүүлсэн байна”, 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Хамгаалалтын нэг ээлжид 2-оос доошгүй хамгаалалтын ажилтан үүрэг гүйцэтгэхээр зохион байгуулна” гэж тус тус заасан.

Гэмт хэрэг үйлдсэн хэрэг хариуцах чадваргүй этгээдэд авсан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг СЭМҮТ-ийн Шүүхийн сэтгэц эмгэг судлалын клиникт хэрэглэж байгаа бөгөөд харуул хамгаалалтыг ШШГЕГ-ын Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны Баривчлах төвийн алба хаагчид хариуцан өдрийн цагаар 1 ахлах ажилтан, 2 алба хаагч, шөнийн цагт 2 алба хаагч хяналт тавин ажилладаг. Шүүхийн сэтгэц эмгэг судлалын клиникт эмчлэгдэж байгаа хүний ихэнх нь хүнд гэмт хэрэг үйлдэн албадан эмчилж байгаа, мөн тус клиникт шүүгчийн захирамжаар Шүүх, сэтгэц эмгэг судлалын магадлан шинжилгээ хийхэд тодорхой хугацаагаар хэвтүүлж, хяналтад байлгах, ажиглалт хийлгэхээр ирсэн шинжлүүлэгч мөн хэвтдэг. Албадан эмчлүүлж буй сэтгэцийн архаг даамжрах явц бүхий солиорох эмгэгтэй хүнд харилцааны өндөр ур чадвар, хурц сонор сэрэмж, тасралтгүй хараа хяналт шаардлагатай төдийгүй сэтгэцийн эмгэгийн тухай ерөнхий ойлголттой, туршлагатай албан хаагч хяналт тавих нь нэн чухал байдаг.

³⁹ Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 1/564 дүгээр албан бичиг.

⁴⁰ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2017 он, www.legalinfo.mn

Албадан эмчлүүлэгч нарт эмч үзлэг хийх, эмчилгээ, шинжилгээнд гадагш авч явах, эмчлүүлэгч нарт эргэлт ирэх, тэднийг нийтэд нь хоолонд оруулах, цэвэрлэгээ үйлчилгээ хийх, гадагш агаарт гаргах зэрэгт шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчид хүрэлцдэггүйгээс дээрх эмчлүүлэгчид бусдын биед халдах, өөртөө болон бусдад хохирол учруулах өндөр эрсдэлтэй байдаг тул хяналт тавих алба хаагчдыг чадавхжуулах, тэдний тоог нэмэгдүүлэх шаардлагатай болсон байна.

VII. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх тогтолцоо, үйл ажиллагааг боловсронгуй болгох

Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний дараа үзүүлэх тусламж үйлчилгээ: Эрүүгийн хуулийн 7.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй байсан хүний сэтгэцийн байдал нь өөртөө, бусдад аюул учруулахааргүй бол шүүх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхгүйгээр сэтгэцийн эрүүл мэндийн холбогдох байгууллагад эмчлүүлэх, асран хамгаалагчид халамжлуулахаар шилжүүлж болно” гэж заажээ. Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг шүүхийн шийдвэрээр зогсоосон боловч асран хамгаалах харгалзан дэмжих хүнгүй, эсхүл асрамжиндаа авахаас татгалзсан тохиолдолд уг асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар тусгаагүй байна.

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Шүүхийн сэтгэц эмгэг судлалын клиникт албадан эмчлүүлж байгаа 39 хүнээс 5 хүн⁴¹ нь албадан эмчилгээний хугацаа дууссан боловч гэр оронгүй, асран хамгаалах, харгалзан дэмжих хүнгүй, асран хамгаалах хүн байгаа боловч өөрийн асрамжид авах хүсэлгүй байгаагаас тус төвд үргэлжлүүлэн албадан эмчлэгдсээр байгаа нь Монгол Улсын нэгдэн орсон гэрээ конвенцоор, сэтгэцийн эмгэгтэй хүнийг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байгааг харуулах юм.

Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Хүн амын сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар төрийн бүх шатны байгууллага тус тусын эрх хэмжээний хүрээнд дараах үүрэг хүлээнэ” гэж, мөн зүйлийн 5.1.8 дахь заалтад “сэтгэц-нийгмийн сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэх ажлын байр бий болгож, сэтгэцийн эмгэгтэй хүний асуудлыг дэмжих төв болон тусгайлсан асрамжийн газрыг аймаг, дүүрэгт байгуулах” гэж хуульчилсан боловч өнөөдрийн байдлаар дурдсан асрамжийн газар байгуулагдаагүй байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар баталсан “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай

⁴¹ Шийтгэх тогтоол. Сэлэнгэ аймаг Сайхан сум дахь СДЭХАШШ. 2018.05.07. №36., Шийтгэх тогтоол. Дархан-Уул аймаг дахь СДЭХАШШ. 2020.04.28. №168., Шүүгчийн захирамж. Дархан-Уул аймаг дахь СДЭХАШШ. 2021.02.19. №100., Шийтгэх тогтоол. ХУДЭХАШШ. 2020.01.16. №38., Шийтгэх тогтоол. Орхон аймаг дахь СДЭХАШШ. 2020.09.11. №308.

шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, түүнд хяналт тавих журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.8 дахь хэсэгт "Асран хамгаалах хүнгүй, гэр оронгүй эмчлүүлэгчийг албадан эмчилгээ дууссаны дараа сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв нь холбогдох байгууллагад хүсэлтээ гарган асуудлыг шийдвэрлэж ажиллана" гэж заасан боловч хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байна.

Энэ талаар хүний эрхийн чиглэлээр ажилладаг олон улсын болон үндэсний байгууллагаас тодорхой санал зөвлөмж өгч байсныг нэн даруй хэрэгжүүлэх шаардлагатай юм. ХЭҮК-оос СЭМҮТ-д хийсэн хяналт шалгалтын дүгнэлтэд "Албадан эмчлүүлэх хугацааг шүүхийн шийдвэрт заагагүй, хугацаа заасан ч асран хамгаалах харгалзан дэмжих хүнгүй, холбогдох баримт материал дутуу гэх шалтгаанаар эмнэлгээс гаргахгүй байгаа асуудлыг СЭМҮТ дангаараа шийдвэрлэх боломжгүй, тогтолцооны шинжтэй, хүний эрхийн асуудал бөгөөд нэн даруй шийдвэрлэх шаардлагатай"⁴² гэж, НҮБ-ын дур зоргоор баривчлан саатуулахаас урьдчилан сэргийлэх ажлын хэсэг "...20-25 жил эмчлүүлж буй эмчлүүлэгчид мөн байлаа. Гэсэн хэдий ч нийгэм, хамт олонд түшиглэсэн тусламж үйлчилгээ байхгүй, мөн тэдгээр хүмүүсийг харж хандах, тусламж, дэмжлэг үзүүлэх гэр бүл, төрөл садан байхгүй учраас тус төвөөс хэзээ гарах нь тодорхойгүй байсаар байна"⁴³ гэж тус тус дүгнэжээ.

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн санаачилгаар 20 гаруй жилийн өмнө ийм нөхцөлд байгаа хүмүүсийг эмнэлгээс гаргаж, тусад нь амьдруулах зорилгоор эмнэлгийн хашаан дотроо Монгол гэр барин зарим эмчлүүлэгчдийг тусад нь гарган, тусгайлсан асрамжийн үйлчилгээ үзүүлсэн нь тун сайшаалтай байна.⁴⁴

2018 онд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.3.26-д заасан "Сэтгэцийн архаг өвчтөнд зориулсан тусгайлсан асрамжийн газар байгуулах" ажлын хүрээнд төрөлжсөн асрамжийн газарт асруулж байгаа сэтгэцийн өвчтэй хүмүүсийн асуудлыг шийдвэрлэх, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, хууль, эрх зүйн орчинг олон улсын чиг хандлагад нийцүүлэх талаар санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулсан бөгөөд 2016-2020 онд хэрэгжих Эрүүл мэндийн яамны үйл ажиллагааны төлөвлөгөөнд сэтгэцийн архаг өвчтөнд зориулсан тусгайлсан асрамжийн газар байгуулах зорилт тусгагдсан юм. Уг асрамжийн газрын 2017 онд эрх зүйн орчныг шинэчлэн бүрдүүлэх, 2018 онд зураг төсөв батлан барилгын ажлын явцыг 50 хувьд хүргэх, 2019 онд барилга байгууламжийг улсын комисс хүлээн авч үйл ажиллагааг эхлэх шат дараалсан хуваарь байгаа боловч өнөөгийн байдлаар ажлын хэсэг байгуулж,

⁴² ХЭҮК-ын гишүүний 2021 оны 12 дугаар сарын 30-ний өдрийн 3/46 дугаар шаардлага.

⁴³ НҮБ-ын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсгийн 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн урьдчилсан дүгнэлт.

⁴⁴ НҮБ-ын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсгийн урьдчилсан дүгнэлт, 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдөр.

холбогдох тооцоо судалгаа бүрэн гаргаж, барилгын ажлыг эхэлсэн байна.⁴⁵

Иймд хууль ёсны асран хамгаалагчгүй, ар гэр нь асрамжиндаа авахаас татгалзсан хүний албадан эмчилгээний хугацаа дууссан тохиолдолд асрамжийн газарт шилжүүлэхтэй холбоотой нарийвчлан хуульчлах, шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээ авахгүй бол тухайн эмчлүүлэгчийг бүх насаар нь албадан эмчлэх нөхцөл байдал үүсч байна. Эрүүгийн хуульд хүний эрх чөлөөг хасч бүх насаар хорих ял оногдуулж болох гэмт хэргийн төрлийг хуульчилж өгсөн бөгөөд уг ялаар шийтгүүлсэн хүн Тусгай нэгжид 10 жил ял эдэлсэний дараа зэрэглэл буурах зохицуулалтыг хуульчилсан байхад эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хугацаагүй оногдуулах, хугацаа дууссан эмчлүүлэгчийг хүлээн авах газаргүй гэх шалтгаанаар үргэлжлүүлэн эрх чөлөөг нь тодорхой дэглэм бүхий нөхцөлд эрх чөлөөг нь хасаж байгаа хүний эрхийн зарчмын үүднээс зөвтгөх үндэсгүй юм.

Цаашид сэтгэцийн эмгэгтэй, архаг хүнд өвчтэй хүний асрамжийн газрыг ашиглалтанд оруулах, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх хугацаа дууссан өвчтөнийг шилжүүлэх эрх зүйн орчин бүрдүүлэх нь уг арга хэмжээний үр нөлөөг дээшлүүлэх, бусад эмчлүүлэгчдийн эрхийг хангахад ач холбогдолтой.

VIII. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой бусад асуудал

Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2005 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 167/265 дугаар “Шүүх эмнэлгийн магадлан шинжилгээ явуулах дүрэм, заавар баталж мөрдүүлэх тухай” тушаалын 4 дүгээр хавсралтаар “Шүүх сэтгэц, эмгэг судлалын магадлагаа хийх заавар”-ыг баталсан. Дээрх зааврын дагуу Нийслэлд СЭМҮТ-ийн ерөнхий захирал, орон нутагт аймгын Нэгдсэн эмнэлгийн ерөнхий эмчийн тушаалаар орон тооны бус сэтгэцийн нарийн мэргэжлийн 3-аас доошгүй шинжээч эмч хариуцан шинжилгээ хийхээр нарийвчлан зааж өгсөн боловч орон нутагт сэтгэцийн 1-2 эмч, эмчилгээ эрхэлсэн орлогч, зарим тохиолдолд сэтгэцийн 1 эмч, өөр мэргэжлийн 2 эмч оролцон дүгнэлт гаргаж байгаа нь учир дутагдалтай байна.

Түүнчлэн дээрх 167/265 дугаар тушаалыг Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2010 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 135/256 дугаар тушаалаар хүчингүй болсонд тооцож “Шүүх эмнэлгийн

⁴⁵ СЭМҮТ-өөс “Сэтгэцийн эмгэгтэй эмчлүүлэгчдийн асрамжийн төв”-ийн ажиллах бүтэц, ор, хүний нөөцийн зураглалыг урьдчилан төсөл байдлаар гаргасан. Үүнд шинэ асрамжийн газрыг 300 орны хүчин чадалтай гэвэл эмч, эмнэлгийн дээд мэргэжилтэн 25, сэтгэл зүйч 5, эм зүйч 1, нягтлан бодогч 4, нийгмийн ажилтан 1, ахлах сувилагч 6, сувилагч 76, эм найруулагч 2, лаборант 2, сэргээн засах ажилтан 11, бичиг хэргийн ажилтан 1, нярав 2, тогооч 4, бэлтгэгч 6, туслах сувилагч 55, угаагч индүүдэгч 3, үйлчлэгч 8, жижүүр 8, жолооч 2 нийт 222 ажиллах орон тоо шаардлагатай тухай 2017 онд Хөдөлмөр нийгмийн хамгааллын яаманд СЭМҮТ-өөс хүргүүлж байсан.

шинжилгээ хийх журам"-ыг шинээр, мөн дээрх 135/256 дугаар тушаалыг Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2014 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/215/421 дүгээр тушаалаар хүчингүй болсонд тооцож "Шүүх эмнэлгийн шинжилгээ хийх журам"-ыг шинээр тус тус баталсан. Дээр дурдсан 2010, 2014 оны тушаалуудад "Шүүх сэтгэц, эмгэг судлалын магадлагаа хийх заавар"-ыг шинэчлэн батлаагүйгээс одоог хүртэл хүчингүй болсон Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2005 оны хамтарсан тушаалаар баталсан зааврыг мөрдөж Нийслэл болон орон нутагт шүүх сэтгэц эмгэг судлалын магадлагааг гаргаж байна.

Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний үндэслэл болох хэрэг хариуцах чадваргүй байдлыг тодорхойлох "Шүүх сэтгэц, эмгэг судлалын магадлагаа хийх заавар"-ыг шинэчлэн батлах нь зүйтэй.

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн А-240/А369 дүгээр хамтарсан тушаалаар баталсан "Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх түүнд хяналт тавих журам"-ын 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэгт "Албадан эмчлүүлэх этгээдийг хүргэж ирсэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтнаас тухайн этгээдэд албадан эмчилгээ явуулах тухай шүүхийн шийдвэр, сэтгэцийн эмгэг судлалын шинжилгээний дүгнэлт, магадлагааны актын хуулбар, иргэний болон бусад холбогдох бичиг баримтыг үндэслэн албан ёсоор хүлээн авах ба эдгээр нь өвчний түүх нээх үндэслэл болно." заасан.

Дээрх журмын дагуу СЭМҮТ нь сэтгэц эмгэг судлалын шинжилгээний дүгнэлт, магадлагааны актын хуулбар, иргэний бичиг баримтыг шүүхийн шийдвэрийн хамт ирүүлэхийг шаардах тохиолдол цөөнгүй байна. Түүнчлэн шүүхээс албадан эмчлэхээр шийдвэрлэсэн хүнийг СЭМҮТ-д хүргэхдээ зарим тохиолдолд шүүхийн шийдвэр хүчинтэй болсон өдөр буюу шийдвэрийг уншин сонгосон өдрөөр, зарим тохиолдолд шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсны дараа хүргэж байгаа тул энэ талаар нэгдсэн практик тогтоох шаардлага бий болсон. Тухайлбал, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 11.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Шүүх хуралдааны тэмдэглэлийг шүүхийн шийдвэрийг уншиж сонгосноос хойш 7 хоногийн дотор гаргаж, шүүх хуралдаан даргалагч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга гарын үсэг зурж, прокурор, оролцогчид танилцуулна." гэж, мөн хуулийн 36.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Шүүхийн шийдвэрийг уншиж сонгосноос хойш 15 хоногийн дотор ...бүрэн эхээр, бичгээр үйлдэж улсын яллагч, шүүгдэгч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, өмгөөлөгчид гардуулан өгнө." гэж тус тус заасан байна.

Иймд сэтгэцийн эмгэг, оюун ухааны хомсдолын улмаас хэрэг хариуцах чадваргүй этгээдэд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхээр шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг уншиж сонгосон буюу хүчинтэй болсны

дараа шууд бичгээр үйлдэн албажуулж СЭМҮТ-д хүргэх боломжгүй тул сэтгэц эмгэг судлалын шинжилгээний дүгнэлт, магадлагаа, иргэний бичиг баримт, албадан эмчлүүлэгчийг хүлээлгэн өгсөн тухай шүүхийн баримтын хамт албадан эмчилгээг биелүүлэх СЭМҮТ-д хүргэх талаар холбогдох журамд өөрчлөлт оруулах шаардлага бий болж байна.

Шүүх гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг харгалзан сэтгэл заслын, донтох зуршлын эсрэг эмчилгээ хийлгэх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ оногдуулж болно⁴⁶ гэж заасны дагуу хэрэг хариуцах чадваргүй этгээдэд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхдээ сэтгэл заслын болон донтох зуршлын эсрэг ямар эмчилгээ хийлгэхийг ихэнх тохиолдолд шийдвэртээ дурдаагүй орхисон зэрэг хууль хэрэглээний алдаа гарч, уг шийдвэрийг хэрэгжүүлэхэд бэрхшээл үүсч байна.

IX. ДҮГНЭЛТ, САНАЛ

1. Хэрэг хариуцах хязгаарлагдмал чадвар, түүний шалгуурыг эрүүгийн хуульд тусгаж, зарим төрлийн гэмт хэрэгт тухайлбал, хүнийг алах, бага насны хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл, мансууруулах бодис сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг үйлдсэн хэрэг хариуцах чадвартай боловч сэтгэцийн эмгэгтэй хүмүүст ял оногдуулахын зэрэгцээ албадан эмчлэх арга хэмжээг хэрэглэх үндэслэлийг хуульчлах шаардлага нэгэнт бий болжээ.
2. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг гэм буруутай хүнд ял эдэлж байхад болон эдлэсний дараа тодорхой хугацаанд үргэлжлүүлэн хяналттайгаар хэрэгжүүлэх нь дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, сэтгэцийн эмгэгээс шалтгаалсан гэмт зан байдлыг засах зэрэг эерэг үр нөлөөтэй бөгөөд эрүүгийн хариуцлагын зорилгыг бүрэн хангах ач холбогдолтой юм.
3. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэхдээ гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэмт этгээдийн хувийн байдлыг харгалзан ямар төрлийн эмнэлэгт эмчлэх талаарх зохицуулалт хуульчлагдаагүйгээс анхан шатны шүүх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхдээ түүнийг хэрэгжүүлэх эмнэлгийн төрлийг хуульд заагаагүй нэр томьёо хэрэглэн тогтоох, гэмт хэрэг үйлдсэн хэрэг хариуцах чадваргүй хүний хувийн байдалд тохироогүй тасагт хэвтүүлэн эмчлэх зэрэг доголдол үүсэж байна.
4. Зөрчлийн шинжтэй үйлдэлд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх журмыг Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд хуульчилсан хэдий ч зөрчилд оногдуулсан эмнэлгийн чанартай

⁴⁶ Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.4 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг.

- албадлагын арга хэмжээг гэмт хэрэг үйлдсэн хүнтэй ижилхэн орчин нөхцөлд хэрэгжүүлж байгааг засах шаардлага тулгарч байна.
5. Шүүх гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг харгалзан сэтгэл заслын, донтох зуршлын эсрэг эмчилгээ хийлгэх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ оногдуулж болно гэж заасны дагуу хэрэг хариуцах чадваргүй этгээдэд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхдээ сэтгэл заслын болон донтох зуршлын эсрэг ямар эмчилгээ хийлгэхийг ихэнх тохиолдолд шийдвэртээ дурдаагүй орхисон зэрэг хууль хэрэглээний алдаа гарч, уг шийдвэрийг хэрэгжүүлэхэд бэрхшээл үүсч байна.

Дээрх дүгнэлтэд үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна.

1. Эрүүгийн хуульд “хэрэг хариуцах хязгаарлагдмал чадвар, түүний шалгуур”-ыг хуульчлах, хүнийг алах, бага насны хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл зэрэг гэмт хэрэг үйлдсэн хэрэг хариуцах чадвартай боловч сэтгэцийн эмгэгтэй хүмүүст ял оногдуулахын зэрэгцээ эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэх үндэслэлийг хуульчлах;
2. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрөл, дэглэмийг дараах байдлаар Эрүүгийн хуульд хуульчлах,
 - хамгаалах зорилгоор эмчийн хяналтанд цагдан хорих;
 - сэтгэл заслын эмчилгээнд хамрагдах;
 - сэтгэцийн эмчийн хяналт дор амбулаторит эмчлэх;
 - сэтгэцийн эмнэлэгт ердийн хяналт дор эмчлэх;
 - сэтгэцийн эмнэлэгт эрчимжүүлсэн хяналт дор эмчлэх;
 - сэтгэцийн эмнэлэгт онцгой хяналт дор эмчлэх.
3. Эрүүгийн хуулийн 7.4 дүгээр зүйлийн холбогдох хэсэгт “эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүний сэтгэцийн эмгэгийн талаар 6 сар тутам дүгнэлт гаргах” талаар холбогдох зохицуулалтыг тусгах;
4. Эрүүгийн хуульд “Согтуурах болон мансуурах донтой хүнд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх, сунгах хугацааг 6-12 сарын хугацаатай тогтоох” зохицуулалтыг хуульчлах;
5. 6. Зөрчил, гэмт хэрэг үйлдсэн үндэслэлээр эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх, хамгаалах зорилгоор эмчийн хяналтанд цагдан хорих арга хэмжээний орчин нөхцөлийг хүний эрхийн зарчим хэм хэмжээнд нийцүүлэн ялгамжтай тогтоох,
6. Сэтгэцийн эмгэгтэй хүний асрамжийн газрыг ашиглалтад оруулах, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх хугацаа дууссан өвчтөнийг шилжүүлэх эрх зүйн орчинг Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд тусгах.

Х. НОМ ЗҮЙ

Монгол хэл дээрх эх сурвалж:

1. С.Жанцан. „Монгол Улсын эрүүгийн эрх зүйн онол /Гэмт хэргийн тухай сургааль/. I боть. Улаанбаатар, 2009.
2. Г.Гантөмөр. Гэмт хэргийн бүрэлдэхүүний ерөнхий онол. Улаанбаатар, 2011.
3. С.Нарангэрэл. Монгол Улсын эрүүгийн эрх зүй. Ерөнхий анги. Улаанбаатар, 1999.
4. Г.Гантөмөр нар. Эрүүгийн эрх зүй: Ерөнхий анги (сурах бичиг). Улаанбаатар, 2020.
5. Б.Гомбо. “Хорих ял шийтгүүлсэн хоригдлуудын сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал”. Гэмт явдалтай тэмцэх асуудал сэтгүүл. Улаанбаатар, 2021. №79.
6. Б.Гомбо. “Сэтгэцийн эмгэгтэй хүний нийгэмд аюултай үйлдэл: Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэхэд тулгамдсан асуудал”. Салбар дундын анхдугаар зөвлөгөөний илтгэл. Улаанбаатар, 2021.

Гадаад хэл дээрх эх сурвалж:

7. Курс уголовного права. Общая часть. Москва: МГУ, 1999.
8. Уголовное право России. Москва, 1999.
9. Уголовный кодекс РД. Москва, 2000.
10. Уголовный кодекс Испании. 1998.
11. Уголовный кодекс Испании. 2002.

Эрх зүйн эх сурвалж:

12. Монгол Улсын Эрүүгийн хууль. Ерөнхий анги, 7.4 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг.
13. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. 2017.
14. Төрийн мэдээлэл эмхэтгэл. Улаанбаатар, 2017. №23.
15. Төрийн мэдээлэл эмхэтгэл. Улаанбаатар, 2017. №24.

Шүүхийн практик, шийдвэр:

16. Дархан-Уул аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх. 2017.12.28. №02.
17. Говь-Алтай аймаг дахь Сум дундын шүүх. 2018.08.02. №76.
18. Баянхонгор аймаг дахь СДЭХАШШ. 2018.06.26. №147.
19. Дорнод аймаг дахь СДЭХАШШ. 2020.05.25. №155.
20. Дорнод аймаг дахь СДЭХАШШ. 2020.11.10. №155А.
21. Өвөрхангай аймаг дахь СДЭХАШШ. 2017.11.22. №152.
22. Орхон аймаг дахь СДЭХАШШ. 2021.01.22. №31.
23. Ховд аймаг дахь СДЭХАШШ. 2019.07.22. №124.

24. Өвөрхангай аймаг дахь СДЭХАШШ. 2018.05.30. №87.
25. Сэлэнгэ аймаг, Сайхан сум дахь СДЭХАШШ. 2018.05.07. №36.
26. Дархан-Уул аймаг дахь СДЭХАШШ. 2020.04.28. №168.
27. Хан-Уул дүүргийн ЭХАШШ. 2020.01.16. №38.
28. Орхон аймаг дахь СДЭХАШШ. 2020.09.11. №308.
29. Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх. 2019.04.01. №271.
30. Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх. 2022.03.10. №563.
31. Орхон аймаг дахь Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх. 2022.09.01. №750.
32. Баянзүрх дүүргийн ЭХАШШ. 2019.11.29. №361.
33. Хан-Уул дүүргийн ЭХАШШ. 2018.10.17. №1339.
34. Дархан-Уул аймаг дахь СДЭХАШШ. 2021.02.19. №100.
35. Нийслэлийн шүүх. 2002.03.01. №14.
36. Баянзүрх дүүргийн шүүх. 2006.04.10. №158.
37. Баянзүрх дүүргийн шүүх. 2008.07.03. №341.

Бусад баримт, тайлан, албан бичиг

38. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар. 457, 433 дугаар хорих ангиудад хийсэн социологийн судалгааны дүгнэлт. Улаанбаатар, 2023.
39. Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх. Албан бичиг. 2023.03.14. №1/564.
40. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв. Ерөнхий захирлын албан бичиг.
41. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвөөс ХНХЯ-нд хүргүүлсэн асрамжийн төвийн бүтэц, орон тооны зураглал. 2017.
42. Хүний эрхийн Үндэсний Комисс. Гишүүний шаардлага. 2021.12.30. №3/46.
43. НҮБ. Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсгийн урьдчилсан дүгнэлт. 2022.10.14.

Цахим эх сурвалж:

44. Criminal Code of the Kyrgyz Republic.
45. French Penal Code (General Criminal Law).
46. Legalinfo.mn.

ОИХ.МН
СУДАЛГААНЫ САН



Э.ЦЭРЭНХАНД

Дотоод хэргийн их сургуулийн Сургалт судалгааны 403 дугаар анги-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн Иргэний шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн ахлах багш, хошууч

ХҮҮХДИЙГ ХУУЛЬ ЁСНЫ АСРАН ХАМГААЛАГЧИД ШИЛЖҮҮЛЭН ӨГӨХ, ТУСДАА АМЬДАРДАГ ЭЦЭГ, ЭХТЭЙ НЬ АЛБАДАН УУЛЗУУЛАХ ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГАА

TRANSFER OF CHILDREN TO THEIR LEGAL GUARDIANS AND ENFORCEMENT OF COURT DECISIONS ON COMPULSORY VISITATION WITH NON-CUSTODIAL PARENTS

Хураангуй: Өнөө цагт дэлхий нийтийн асуудал болсон гэрлэлт цуцлалтаас үүссэн үр дагавар болох хүүхдийн асран хамгаалагч тогтоох, хууль ёсны асран хамгаалагчид хүүхдийг шилжүүлэн өгөх болон хүүхдийн тэтгэлэг гаргуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тоо өсөн нэмэгдэж байна. Үүнтэй холбоотойгоор гэр бүлийн тухай хууль болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэхэд шийдвэр гүйцэтгэгчийн зүгээс хүүхдийн эрхийг хангах, хамгаалахад онцгой анхаарал хандуулах шаардлагатай болж байна. Иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүүхдийн эрхийг хангах, хамгаалахад шүүх бүх төрлийн арга хэмжээг авч хэрэгжүүлэн хэвшсэн боловч шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хүүхдийн эрх, ашиг хөндөгдөх үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хууль, эрх зүйн актуудад тодорхой тусгаагүйгээс хүүхдийн эрхийн зөрчил өсөн нэмэгдэх хандлагатай байна. Иймд энэхүү

илтгэлээрээ гэр бүлийн маргаанаас үүдэлтэй иргэний хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагаанд хүүхдийн эрхийг хангахад анхаарах асуудлын талаар хөндсөн билээ.

Түлхүүр үгс: хүүхдийн эрх, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, гэр бүл, эрх зүйн зохицуулалт, төлбөр төлөгч, төлбөр авагч, шийдвэр гүйцэтгэгч, хүүхдийн тэтгэлэг

Abstract: *In recent years, the number of enforcement proceedings related to the transfer of children to their legal guardians and the enforcement of child support orders arising from divorce cases—a growing global issue—has been steadily increasing. Consequently, in implementing the coercive measures prescribed by the Family Law and the Law on Enforcement of Court Decisions, it has become essential for bailiffs to pay particular attention to protecting and ensuring the rights of the child. While the courts have developed well-established practices to safeguard children's rights during civil proceedings, there remains a lack of explicit legal provisions or procedures addressing the protection of children's rights during the enforcement stage. This gap has led to an increasing number of violations of children's rights during enforcement actions. Therefore, this paper discusses key considerations for ensuring the protection of children's rights in the enforcement of court decisions arising from family disputes.*

Keywords: *child's rights, enforcement proceedings, family, legal regulation, debtor, claimant, bailiff, child support*

I. УДИРТГАЛ

Хүн төрөлхтөний амьдралын хэв маяг болон эдийн засаг, нийгмийн соёлын өөрчлөлтүүдийг даган гэр бүлийн амьдралын хэлбэрүүд хувьсан өөрчлөгдөж байна. Гэр бүлийн бүтэц хэв маяг өөрчлөгдөж байгаа нь нийлмэл гэр бүлийн тоо ихэсч, улс дамнасан буюу олон улсын хөдөлмөр шилжилт хөдөлгөөний улмаас тусдаа амьдардаг гэр бүл бий болсоор байна. Дотоодын хөдөлмөр шилжилт хөдөлгөөний улмаас тусдаа амьдрах гэр бүлүүд ч мөн байна. Үүнтэй зэрэгцэн дахин гэр бүл болж буй хүмүүсийн тоо нэмэгдэж байгаа нь нөгөө талдаа олон сөрөг үр дагаврыг бий болгодог. Эдгээр хүчин зүйлсийн нөлөөгөөр нийгэмд үүсэж буй хамгийн том асуудал бол гэрлэлт цуцлалт юм. Гэрлэлт цуцлалтын улмаас үүсэн бий болж буй үр дагаврын хамгийн хүнд, сөрөг нөлөөллийг хүүхэд амсдаг.

Манай улсад гэрлэлт түүнтэй харьцуулах гэрлэлт цуцлалтын тоо жил ирэх тусам нэмэгдэх болсон бөгөөд Монгол Улсын хэмжээнд өдөрт 40 хос гэрлэлтээ бүртгүүлж, 10 гэр бүл гэрлэлтээ цуцлуулж байна гэсэн статистикийг Үндэсний статистикийн хорооноос гаргасан байдаг.¹ Гэрлэлт цуцалж буй гэр бүлийн хүүхдийн нас сэтгэл зүйн онцлогоос шалтгаалан сөрөг үйл явц

¹ Үндэсний статистикийн хороо, 2025 он.

ажиглагддаг. Энэ нь бага дунд, ахлах ангийн хүүхдүүд дээр илүү хүндээр тусдаг бөгөөд хүүхэд эцэг, эхийнхээ аль нэгийг сонгох болдог, эсвэл дунд нь хаягддаг, мөн гэр бүл салалтын шалтгааныг өөртөөгөө холбон ойлгож сэтгэл гутралд ордог гэх мэт асуудлууд бий. Гэрлэлтээ цуцлуулж байгаа хосуудын асуудал гэр бүлийн харилцаанд гарч буй нийгмийн шинжтэй хүндрэлтэй асуудлын нэг бөгөөд гэр бүл цуцлалтын гол хохирогч нь хүүхэд болж байгааг анхаарч, бодлогын түвшинд тухайн асуудлыг зохицуулах шаардлага үүсэж байна.

Сүүлийн жилүүдэд хосуудын хоорондын таарамжгүй харилцааны улмаас хүүхдээ төрсөн эх, эцэгтэйн уулзуулахгүй байх тохиолдолууд нэмэгдэж шүүхээс гэрлэлт цуцалж, хүүхдийн асрамж тогтоох, хүүхдийн тэтгэлэг гаргуулах шаардлагыг хангахаас гадна тусдаа амьдардаг эцэг, эхтэй нь тогтмол уулзуулж байх ажиллагааг албадан зохион байгуулах талаар шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрүүдийн тоо нэмэгдэж байна.

Үүнтэй зэрэгцээд шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны арга барил, зохион байгуулалтад өөрчлөлт орох шаардлагатай болж байгаа юм. Ихэнх тохиолдолд хүүхэд гэр бүлийн гишүүдтэйгээ ижил дасал болсон үед хүүхдийн асрамжийг өөрөөр тогтоож, хүүхдийг хүсээгүй үед энэ төрлийн ажиллагааг зохион байгуулах болдог. Ялангуяа нийлмэл гэр бүлийн тухайд хүүхэд өвөг эцэг, эмэг эхтэйгээ хамт өсөж, дассан үед хүүхдийн асрамжийг эцэг, эх болсон хүмүүст шилжүүлдэг нь биелүүлэхэд хамгийн хүндрэлтэй шийдвэрүүдийн нэг болдог байна.

Нөгөө талаас төрсөн цагаасаа хойш тусдаа амьдарч байсан гэр бүлүүдийн хувьд ч энэ асуудал бэрхшээлийг дагуулдаг. Үүнд хамгийн түрүүнд хүүхдийн сэтгэл зүйн асуудал хөндөгддөг.

Хүүхэд бүр эрүүл, аюулгүй орчинд өсөж, хөгжих, аливаа төрлийн хүчирхийллээс ангид байх эрхийг хангах, хамгаалахад чиглэсэн нийгмийн бүх салбарын үйл ажиллагаа, үйлчилгээ нь хүүхэд хамгааллын тогтолцоог бүрдүүлдэг байх ёстой. Хүүхэд хамгааллын үйл ажиллагаа нь мэргэжлийн, оролцоонд тулгуурласан, уялдаа холбоотой, цогц байх нь нэн чухал бөгөөд төрийн байгууллагын үйл ажиллагааг нэгдмэл байдлаар зохион байгуулснаар илүү үр дүнд хүрэх боломжтой юм.

Өнөөдрийн илтгэлээрээ шүүхээс хүүхдийн тэтгэлэг гаргуулахтай хамт шийдвэрлэсэн хүүхдийг хууль ёсны асран хамгаалагчид шилжүүлэн өгөх, тусдаа амьдардаг эцэг, эхтэй нь уулзуулах ажиллагааг албадан зохион байгуулах үеийн хүүхдийн эрхийн асуудлыг хөндөхийг зорьсон билээ.

II. ҮНДСЭН ХЭСЭГ

Монгол Улсын Үндсэн хуулийн 17 дугаар зүйлд зааснаар “үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх нь Монгол Улсын иргэний журамт үүрэг” гэж заасан бөгөөд эцэг,

эх нь хүүхдийг асран хамгаалах, тэжээн тэтгэх, эрүүл чийрэг өсгөн бойжуулах, сэтгэхүйн хувьд төлөвшүүлэх, үндэсний ёс заншил, уламжлалаа дээдлэх үзлээр хүмүүжүүлэх, түүнд суурь боловсрол эзэмшүүлэх, хөдөлмөрийн анхны дадал олгох зэрэг үүргийг хуулиар хүлээлгэсэн байна. Иймд монгол хүн бүр үр, хүүхдээ өсгөн хүмүүжүүлж, тэдний өмнө хариуцлагатай байх зарчимыг хуулиар тогтоосон. Гэр бүлийн харилцаа өөрийн гэсэн онцлогтой байх бөгөөд гэр бүлийн гишүүдийн эдийн бус амины харилцаа, итгэл үнэмшил, хайр сэтгэл гэх олон хүчин зүйлийн нөлөөллийг өөртөө агуулдаг. Харамсалтай нь гэрлэлт бүхэн аз жаргалтай төгсдөггүй бөгөөд гэрлэлт цуцлалтын маргааныг шүүхээр шийдвэрлүүлэх үед хүүхдийн асран хамгаалагч, тэтгэлэгийн хэмжээг тогтоох, эцэг, эхийн хувьд хүүхдийн өмнө хүлээсэн эрх үүргээ хэрэгжүүлэх боломжийн шийдлийг бий болгох шаардлагатай болдог.

Гэрлэлтийг цуцлахад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээг нэхэмжлэлийн шаардлагын хэмжээгээр тодорхойлох бөгөөд нийтлэг байдлаар дараах шаардлагыг хангаж шийдвэрлэх байдал түгээмэл байна. Үүнд:

1. Гэрлэлт цуцлах
2. Хүүхдийн асрамж тогтоолгох
3. Хүүхдийн тэтгэлэг тогтоолгох
4. Хүүхэдтэй уулзуулах талаар талууд харилцан тохиролцож эвлэрлийн гэрээг байгуулах зэрэг асуудлуудыг нийтлэг байдлаар шийдвэрлэж байна.

Монгол Улсын Гэр бүлийн тухай хуульд² зааснаар эцэг, эх нь насанд хүрээгүй болон насанд хүрсэн боловч хөдөлмөрийн чадваргүй хүүхдээ тэжээн тэтгэх үүрэгтэй. Энэхүү үүргээ эцэг, эх нь харилцан тохиролцож гэрээ байгуулан шийдвэрлэж болохоор хуульд заасан ба хэрэв тэтгэлгийн хэмжээг харилцан тохиролцоогүй, тохиролцоонд хүрч чадаагүй, гэрээ байгуулаагүй тохиолдолд тэтгэлгийн хэмжээг хүүхдийн насны байдлыг харгалзан шүүх тогтоодог. Хүүхдийг тэжээн тэтгэх үүрэг нь хүүхдийг эрүүл орчинд өсч хүмүүжүүлэхэд шаардлагатай хэрэгцээт наад захын зүйлсийг хангахад чиглэгддэг.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд³ заасны дагуу шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлээгүй тохиолдолд гүйцэтгэх хуудсыг үндэслэн албадан гүйцэтгэх ажиллагааг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаар гүйцэтгүүлнэ гэж заасан байдаг.

Хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагаа нь 1949 оны Шүүхийн зохион байгуулалтын хууль, 1952 оны Иргэний байцаан шийтгэх хууль, 1967 оны Иргэний байцаан шийтгэх тухай хууль, 1994 оны Шүүхийн шийдвэр

² Гэр бүлийн тухай хууль, 1999 он.

³ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2002 он.

биелүүлэх албаны тухай хууль, 1994 оны Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 1996 оны Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хууль, 1999 оны Гэр бүлийн тухай хууль, 2002 он болон 2017 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар тус тус зохицуулагдаж иржээ. Хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрээр гэрлэлт цуцлах, хүүхдийн асрамж тогтоох, тэтгэлэг гаргуулах болон хууль ёсны асран хамгаалагчид хүүхэд шилжүүлэн өгөх, тусдаа амьдардаг, эцэг, эхтэй нь тогтмол уулзуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагааг албадан гүйцэтгэх ажиллагааг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хэрэгжүүлж байна.

Хүүхэд гэдэг бол бие организм, сэтгэл зүй, ачаалал даах чадварын хувьд харьцангуй сул байдаг. Энэ үед нь тусдаа амьдардаг эцэг, эхтэй нь хүүхдийг албадан уулзуулах, цаашлаад хууль ёсны асран хамгаалагчид шилжүүлэн өгөх ажиллагаа нь сэтгэл зүйн хүнд цохилтуудыг хүүхдүүдэд өгсөөр байна. Хүүхэд насанд тохиолдсон аливаа төрлийн албадлага, хүч хэрэглэсэн байдал нь хүүхдийн сэтгэл зүйн гэмтэлд шууд хүргэдэг бөгөөд энэхүү гэмтэл нь тухайн хүүхдийн амьдралд тэр дундаа шийдвэр гаргалтад ухамсаргүйгээр шууд нөлөө үзүүлж байдаг байна.

Монгол Улсын хэмжээнд иргэний хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагаа явуулах эрх бүхий 300 орчим шийдвэр гүйцэтгэгч⁴ гардан зохион байгуулдаг. Хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагааг шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан журмын дагуу иргэнээс төлбөр гаргуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагааны нийтлэг аргачлалаар зохион байгуулж байна.

Шийдвэр гүйцэтгэх албаны 09 дүгээр сарын “Хүүхдийн тэтгэлгийн төлбөр барагдуулалтын мэдээ”-ээр нийт 19,655 гүйцэтгэх баримт бичигт хүүхдийн тэтгэлгийг төлүүлэх ажиллагааг Монгол Улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу зохион байгуулан ажиллаж байна.⁵ Энэхүү гүйцэтгэх баримт бичгийн 5 хувийг /ойролцоор жилд 1000 орчим/ хүүхдийн тэтгэлгийн хамт шийдвэрлэсэн хүүхдийг хууль ёсны асран хамгаалагчид шилжүүлэн өгөх, тусдаа амьдардаг эцэг, эхтэй нь албадан уулзуулах ажиллагаа эзэлдэг байна.⁶

Нийслэлийн тухайд Улаанбаатар хотын төвийн 7 дүүргийн хүүхдийн тэтгэлэг төлүүлэх албадлагын арга хэмжээг Банкны төлбөр барагдуулах газар хариуцан гүйцэтгэдэг. Банкны төлбөр барагдуулах газар нь нийт хүүхдийн тэтгэлгийн материалын 50 орчим хувийг дангаараа төвлөрүүлэн, өнөөдрийн

⁴ ШШГЕГ, Шүүхийн шийдвэрийн биелэлтэд нөлөөлөх хүчин зүйлс, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам хэлэлцүүлэг, 2023 он.

⁵ Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, 2025 он

⁶ Энэ төрлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар тусгайлсан мэдээний маягт байхгүй. Албан ёсны тоо баримт, судалгаа байхгүй тул Банкны төлбөр барагдуулах газрын бүртгэлээс дээрх тоон мэдээллийг боловсруулсан болно.

байдлаар 9035 гүйцэтгэх хуудас (БТБГ, 2025)-т холбогдох шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу гэр бүлийн маргаан бүхий шүүхийн шийдвэрт холбогдуулан иргэний хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зохион байгуулахдаа иргэнээс төлбөр гаргуулах ажиллагааны арга журмын дагуу гүйцэтгэдэг. Нэг талаараа төлбөр төлөгч иргэнээс хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагаа нь энэ төрлийн шүүхийн шийдвэрийг гүйцэтгэхэд гол шаардлага болж ирдэг. Үүнтэй холбоотой иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны мэдээ, судалгаа хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагаанд суурилан гардаг байна.

Хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагаанаас гадна хамгийн их анхаарал татсан 2 төрлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлэхэд шийдвэр гүйцэтгэгчийн зүгээс хүүхдийн эрхийг хангах, хамгаалахад онцгой анхаарал хандуулах шаардлага байна. Үүнд

1. Гүйцэтгэх баримт бичигт заасны дагуу хүүхдийг хууль бус асран хамгаалагчаас хууль ёсны асран хамгаалагчид хүлээлгэн өгөх шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тухайд авч үзье.

“Хүүхдийн эрхийн тухай конвенц”-ын 3 дугаар зүйлийн 1-т “...шүүх, захиргааны болон хууль тогтоох байгууллагаас хүүхдийн талаар явуулах аливаа үйл ажиллагаанд юуны өмнө хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангахад анхаарлаа хандуулна”, конвенцын 8 дугаар зүйлийн 2-т “хүүхэд хувийн байдлаа зарим талаар буюу бүхэлд нь хууль бусаар алдахад хүрвэл даруй сэргээн тогтооход чиглэсэн тусламж, хамгаалалт үзүүлнэ. Мөн 9 дүгээр зүйлийн 3-т “хүүхдийн дээд ашиг сонирхолд харшлахгүй бол эцэг, эхийнхээ аль нэгнээс буюу хоёулангаас салж хагацсан хүүхэд эцэг, эхийнхээ аль алинтай байнга хувийн болон шууд харилцаа холбоотой байх эрхийг оролцогч улсууд хүндэтгэнэ” гэж тус тус заасан байдаг.

Шүүхийн шийдвэр болон гүйцэтгэх баримт бичигт хүүхдийг хууль бус асран хамгаалагчаас хууль ёсны асран хамгаалагчид хүлээлгэн өгөхөөр тогтоосон бол дээрх үүргийг сайн дураараа биелүүлэхийг хариуцагч буюу төлбөр төлөгч этгээдээс шийдвэр гүйцэтгэгч шаардана. Дээрх шаардлагыг сайн дураараа биелүүлээгүй тохиолдолд тогтоосон үүргийг хангуулах албадлагын арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Хүүхдийг хууль бус асран хамгаалагчаас хууль ёсны асран хамгаалагчид хүлээлгэн өгөх үүргийг хангуулах хугацааг шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгч, бусад этгээдэд тогтоож, хүүхдийг шилжүүлбэл зохих этгээдэд хүлээлгэн өгч, холбогдох үйл явцыг тэмдэглэлээр баталгаажуулна. Шүүхийн шийдвэрт хүүхдийг хууль бус асран хамгаалагчаас (эцэг, эх, эмээ, өвөө) шилжүүлэн шүүхийн шийдвэрт заасан хууль ёсны асран хамгаалагчид (эх, эцэг) хүлээлгэн өгөхөөр шийдвэрлэсэн бол хүүхэд шилжүүлэх үүргийг

хангуулах хугацааг төлбөр төлөгч, бусад этгээдэд тогтоож, хүүхдийг асран хамгаалагчид хүлээлгэн өгч, холбогдох үйл явцыг баталгаажуулна. Шийдвэр гүйцэтгэгч шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулахдаа хүүхдийн оршин суух газрын өрхийн эмнэлэгтэй хамтран хүүхдийн биед эрүүл мэндийн үзлэг хийлгэж, ил шарх, сорви, бэртэл, гэмтэл байгаа эсэхийг нягтлан шалгаж, хүүхэд хүлээлцсэн тэмдэглэлд тусгаж, оролцогчоос гаргасан санал, хүсэлтийг шийдвэрлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.⁷ Энэ төрлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд шаардлагатай гэж үзвэл харьяалах нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага, хүүхдийн эрхийг хамгаалах төрийн болон төрийн бус байгууллага эсхүл нутгийн захиргааны байгууллагын төлөөллийг оролцуулан албадлагын арга хэмжээг хэрэгжүүлж болно.⁸

Хүүхдийг шилжүүлэх явцад асран хамгаалагчид тухайн хүүхэд асран хамгаалагчид очихоос татгалзсан, уг ажиллагааны явцад сэтгэл зүйн цочролд орсон үйлдэл гаргасан бол албадлагын арга хэмжээг түр хойшлуулж, дахин уулзалтыг товлон зохион байгуулна. Хүүхэд шилжүүлэх үүрэг хүлээсэн этгээд шүүхээс тогтоосон асрамжийг өөрчлөх, бусад үндэслэлээр шүүхэд нэхэмжлэл гаргасан бол тухайн хэрэг, маргааныг шийдвэрлэх хүртэл хугацаагаар албадлагын арга хэмжээг шүүгчийн захирамжаар түдгэлзүүлдэг. Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд гэр бүлийн гишүүд нэгнээ тэжээн тэтгэх харилцаа бүхий хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагааг нийтлэг байдлаар зохион байгуулж хэвшсэн боловч шүүхээс хүүхдийн тэтгэлэгийн хамт шийдвэрлэсэн хүүхдийн хууль ёсны асран хамгаалагчид шилжүүлэн өгөх ажиллагаа, тусдаа амьдардаг эцэг, эхтэй нь уулзуулах ажиллагааны талаар хуульчилсан, журамласан эрх зүйн хэм хэмжээг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд тусгайлан тусгаагүй байна. Үүнээс үүдэлтэйгээр энэ төрлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг эд хөрөнгө хүлээлгэн өгөх ажиллагаа мэтээр хэрэгжүүлэх хандлага бий болж болзошгүй нөхцөлд байна.

2. Хүүхдийг тусдаа амьдардаг эцэг, эхтэй нь уулзуулах ажиллагааг албадан гүйцэтгэх шийдвэр гүйцэтгэх ажиллагааны онцлог

Шүүхээс гэр бүл цуцалсан шийдвэрийг гаргахдаа хүүхдийг эцэг, эх болон хамаарал бүхий этгээдтэй нийтээр амрах болон баяр ёслолын өдрүүд түүнчлэн бусад хугацаанд (хүссэн үед) уулзуулахыг даалгах, долоо хоногт нэгээс доошгүй хоног хамт байлгахыг даалгах зэрэг олон төрлийн шийдвэрийг гаргадаг. Энэ тохиолдолд талууд харилцан тохиролцож хүүхдийг уулзуулах талаар эвлэрлийн гэрээг байгуулж тохиролцоогүй үед албадан гүйцэтгэх ажиллагааг зохион байгуулна. Талууд тодорхой үүргийг гүйцэтгэхтэй холбогдуулан эвлэрч, гэрээ байгуулсан бол иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгох ба гэрээний үүрэг зөрчсөн тохиолдолд албадлагын арга хэмжээг сэргээх үндэслэлийг талуудад танилцуулж, хууль

⁷ ШШГЕГ, Иргэний, захиргааны, зөрчлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, 2019 он.

⁸ ШШГЕГ, Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны дараалал, эрх зүйн зохицуулалт, 2022 он.

сануулж, шийдвэр гүйцэтгэгч тэмдэглэл үйлдэж баталгаажуулна.

Энэ талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд тодорхой хуульчилж өгөөгүйгээс гадна шүүхийн шийдвэрээр оногдуулсан үүргийг биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх хууль зүйн хариуцлагыг Зөрчлийн тухай хууль болон Эрүүгийн хуульд тусгаагүй байна.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн үзэл баримтлал нь гэр бүл, сургууль нийгмийн орчинд хүүхдийг эрхийг зөрчигдөхөөс хамгаалах, гэр бүлийн хүчирхийллийн үед аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн байх бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үеийн хүүхэд хамгааллын асуудлыг зохицуулсан боловч хууль сахиулах ажиллагааны үед тэр тусмаа шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх үед хүүхдийн эрхийг хэрхэн хангах хамгаалах талаар зохицуулалтыг орхигдуулсан байна. Мөн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зохион байгуулах арга журмыг тодорхойлсон шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх үед хүүхэд

Шигтгээ

2015 оны 05 дугаар сард Сонгинохайрхан дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрээр /хувийн мэдээллийг нууцлах зорилгоор товч агуулгыг тусгав/ 7 настай хүүг хууль ёсны асран хамгаалагчид /эх/ шилжүүлэн өгч, хариуцагчаас /эцэг/ хүүхдийн тэтгэлэг гаргуулж, нэхэмжлэгчид олгохоор шийдвэрлэсэн шийдвэрийг албадан гүйцэтгэх үүрэг Банкны төлбөр барагдуулах газарт ирсэн юм. Тухайн үед шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талуудыг байлцуулан хүүхдийг хууль ёсны асран хамгаалагчид хүлээлгэн өгөх талаар ярилцаж, олон удаагийн уулзалт товлоод амжилтыг олоогүй. Төлбөр авагчийн зүгээс хүүгээ авахыг өдөр бүр шийдвэр гүйцэтгэгчээс шаардаж, төлбөр төлөгчийн хувьд аргагүй хүнд байдалд орж байгаага учирлах байдлаар цаг хугааг нилээдгүй үрсэн. Энэ тохиолдолд хүү төрсөн цагаасаа хойш ээжтэйгээ уулзаагүй, ээжийгээ танихгүй учраас ээжийнхээ асрамжинд очихоос татгалздаг байсан юм. Энэ хугацаанд хүүхдийн сэтгэл зүйн байдлыг тогтворжуулах нийгмийн ажилтан, сэтгэл зүйч аль нь ч ажиллаагүй бөгөөд хүүг ээжтэйгээ уулзаж ойлголцож, дотносох боломжийг бүрдүүлэлгүй шийдвэр гүйцэтгэх ажиллагааны шуурхай байдлыг хангах, шүүхийн шийдвэрийг гарцаагүй биелүүлэх

зарчимд хөтлөгдөн хүүг эцгээс нь хүчээр салгаж уйлуулсаар эхэд нь хүлээлгэн өгсөн.

Түүнээс хойш хүүд ямар хүндрэл бэрхшээл тулгарсан, сэтгэл зүйн байдал тогтвортой байсан эсэх, орчиндоо хэр хугацааны дараа дассан дасаагүй, энэ ажиллагаанаас үүдэлтэй сэтгэл зүйн гэмтэл үүссэн эсэх асуудалд хэн ч анхаарлаа хандуулаагүй. Одоо ч энэ төрлийн ажиллагааг гүйцэтгэхдээ хүүхдийг эд хөрөнгө шилжүүлэх ажиллагаатай адилтган албадан шилжүүлж байгаа нь өнөөдрийн хамгийн эмзэг сэдэв болоод байна.

Дээрх тохиолдлоос авч үзвэл шүүхийн шийдвэр гарцаагүй биелэгдэх, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг шуурхай зохион байгуулахаас илүүтэйгээр хүүхдийн дээд эрх ашиг, сонирхлыг хангах, хамгаалахад анхаарах зайлшгүй шаардлагатай байгааг харуулж байна.

Угтаа бол энэ төрлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд холбогдуулан хүүхэд хамгааллын зарчмыг баримтлан, хүүхэд өөрийн үзэл бодлоо илэрхийлэх, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар санал, хүсэлтээ гаргах, хүүхдийн хувийн сэтгэл зүйн онцлогт тохирсон байдлаар уулзалт ярилцагыг үе шаттай зохион байгуулах болон албадлагын арга хэмжээнд хүүхдийн сэтгэл зүйч, нийгмийн ажилтан зэрэг мэргэжлийн байгууллагын төлөөллийн татан оролцуулж хүүхдийн эрхийг хангах боломжийг бий болгоход анхаарах хэрэгтэй юм.

Мөн энэ төрлийн албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэхдээ хүүхдийн сэтгэл зүйн хэвийн байдлыг хангахын тулд алба хаагч хүүхдэд ээлтэй орчинд энгийн хувцастай үүрэг гүйцэтгэх хэрэгцээ шаардлага хүртэл бий болно. Мөн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад хүүхдэд хүч хэрэглэх болон аливаа албадлагыг хэрэглэхгүй байхад анхаарах шаардлагатай байна.

Хүүхдийг асран хамгаалагчид шилжүүлэн өгөх ажиллагаа болон тусдаа амьдардаг эцэг, эхтэй нь уулзуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зохион байгуулах үед шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талуудад аюулгүй байдлын зааварчилгаа өгч байх шаардлагатай бөгөөд хүүхдийн өмнө үүрэг хүлээсэн этгээд энэ төрлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулсан үйлдэл, эс үйлдэхүйд хүлээлгэх хариуцлагыг Зөрчлийн тухай хуульд хуульчилж өгөх хэрэгцээ, шаардлагатай байна.

III. ДҮГНЭЛТ

Илтгэлийн хүрээнд дараах дүгнэлтүүдийг гаргаж байна.

1. Улсын хэмжээнд хүүхдийн тэтгэлэг гаргуулах, хүүхдийг хууль ёсны асран хамгаалагчид шилжүүлэхтэй холбоотой 19000 орчим гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явагдаж байна. Эдгээрээс 5 орчим хувь буюу жилд 1000 орчим гүйцэтгэх баримт бичигт хүүхдийг хууль ёсны асаран хамгаалагчид шилжүүлэн өгөх, тусдаа амьдардаг эцэг, эхтэй нь албадан уулзуулах ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна. Тиймээс энэ төрлийн албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэхэд хүүхдийн эрхийг хангах, хамгаалах, хүүхдийн аюулгүй байдлыг хангах тусгайлсан зарчим, үзэл санаа бүхий хууль зүйн зохицуулалт шаардлагатай байгааг харуулж байна.

2. Хүүхдийн бие, сэтгэл зүй гадаад орчны нөлөөлөлд ихээхэн мэдрэг тул хүүхэдтэй холбоотой шүүхийн шийдвэр албадан гүйцэтгэх ажиллагаа нь хүүхдийн сэтгэл зүйн онцлог хүчин зүйлсэд тохирсон байх шаардлагатай. Энэхүү онцлог байдлыг процессын хуульд тусгаж өгөөгүйгээс хүүхдийн эрх, ашиг сонирхолыг албадан гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлэхдээ хууль сахиулагчийн зүгээс харгалзан үзэхгүй байгаа нь хүүхдийн эрхийн зөрчлүүдэд хүргэж байна.

Шүүхийн шийдвэрийг шуурхай бөгөөд бүрэн бодитой биелүүлэх хуулиар хүлээсэн үүрэг хүлээсэн хууль сахиулагчийн хувьд ч хүүхдийн тэтгэлэг гаргуулах болон, хүүхдийг хууль ёсны асран хамгаалагчид шилжүүлэн өгөх, тусдаа амьдардаг эцэг, эхтэй нь албадан уулзуулах үед хүнлэг бөгөөд хүүхдийн амьдрал, ирээдүйтэй холбоотой ажиллагаа гэдгийг санан, иргэнээс төлбөр гаргуулах нийтлэг ажиллагаанаас гадна гэр бүлийн эдийн бус амины харилцаа бүхий асуудалд хүүхэд хамгааллын зарчмыг баримталж, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зохион байгуулах шаардлагатай байна.

3. Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь төрийн албадлагын онцгой хэлбэр хэдий ч аливаа албадлагын арга хэмжээ нь хүүхэд хэрхэн хортойгоор нөлөөлдөг болохыг хууль сахиулагчийн зүгээс анхаарах хэрэгтэй. Шүүхийн шийдвэр гарцаагүй биелэгдэж, биелэлтийг хангуулах үүрэгтэй хэдий ч хүүхэдтэй холбоотой шийдвэр гүйцэтгэх ажиллагааг эд хөрөнгө гаргуулах, шилжүүлэх ажиллагаатай адилтган үзэж хэзээ ч болохгүй юм. Иймд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн актуудад хүүхдийн эрхийг хангах, хамгаалахад чиглэсэн зарчим, зохицуулалт, аюулгүй ажиллагааны зааварчилгааг боловсруулан мөрдүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

IV. САНАЛ

1. Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хүүхдийг татан оролцуулах үед хүүхдийн сэтгэл зүйн байдлыг тодорхойлсон тодорхойлолтыг үндэслэн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зохион байгуулдаг байх.
2. Хүүхэд уулзуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зохион байгуулах аюулгүй байдлын зааварчилгаа боловсруулах шаарлагатай.
3. Хүүхдийн дээд эрх ашгийг хангаж хамгаалахыг удирдлага болгож түүний өөрийгөө илэрхийлсэн байдлыг үндэслэн тогтоол, шийдвэр гаргадаг байх.
4. Хүүхдийг эцэг, эхтэй нь хамт уулзуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үед хүүхдийн сэтгэл зүйн болон бие махбодын аливаа хүчирхийллээс ангид байлгах талаар хууль сануулж, аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх.
5. Шаардлагатай тохиолдолд хүүхдийн сэтгэл зүйч, хүүхэд хамгааллын ажилтныг шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд татан оролцуулдаг байх.
6. Хүүхдийн сэтгэл зүй тогтворгүй эсэргүүцэл үзүүлэх үед албадлага хэрэглэхээс зайлсхийх.
7. Хүүхдийн уулзалт хийх өрөөг газар, хэлтэс дээр бий болгож, хүүхдэд ээлтэй орчинг бүрдүүлэх.

V. НОМ ЗҮЙ

Эх сурвалж

1. БТБГ. (2025). Хүүхдийн тэтгэлгийн 10 сарын мэдээ. Улаанбаатар: ШГА.
2. ХЗҮХ. (1989 оны 11 20). Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. www.legalinfo.mn: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=1276>-ээс Гаргасан
3. ХЗҮХ. (1999). Гэр бүлийн тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл, №30.
4. ХЗҮХ. (2002). Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл, №8.
5. ХЗҮХ. (2025 оны 10 27). www.legalinfo.mn. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=367>-ээс Гаргасан
6. Үндэстний статистикийн хороо, Ү. с. (2025 оны 10 27). www.1212.mn. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан: <https://www.1212.mn/mn>-ээс Гаргасан
7. ХЭҮК. (2025 оны 10 27). МУ дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл. www.Legaldata.mn: <https://legaldata.mn/buteel/pdf?id=1590>-ээс Гаргасан
8. ШГА. (2025). Хүүхдийн тэтгэлэг барагдуулалтын 2025 оны 10 дугаар сарын мэдээ. Улаанбаатар: ШГА.

9. ШШГЕГ. (2019). Иргэний, захиргааны, зөрчлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа . Улаанбаатар: ШГА.
10. ШШГЕГ. (2022). Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны дараалал, эрх зүйн зохицуулалт. Улаанбаатар хот: ШГА.
11. ШШГЕГ. (2023). Шүүхийн шийдвэрийн биелэлтэд нөлөөлөх хүчин зүйлс, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам хэлэлцүүлэг. Шүүхийн шийдвэрийн биелэлтэд нөлөөлөх хүчин зүйлс, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам хэлэлцүүлэг (хууд. 48). Улаанбаатар: ШШГЕГ.
12. Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл эмхтгэл. УБ., 1992 он. №01
13. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Төрийн мэдээлэл эмхтгэл. УБ., 2017 он. №24

UIH.MN
СУДАЛГААНЫ САН



Б.БОЛОО

Улс төр судлалын магистр, хөгжлийн бэрхшээлийн ойлголт түгээх трэйнер

ЧИМЭЭГҮЙ ХАШГИРААН

SILENT SCREAM

Хураангуй: Үндэсний статистикийн хорооны 2024 оны тоон мэдээгээр Монгол Улсын нийт хүн амын 3.3 хувь нь буюу 107.9 мянган хөгжлийн бэрхшээлтэй хүн байгаа бөгөөд тэдний 21.2 мянга нь оюун, сэтгэцийн бэрхшээлтэй иргэд байна.

Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцод эрх зүйн чадамжтай байх эрхийг маш тодорхой тусгасан байдаг. Тухайлбал, Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 6 дугаар зүйлд “Хүн бүр хаана ч байсан эрх зүйн чадвартай байх эрхээ хүлээн зөвшөөрүүлэх эрхтэй, 8 дугаар зүйлд “Үндсэн хууль болон бусад хуулиар олгосон үндсэн эрх нь зөрчигдвөл хүн бүр эрх мэдэл бүхий үндэсний шүүхээр эрхээ бүрэн сэргээн тогтоолгох эрхтэй”, харин Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 16 дугаар зүйлд “Хүн бүр хаана ч эрх зүйн чадвартай байх эрхээ хүлээн зөвшөөрүүлэх эрхтэй” гэж, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 6 дугаар зүйлд “Энэхүү Пактад оролцогч улсууд түүнд заасан эдийн засаг, нийгэм, соёлын бүх эрхийг эрэгтэй, эмэгтэйчүүдэд тэгш эдлүүлэх нөхцөлийг хангах үүрэгтэй” гэж тус тус заасан байдаг.

Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 11-д “улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын

тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална” гэж заасан байдаг. Гэвч энэ заалт хөгжлийн бэрхшээлтэй хүн, түүн дотроо оюун, сэтгэцийн бэрхшээлтэй хүнд үйлчлэхгүй байгаагаас гадна дээр дурдсан эрхүүдээ эдэлж чадахгүй байна.

Учир нь Иргэний хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т “Сэтгэцийн өвчний улмаас өөрийн үйлдлийн учир холбогдлыг ойлгохгүй, өөрийгөө зөв удирдаж чадахгүй болсон этгээдийг шүүх иргэний эрх зүйн чадамжгүй гэж тооцож, түүнд асран хамгаалалт тогтооно.” гэж, Гэр бүлийн тухай хуулийн 9.1.6-д “гэрлэгчдийн хэн нэг нь, эсхүл хоёулаа удамших хандлагатай сэтгэцийн архаг өвчтэй бол” гэрлэлтийг хориглох, 58.3.2-д хүүхэд үрчлэн авахдаа “үрчлэгч нь сүрьеэ, ДОХ, сэтгэцийн өвчтэй эсэх талаарх эмнэлгийн магадлагаа” авчирна, Сонгуулийн багц хуулинд сонгох эрхээ эдлэхгүй иргэнд сэтгэцийн бэрхшээлтэй хүнийг оруулсан байдаг нь өөрөө Үндсэн хуулиа зөрчсөн хууль тогтоомж байгааг харуулж байгаа юм. Өөрөөр хэлбэл Үндсэн хууль “сэтгэц” гэсэн тодотголоор хэн нэгний эрхийг хязгаарлаагүй байхад дээрх хуулиудаар эдгээр иргэний эрхийг хязгаарласаар байна, хүний эдлэх ёстой суурь эрхүүдээс “өөрийн оролцоогүйгээр, автоматаар татгалзах”-д хүргэж, “өөр сонголт” байхгүй, бий болгохгүй байсаар байна.

Иймд оюуны бэрхшээлтэй иргэдийн “эрх зүйн чадамж”-ийг сэргээж, эрхийг нь эдлүүлэх тухай асуудлыг хөндсөн.

Түлхүүр үг: Иргэний хууль, сэтгэцийн бэрхшээл, эрх зүйн чадамж, эрх, конвенц, эрхийн зөрчил.

Abstract: According to 2024 data from National Statistics Office of Mongolia, persons with disabilities represent 3.3 percent of the population, which is 107,900 people. Of these, 21,200 have intellectual and psychosocial disabilities. International treaties and conventions to which Mongolia is a State Party clearly affirm the right to legal capacity. Article 6 of the Universal Declaration of Human Rights states that “Everyone has the right to recognition everywhere as a person before the law,” while Article 8 affirms that “Everyone has the right to an effective remedy by the competent national tribunals for acts violating the fundamental rights granted him by the constitution or by law.” Similarly, Article 16 of the International Covenant on Civil and Political Rights declares that “Everyone shall have the right to recognition everywhere as a person before the law.” Article 6 of the International Covenant on Economic, Social and Cultural Rights recognizes “the right to work” and commits States Parties to ensuring equal enjoyment of all economic, social, and cultural rights by both men and women.

Article 16.11 of Mongolia’s Constitution states: “Men and women shall have equal rights in political, economic, social, cultural life, and in family relations. Marriage shall be based on the equality and voluntary union of an adult man and woman

as prescribed by law. The State shall protect the interests of the family, mothers, infants, and children.” In practice, however, this provision does not extend to people with disabilities, particularly those with intellectual or psychosocial disabilities, who remain unable to fully exercise these fundamental rights.

This is because Article 18.2 of the Civil Code provides: “A person who, due to mental illness, does not understand the meaning of his/her actions and is incapable of managing his/her behavior shall be declared by the court as having no legal capacity and placed under guardianship. “The Family Law further restricts rights:

- Article 9.1.6 prohibits marriage if one or both parties have a chronic hereditary mental illness
- Article 58.3.2 requires prospective adoptive parents to present medical certificates proving they do not have tuberculosis, HIV/AIDS, or mental illness

Furthermore, the Election Law places people with psychosocial disabilities in the category of individuals who are not permitted to exercise the right to vote. These restrictions contradict the Constitution, which does not limit rights based on mental disability.

Consequently, these laws unjustly deprive people with intellectual or psychosocial disabilities of their fundamental rights, rights that should never be forfeited automatically and without personal consent. They are denied access to alternative decision-making mechanisms, preventing them from living independently and participating fully in society.

This paper therefore addresses the critical issue of restoring legal capacity to people with intellectual disabilities and ensuring their full enjoyment of rights.

Keywords: Civil Code, psychosocial disability, legal capacity, rights, conventions, human rights violations.

I. УДИРТГАЛ

Үндсэн хууль дээр хүний эрхийг л дээд зэргээр тунхаглаагүй бол түүнийг Үндсэн хууль гэж үзэхгүй гэдэг. Өөрөөр хэлбэл Үндсэн хууль дээрээ хүний эрхийг хангасан байдлаар томьёолж, үүнийгээ хамгаалах, бэхжүүлэх тогтолцоог тусгасан бол сайн Үндсэн хууль гэж үздэг. Энэ утгаараа Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд¹ Монгол Улсын иргэн бүрийн баталгаатай эдлэх ёстой 18 эрхийг зааж өгсөн. Бүр тодруулж, нарийвчлан үзвэл 18-аас илүү эрхийг жагсаан бичсэн байдаг.

Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 11-д “улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. Гэрлэлт

¹ <https://legalinfo.mn/mn/detail?lawid=367>

нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална” гэж заасан байдаг. Гэвч энэ заалт хөгжлийн бэрхшээлтэй хүн, түүн дотроо оюун, сэтгэцийн бэрхшээлтэй хүнд үйлчлэхгүй байгаагаас гадна дээр дурдсан эрхүүдээ эдэлж чадахгүй байна.

Учир нь Иргэний хуулийн² 18 дугаар зүйлийн 18.2-т “Сэтгэцийн өвчний улмаас өөрийн үйлдлийн учир холбогдлыг ойлгохгүй, өөрийгөө зөв удирдаж чадахгүй болсон этгээдийг шүүх иргэний эрх зүйн чадамжгүй гэж тооцож, түүнд асран хамгаалалт тогтооно.” гэж, Гэр бүлийн тухай³ хуулийн 9.1.6-д “гэрлэгчдийн хэн нэг нь, эсхүл хоёулаа удамших хандлагатай сэтгэцийн архаг өвчтэй бол” гэрлэлтийг хориглох, 58.3.2-д хүүхэд үрчлэн авчрахдаа “үрчлэгч нь сүрьеэ, ДОХ, сэтгэцийн өвчтэй эсэх талаархи эмнэлгийн магадлагаа” авчирна, Сонгуулийн багц хуулинд сонгох эрхээ эдлэхгүй иргэнд сэтгэцийн бэрхшээлтэй хүнийг оруулсан байдаг нь өөрөө Үндсэн хуулиа зөрчсөн хууль тогтоомж байгааг харуулж байгаа юм. Өөрөөр хэлбэл Үндсэн хууль “сэтгэц” гэсэн тодотголоор хэн нэгний эрхийг хязгаарлаагүй байхад дээрх хуулиудаар эдгээр иргэний эрхийг хязгаарласаар байна, хүний эдлэх ёстой суурь эрхүүдээс “өөрийн оролцоогүйгээр, автоматаар татгалзах”-д хүргэж, “өөр сонголт” байхгүй, бий болгохгүй байсаар байна.

Монгол Улсын Засгийн газар дэлхий нийтийн хүний эрхийг хангах, хамгаалах суурь баримт бичиг болох Хүний эрхийн түгээмэл тунхаглал⁴, Эдийн засаг, нийгэм, соёлын пакт⁵, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт⁶, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцод⁷ нэгдэн орсон байдаг. Тэгвэл дээрх олон улсын гэрээ, конвенцод эрх зүйн чадамжтай байх эрхийг маш тодорхой тусгасан байдаг. Тухайлбал, Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 6 дугаар зүйлд “Хүн бүр хаана ч байсан эрх зүйн чадвартай байх эрхээ хүлээн зөвшөөрүүлэх эрхтэй, 8 дугаар зүйлд “Үндсэн хууль болон бусад хуулиар олгосон үндсэн эрх нь зөрчигдвөл хүн бүр эрх мэдэл бүхий үндэсний шүүхээр эрхээ бүрэн сэргээн тогтоолгох эрхтэй”, харин Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 16 дугаар зүйлд “Хүн бүр хаана ч эрх зүйн чадвартай байх эрхээ хүлээн зөвшөөрүүлэх эрхтэй” гэж, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 6 дугаар зүйлд “Энэхүү Пактад оролцогч улсууд түүнд заасан эдийн засаг, нийгэм, соёлын бүх эрхийг эрэгтэй, эмэгтэйчүүдэд тэгш эдлүүлэх нөхцөлийг хангах үүрэгтэй” гэж тус тус заасан байдаг.

² <https://legalinfo.mn/mn/detail?lawId=299>

³ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=226>

⁴ <https://legalinfo.mn/mn/detail/1271>

⁵ <https://legalinfo.mn/mn/detail/1284>

⁶ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=1257>

⁷ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=10034>

Харин хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах, хамгаалах суурь баримт бичиг болох Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцын 12 дугаар зүйл буюу Хуулийн өмнө тэгш байх эрхийн хүрээнд эрх зүйн чадамжтай хамаарах зохицуулалтыг дараах байдлаар тусгасан байна.

II. 12 ДУГААР ЗҮЙЛ. ХУУЛИЙН ӨМНӨ ТЭГШ БАЙХ ЭРХ

1. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь бусад хүний нэгэн адил хуулийн өмнө адил тэгш байх эрхтэйг дахин нотолж байна.
2. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь амьдралын бүхий л хүрээнд бусадтай адил тэгш байх үндсэн дээр эрх зүйн чадамжтай байх явдлыг хүлээн зөвшөөрнө.
3. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эрх зүйн чадамжаа хэрэгжүүлэхэд нь шаардагдах дэмжлэг туслалцааг хүртээмжтэй байлгах үүднээс шаардлагатай арга хэмжээ авна.
4. Оролцогч улсууд нь эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй, зохистой хамгаалалтыг бий болгохуйц эрх зүйн чадамжаа хэрэгжүүлэхтэй холбогдсон бүх арга хэмжээг олон улсын хүний эрхийн хэм хэмжээний дагуу авна. Эрх зүйн чадамжийг хэрэгжүүлэхтэй холбогдсон ийм хамгаалалт нь тухайн хүний сонголт, хүсэл зоригт нийцсэн, эрхийг хүндэтгэсэн, сонирхлын зөрчилгүй, сөрөг нөлөөгүй, хувийн нөхцөл байдалд нь тохирсон, байж болох хамгийн богино хугацаанд байх бөгөөд бүрэн эрхт, хараат бус, бие даасан байгууллага, эсхүл шүүхийн зохих шатны байгууллага түүнийг тогтмол хянаж байна. Эдгээр хамгаалалт нь тухайн хүний эрх, ашиг сонирхол аль хэр хөндөгдөнө төдий чинээний хэмжээтэй байна.
5. Энэ зүйлийн заалтуудын дагуу оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эд хөрөнгө эзэмших, түүнийг өвлөх, санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх болон банкны зээл, үл хөдлөх хөрөнгийн барьцаат зээл болон бусад төрлийн санхүүгийн үйлчилгээг тэгш хүртэх эрхийг баталгаажуулах зорилгоор шаардлагатай, үр дүнтэй арга хэмжээ авах бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүний эд хөрөнгийг хүсэл зоригийг нь үл хамааран хураахгүй байх явдлыг баталгаажуулна.” гэж заасан байна.

Монгол Улсын Засгийн газраас Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцын хэрэгжилтийн анхны тайланг 2011 онд, 2 болон 3 дугаар тайланг хамтатган богино асуумжийн дагуу 2019 онд хүргүүлсэн ч коронавирус цар тахлын улмаас хэлэлцэгдэх байдал хойшилсоор 2023 онд нэмэлт тайланг хүргүүсэн. Харин НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хороо эхний тайланг 2015 онд, 2 болон 3 дугаар тайланг 2023 онд хэлэлцэн тухай бүртээ зөвлөмжийг ирүүлсэн.

Тодруулбал 2015 онд Монгол Улсын Засгийн газарт 37 зөвлөмж, 3 шаардлага, 1 хүсэлт ирүүлсэн ба үүндээ “Хаана, хэнтэй амьдрахаа сонгох, өөрийн дэмжиж байгаа улс төрийн намд санал өгөх, эрүүл мэндийн тусламж дэмжлэгийн талаарх өөрийн гаргасан шийдвэрийг хүндэтгэн үзэх, өөрийн санхүүгийн байдлыг өөрөө хянах, кино, бусад чөлөөт цаг өнгөрүүлэх газар болон соёлын арга хэмжээнүүд хүртээмжтэй байх зэрэг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хуулийн чадамжийг баталгаажуулахыг Хороо Оролцогч улсаас шаардаж байна. Мөн Конвенцын 12 дугаар зүйл болон зөвшөөрөлтэйгөөр эмчилгээг хийлгэх, болих эрх, хүртээмжтэй шүүхээр үйлчлүүлэх, санал өгөх, гэрлэх, эцэг эх байх эрх, ажил хөдөлмөр эрхлэх, өөрийн оршин суух газрыг сонгох зэрэг хувь хүний эрхүүдийг хүндэтгэн үзэж Хорооны ерөнхий зөвлөмж №1-ийг бүрэн хэрэгжүүлж Иргэний эрхийн хуулиас хувь хүний бие даасан, хараат бус байдлыг хүндэтгэн үзэж орон шийдвэр гаргахаас тусламжтайгаар шийдвэр гаргах нөхцөл байдалд шилжихийг Хороо зөвлөж байна. Мөн Оролцогч улсыг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй болон тэдний эрх ашгийг хамгаалдаг байгууллагуудтай хамтран ажиллаж, зөвлөлдөн үндэсний, бүсийн болон орон нутгийн түвшинд төрийн албан хаагч, шүүгч, нийгмийн ажилтнуудад тусламжтайгаар шийдвэр гаргах механизмын талаар болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хуулийн чадамжийн талаар сургалт зохион байгуулахыг Хороо зөвлөж байна.” гэж, 2023 онд 35 зөвлөмжийг ирүүлэхдээ “Хороо нь сэтгэц-нийгмийн болон оюуны бэрхшээлтэй гэсэн үндэслэлээр хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх зүйн чадамжийг хязгаарлаж буй Иргэний хуульд заасан асран хамгааллын болон төлөөлөн шийдвэр гаргах дэглэмийг халахад ахиц гараагүй, мөн энэ тогтолцоог дэмжлэгт шийдвэр гаргах тогтолцоогоор бүрэн солих хугацаа заах тал дээр дэвшил байхгүй байгаад санаа зовниж байна. Хороо нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон тэдний гэр бүлд дэмжлэгтэйгээр шийдвэр гаргах тухай ойлголтыг нэмэгдүүлэхэд хүртээмжтэй мэдээлэл дутмаг байгаад санаа зовниж байна. Асран хамгаалагч, харгалзан дэмжигч зэргийг оролцуулан төлөөлөн шийдвэр гаргах тогтолцоотой холбоотой бүх ялгаварлан гадуурхсан хуулийн заалтыг хүчингүй болгож, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бие даасан байдал, хүсэл зориг, сонголтыг хүндэтгэж хувь хүн өөрөө шийдвэр гаргахыг баталгаажуулсан дэмжлэгтэйгээр шийдвэр гаргах тогтолцоог бий болгох, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх зүйн чадамжийг хүлээн зөвшөөрөх тухай, дэмжлэгтэйгээр шийдвэр гаргах тогтолцооны механизмын талаар холбогдох боловсон хүчнийг сургах болон шинэчлэх үйл явцдаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг тэдгээрийн төлөөллийн байгууллагуудаар дамжуулан үр дүнтэй, бие даасан байдлаар оролцох боломжоор хангах арга хэмжээ ав хэрэгжүүлэхийг зөвлөж байна” гэсэн байна.⁸

⁸ Юнеско, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам., (2024), Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хорооноос Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцын хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр Монгол Улсын Засгийн газарт 2015, 2023 онуудад ирүүлсэн зөвлөмжийн гарын авлага, Улаанбаатар хот.

Хөгжлийн бэрхшээлийн талаарх дэлхий нийтийн чиг хандлагыг тодорхойлсон Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцод 2009 онд нэгдэн орсноороо Монгол Улс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг бусдын адил эрхээ эдэлж, сурч боловсрох, хөгжих, хөдөлмөрлөх, төрийн үйлчилгээ авах, хөгжлийн үр шимээс хүртэх адил, тэгш боломж олгох талаар зохих арга хэмжээг авах үүргийг олон улсын өмнө хүлээсэн юм.

Энэ ч утгаараа конвенцын үзэл баримтлал, зарчимд тулгуурласан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг⁹ 2016 онд Улсын Их Хурлаас батласнаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих, нийгмийн хамгааллыг сайжруулах, тэдний онцлог, чадварт нь тохирсон ажлын байраар хангах, үйлчилгээг сайжруулах чиглэлээр эрх зүйн орчинг боловсронгуй болгох, хэрэгжилтийг эрчимжүүлэх, төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр олон арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэхэд салбар дундын уялдаа холбоог хангах үүднээс 2016 оноос Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах үндэсний зөвлөл, бүх яамд дээр дэд зөвлөл, бүх аймагт салбар зөвлөл байгуулан ажиллуулж байна. Тус зөвлөлүүдэд яамд, холбогдох төрийн байгууллагын удирдах ажилтан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллага, мөн хөгжлийн бэрхшээлийн хэлбэр тус бүрийн төлөөллийг оруулсан байдаг. Тус зөвлөлийн ажиллах журамд заасны дагуу зөвлөл бүр оны эхэнд тухайн жилд хийж хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, жилийн эцэст тайлагнадаг юм.

Түүнчлэн хууль болон конвенцын хэрэгжилтийг хангахад мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах үүрэг бүхий Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрыг 2018 онд Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэрээр байгуулан ажиллаж байна. Агентлаг нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенц, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль болон холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилт, салбар дундын зохицуулалтыг хангах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөгжих, нийгмийн амьдралд оролцох оролцоог дэмжих, төрийн үйлчилгээнд хамрагдахад нь туслах чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна.

Гэвч дээрх зөвлөлөөс гардаг төлөвлөгөөнд оюуны болон сэтгэцийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн нэг ч арга хэмжээ байдаггүйгээс гадна асуудал хариуцсан төрийн байгууллагууд нь ч энэ чиглэлд анхаарал хандуулахгүй байгаа нь оюун, сэтгэцийн бэрхшээлтэй иргэдийг “хөгжлийн гадна үлдээж, ХАЯЖЭЭ”.

Монгол Улс Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцыг нэмэлт, протоколтой нь хамтад нь соёрхон баталсан цөөн улсын хувьд

⁹ <https://legalinfo.mn/mn/detail/11711>

хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд конвенцын хэрэгжилтийн талаарх сүүдэр илтгэлийг боловсруулж, НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хороонд хүргүүлэх эрх олгосон нь маш ач холбогдолтой юм.

III. МОНГОЛ УЛСАД АМЬДАРЧ БУЙ ОЮУН, СЭТГЭЦИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ЭРХҮҮДИЙН ЗӨРЧЛИЙГ ХУРААНГУЙЛАН ТОВЧ БАЙДЛААР БИЧЬЕ.

1. Үндэсний статистикийн хорооны 2024 оны тоон мэдээгээр Монгол Улсын нийт хүн амын 3.3 хувь нь буюу 107.9 мянган хөгжлийн бэрхшээлтэй хүн байгаа бөгөөд тэдний 21.2 мянга нь оюун, сэтгэцийн бэрхшээлтэй иргэд байна. Харин хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн болон оюун, сэтгэцийн бэрхшээлтэй иргэдийн тоог 10 жилийн өмнөх байдалтай нь харьцуулахад 2014 онд 99.5 мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэн байснаас оюун, сэтгэцийн бэрхшээлтэй иргэд 16.9 мянга байна.¹⁰ Өөрөөр хэлбэл нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 17-22 хувь нь оюун, сэтгэцийн бэрхшээлтэй иргэд байна. Эндээс оюун, сэтгэцийн бэрхшээлтэй иргэдийн эзлэх хувь тогтмол 20 хувьтай байгааг харж болох юм. Үүнээс харахад одоог хүртэл оюун, сэтгэцээр нь ялгаж оношлох, бүртгэх ажил хийгдээгүй байгаа нь эдгээр иргэний эрхийн зөрчлийн анхдагч шалтгаан болж байгаа юм.
2. Сурч боловсрох эрхийн хүрээнд Улаанбаатар хотын хэмжээнд байгаа 63, 55, 25, 70 гэсэн 4 тусгай сургуульд л сурах эрхээ эдэлж байгаа ч дараагийн шатны боловсролын үйлчилгээнд хамрагдах боломж нь хязгаарлагдсан байдаг. Мэргэжлийн боловсролын сургуульд хамрагдах гэсэн ч хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамруулах боломжгүй гэсэн хэвээр байгаа учир мөн л улсын хэмжээнд хоёрхон байдаг “Энэрэл” МСҮТ, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дэргэдэх “Сэргээн засалт, сургалт үйлдвэрлэлийн төв”-д л хамрагдаж байна.¹¹
3. Оюуны болон сэтгэцийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүд “тусгай сургуулиа төгсөөд л гэрийн хорионд орж байна, манай хүүхдүүдэд цаашид хамрагдах, хөгжих тогтолцоо, төв манайд даанч байхгүй байна” гэж ихээр ярьдаг. Нээрээ л манайд бусад улсад байдаг шиг өдрөөр хөгжүүлэх үйлчилгээ үзүүлдэг “Day care” үйлчилгээ байдаггүй. Монгол Улсын Засгийн газар Азийн хөгжлийн банктэй хамтран 6 аймагт Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг¹² барьж ашиглалтад оруулсан ч

¹⁰ https://www.nso.mn/mn/statcate/table-view/Society%2C%20development/Disability/DT_NSO_3900_004V1.px

¹¹ Монгол Улсын Засгийн газрын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцын хэрэгжилтийн 2, 3 дугаар тайлан.

¹² <https://www.pwdp.mn>

тухайн төвүүдийн үзүүлж буй үйлчилгээнд мөн оюуны болон сэтгэцийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн зүйл байдаггүй, харин төвөөс зохион байгуулж байгаа тэмцээн, уралдаанд л хамруулдаг гэсэн мэдээллийг тус төвүүдийн тайлангаас уншсан.

4. Хөдөлмөр эрхлэлтийн хувьд JICA байгууллагатай хамтран хэрэгжүүлсэн “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх төсөл”-ийн хүрээнд бэлтгэсэн Job coach буюу ажлын байрны дадлагажуулагчаар¹³ дамжуулан 2021 оноос эхлэн оюун, сэтгэцийн бэрхшээлтэй иргэдийг хамт олны дунд тэгш хамруулан ажиллуулж болдгийг шийдвэр гаргагчид харж байгаа юм. гэхдээ бидэнд энэнээс өөр буюу олон улсын байгууллагагүйгээр хийж чадах, хийх зүйл тун цөөн байгаа нь харамсалтай.

Энэ мэтчилэн тоочоод байвал эрхийн зөрчил маш их байгаа. Харин дээр дурдсанчлан өмч өвлөх, гэр бүл зохиох, хүүхэд өргөж авах, сонгуульд оролцож саналаа өгөх зэрэг эрхүүд нь “ХААЛТТАЙ” хэвээрээ байгаа бөгөөд цаашид хэзээ, хэрхэн нээгдэх нь тодорхойгүй байгаа нь, төлөвлөсөн бодлого шийдвэр дотроо эдгээр иргэний эрхийн асуудлыг тусгахгүй байгаа нь, НҮБ-аас ирүүлж буй зөвлөмж, шаардлагыг “ҮЛ ТООЖ” байгаа нь “ГЭРЭЛ ГЭГЭЭ ОГТ ХАРАГДАХГҮЙ” байгаа юм.

Гэтэл бидний үлгэр дууриалал авдаг Япон улс оюун, сэтгэцийн бэрхшээлтэй иргэдийн эрх зүйн чадамжийг “Дэмжлэгтэй шийдвэр гаргалтын тогтолцоо”-гоор шийдэж, тогтолцоондоо нэвтрүүлсэн. Дэмжлэгтэй шийдвэр гаргах гэдэг нь хөгжлийн бэрхшээлтэй иргэний (оюуны бэрхшээлтэй иргэн) бүх эрхийг бусдад шилжүүлнэ гэсэн үг биш бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй иргэн (оюуны бэрхшээлтэй иргэн) эдлэх ёстой бүх эрхээ өөрөө бүрэн дүүрэн эдлэх боломжийг олгох гэсэн үг юм. Үндсэндээ дэмжлэгтэй бие даан шийдвэр гаргах нь хууль ёсны асран хамгаалагчаас хамааралтай тогтолцоог халах тухай ойлголт юм.¹⁴ Дэмжлэгтэй шийдвэр гаргахыг хуулийн дагуу хэрэгжүүлдэг болсноор зөвхөн оюуны бэрхшээлтэй иргэний бие даан амьдрах эрх болоод шийдвэр гаргах, сонголт хийх эрхийг хэрэгжүүлж буй хэрэг бус юм. Энэ нь насжилтын улмаас оюуны чадвар нь алдагдсан/алдагдаж буй хүмүүс, тархины гэмтэл, эмгэгийн улмаас эрүүл мэнд, эмчилгээгээ бүрэн дүүрэн авч чадахгүй байгаа хүмүүст/иргэдэд мөн адил хамаарна.

Өнөөдөр миний хөндөн бичиж буй энэ сэдвийг өмнө нь сөхөж байсан, дугарч байсан нь маш цөөн бөгөөд эрх зүйн чадамжгүйгээсээ үүдэн энэ олон эрхийн зөрчил үүсч байгаа талаар бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчдад тайлбарлахад ойлгож хүлээж авах хүн байдаггүй нь энэ сэдэв

¹³ Монгол Улсын Засгийн газрын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцын хэрэгжилтийн 2, 3 дугаар тайлан, 2023 он.

¹⁴ https://inclusion-europe.eu/wp-content/uploads/2015/03/15.Position_Supported_Decision_Making_EN.pdf

“хаалттай”, эдгээр иргэдийг “хүн гэж хардаггүй” зэрэг нөхцөл байдалд хүргэсэн гэж хэлж болно.

Ингэж хэлсний учир нь хүн бүр нэр төр, эрхэм чанартай бөгөөд хүн эрхээ эдлэх болон нийгмийн харилцаанд бодитой, үр дүнтэй оролцох, зөрчигдсөн эрхээ хамгаалуулах тэгш боломж, нөхцөлөөр хангах, хөгжлийн гадна хэнийг ч үлдээхгүй байх нь төрийн үүрэг байтал эдгээр иргэний асуудлыг хэн ч, ямар ч байгууллага авч хэлэлцэхгүй байгаа байдлыг хэлж буй юм.

Ихэнх тохиолдолд эхлээд бие эрхтний бэрхшээлтэй иргэдийнхээ асуудлыг шийдчихье дараа нь оюун, сэтгэцийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангахад анхааръя гэдэг хандлага шийдвэр гаргагчдад байдаг. Гэтэл өнөөдөр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь бусад хүмүүсийнхээ нэгэн адил амьдарч, суурь эрхүүдээ бүрэн дүүрэн эдэлж чадаж байгаа улс орнуудад бүх иргэнийхээ эрхийн асуудлыг хамтад нь төлөвлөж, шийдэж ирсэн байдаг юм.

Хөгжлийн бэрхшээлийн салбарт байшин барилга, төв нэмж барихаас илүү “хүний нөөцийг нэмэгдүүлэх”, “үйлчилгээний төрөл, хэлбэрийг нэмэгдүүлэх”-д анхаарч чухалчилдаг. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг тусд нь авч үзэж, тусдаа бодлого, шийдвэр гаргахаас илүү тэгш хамруулах зарчмыг баримталж байгаа бөгөөд НҮБ-аас ч Монгол Улсад ийм эдгээрийг онцгой анхааруулж, зөвлөмждөө дурдсан.

Энэ бүхнийг дүгнээд хэлэхэд өнөөдөр Монгол Улсад Иргэний хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т “Сэтгэцийн өвчний улмаас өөрийн үйлдлийн учир холбогдлыг ойлгохгүй, өөрийгөө зөв удирдаж чадахгүй болсон этгээдийг шүүх иргэний эрх зүйн чадамжгүй гэж тооцож, түүнд асран хамгаалалт тогтооно.” Гэсэн заалтыг өөрчлөхгүйгээр оюун, сэтгэцийн бэрхшээлтэй иргэдийн эрх хангагдахгүй. Тиймээс хамгийн түрүүнд оюун, сэтгэцийн бэрхшээлтэй иргэдийн “эрх зүйн чадамжтай” байх эрхийг нь сэргээхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх онцгой шаардлага байна.

Бодит байдалд энэ бэрхшээлтэй иргэдийн эцэг эх, хууль ёсны асран хамгаалагчдын зүгээс тусгайлан асрамжийн газар байгуулж өгөхийг шаардсаар байдаг нь төрийн зүгээр дээрх эрх зүйн чадамжийг олгоогүйгээс үүдсэн нийгмийн харилцаанд оролцох, суурь эрхүүдийг хангаагүйгээс гадна тэднийг дэмжсэн ямар ч дэмжлэгийн болон хөгжлийн тогтолцоо байдаггүйгээс “шууд хамааралтай” юм.

“Хөгжлийн бэрхшээлтэй хүн амьдрахад таатай нийгэм бол бүх хүний амьдрахад таатай нийгэм байдаг”¹⁵ гэсэн уриа үгний дор нийтлэлийн эхэнд дурдсан олон улсын гэрээ, конвенц дээрх “Хүн бүр хаана ч байсан эрх зүйн чадвартай байх эрхээ хүлээн зөвшөөрүүлэх эрхтэй ба төрөөс үүнийг хангах үүрэгтэй” гэснийг дахин сануулъя.

¹⁵ Kuno Kenji., Disability Equality Training manual series №.5 (2012), Tokyo.

Эдгээр иргэн бусад шиг өөрийнхээ хүсэл сонирхол, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж чаддаггүй болохоор тэдний эрхийг хангах асуудал “ЧИМЭЭГҮЙ ХАШГИРААН” байсан байх. Харин би тэдний өмнөөс “ЦАГААН ХООЛОЙ” болж дуу хоолойг нь чангаас чанга, тодоос тод хүргэхээр сэтгэл шулуудан энэхүү нийтлэлээ бичлээ.

IV. НОМ ЗҮЙ

1. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=367>;
2. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=299>;
3. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=226>;
4. <https://legalinfo.mn/mn/detail/1271>;
5. <https://legalinfo.mn/mn/detail/1284>;
6. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=1257>;
7. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=10034>;
8. Юнеско, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам., (2024), Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хорооноос Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцын хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр Монгол Улсын Засгийн газарт 2015, 2023 онуудад ирүүлсэн зөвлөмжийн гарын авлага, Улаанбаатар хот;
9. <https://legalinfo.mn/mn/detail/11711>;
10. https://www.nso.mn/mn/statcate/tableview/Society%2C%20development/Disability/DT_NSO_3900_004V1.px;
11. Монгол Улсын Засгийн газрын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцын хэрэгжилтийн 2, 3 дугаар тайлан, 2023 он;
12. <https://www.pwdp.mn>;
13. Монгол Улсын Засгийн газрын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцын хэрэгжилтийн 2, 3 дугаар тайлан, 2023 он;
14. https://inclusion-europe.eu/wp-content/uploads/2015/03/15.Position_Supported_Decision_Making_EN.pdf ;
15. Kuno Kenji., Disability Equality Training manual series №.5 (2012), Tokyo;



Т. АНХБАЯР

Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн Замын цагдаагийн тэнхимийн ахлах багш, цагдаагийн хошууч

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГАД ХОРИГДЛЫН ҮСИЙГ ХУСАХ ПРАКТИК БА ХҮНИЙ ЭРХИЙН АСУУДАЛ

Хураангуй. Хорих ял эдэлж буй этгээдийн үсийг албадан хусах журам, практик нь олон улсын хүний эрхийн стандартын хүрээнд хүний нэр төр, хувийн халдашгүй байдлыг хүндлэх зарчимтай хэрхэн зөрчилдөж байгааг энэ өгүүлэлд судлав. Олон улсын гэрээ, баримт бичиг (Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Нельсон Манделагийн дүрэм, Бангкокийн дүрэм)-ийн холбогдох заалтууд болон Хүний эрхийн хорооны ерөнхий тайлбар, Европын Хүний Эрхийн Шүүхийн *Yankov v. Bulgaria*¹ хэрэгт шүүх хоригдлын үсийг хүчээр хусах нь тэдний нэр төрийг доромжлох, хүнлэг бус, ялгаварлан гадуурхах шинжтэй гэж үзсэн нь олон улсын жишиг тогтоосон байна

Монгол Улсын хууль тогтоомжид хоригдлыг хүний эрхийг хүндэтгэн, эрүүдэн шүүлтээс ангид байх, шашин шүтэх эрхийг нь хангах үүрэг заагдсан ч практикт хоригдлуудын үсийг дүрэм журмын дагуу нэгэн жигд хусах явдал хэвээр байна. Энэхүү ажиллагаа нь хоригдлын хүний нэр төр, биеийн халдашгүй байдлын эрх, шашин шүтэх эрх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх зэрэг суурь эрхүүдийг зөрчиж болзошгүйг онолын болон хууль зүйн үүднээс тайлбарлав. Мөн хоригдлын үсийг хусах нь нийгмийн сэтгэл зүйд

¹ Yankov v. Bulgaria (Application No. 39084/97). Европын Хүний Эрхийн Шүүх, 2003 оны 12 дугаар сарын 11-ны шийдвэр.

хэрхэн нөлөөлж, хоригдлын өөрийн үнэлэмжийг бууруулах, бусдын өмнө царай зүсээр нь “ялгасан” доромж нөхцөлд оруулах хор уршигтайг хүний эрхийн болон жендэрийн мэдрэмжийн үүднээс шинжиллээ. Дүгнэлт хэсэгт энэхүү практикийг өөрчлөх, олон улсын стандартад нийцүүлэх талаар санал, зөвлөмжийг дэвшүүлэв.

Abstract. *This article examines how the regulation and practice of forcibly shaving the hair of individuals serving custodial sentences conflicts with the principles of respect for human dignity and bodily integrity under international human rights standards. By analyzing and comparing the relevant provisions of international instruments - including the International Covenant on Civil and Political Rights (ICCPR), the United Nations Standard Minimum Rules for the Treatment of Prisoners (the Nelson Mandela Rules), and the United Nations Rules for the Treatment of Women Prisoners and Non-custodial Measures for Women Offenders (the Bangkok Rules) - as well as the General Comments of the Human Rights Committee and the judgment of the European Court of Human Rights in Yankov v. Bulgaria (2003), the study finds that the forced shaving of prisoners' hair is internationally recognized as conduct that may amount to degrading treatment and discrimination.*

Although the domestic legal framework of Mongolia requires that persons deprived of their liberty be treated with respect for their human rights, be protected from torture and other ill-treatment, and be guaranteed freedom of religion, in practice prisoners continue to have their hair uniformly shaved pursuant to internal rules and disciplinary norms. The article argues, from both theoretical and legal perspectives, that such practices risk violating several fundamental rights of prisoners: the right to dignity, the right to bodily inviolability, the right to freedom of religion, and the right to be free from discrimination.

The analysis further considers the social and psychological effects of forced head shaving, including its capacity to stigmatize detainees, diminish their sense of self-worth, and subject them to public humiliation by visibly “marking” them in front of others. These implications are assessed through a human rights-based and gender-sensitive lens. The conclusion advances recommendations for reform aimed at eliminating the practice and aligning custodial standards in Mongolia with international human rights norms.

Түлхүүр үг: хорих анги, хоригдлын эрх, хүний нэр төр, үсийг хүчээр хусах, жендэрийн тэгш бус байдал, ялгаварлан гадуурхалт, олон улсын стандарт, Нельсон Манделагийн дүрэм

Keywords: *prison institution; prisoners' rights; human dignity; forced head shaving; gender inequality; discrimination; international standards; the Nelson Mandela Rules.*

I. УДИРТГАЛ

Хорих ял эдэлж буй хүмүүсийн үсний засалт, гадаад төрхийг албадан өөрчлөх нь олон орны шоронгийн уламжлалт практикт байсаар ирсэн явдал юм. Монгол Улсын хорих байгууллагууд ч ялангуурын үсийг нэгэн жигд хусуулдаг дүр зураг хэвшил болсон нь хэвлэл мэдээллийн зарим сурвалжид дурдагджээ.² Тухайлбал, хорих ангийн эмнэлэгт ажиллаж буй хоригдлууд “нүцгэн толгойтой” буюу үсээ хусуулсан байдалтай байдаг талаар сэтгүүлчийн сурвалжилгад тэмдэглэсэн байна.³ Энэ мэт практик нь аюулгүй байдлын шаардлага, ариун цэврийн хэрэгцээ гэхээсээ илүүтэй хоригдлыг дүр төрхөөр нь жигшиж, тэдний жинхэнэ өөрийг нь үгүйсгэх шинжтэй шийдвэр гэдэг шүүмжлэл дагуулдаг.



Хүний эрхийн үүднээс авч үзвэл, хоригдлын үсийг хүчээр хусах нь тэдний хүний нэр төр болон биед халдашгүй байх эрх-д халдсан үйлдэл мөн эсэх талаар эргэлзээ төрнө. Мөн уг арга хэмжээ нь шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө (жишээ нь, шашны шалтгаанаар үсээ авхуулдаггүй итгэл үнэмшилтэй хүмүүст) болон ялан эрэгтэй, эмэгтэй хүмүүст өөр өөрөөр нөлөөлдөг тул жендэрийн тэгш байдал, ялгаварлан гадуурхалтаас ангид байх зарчимд сөргөөр нөлөөлөх магадлалтай.

Энэ өгүүлэлд дээрх асуудлыг академик түвшинд олон талын эх сурвалжид тулгуурлан шинжлэхийг зорив. Эхлээд олон улсын хүний эрхийн гол баримт бичгүүд болон практик жишээнүүдээс дурдвал олон улсын пакт, НҮБ-ын хоригдол эрхлэх дүрмүүд, Хүний эрхийн хорооны тайлбар, ЕХЭШ-ийн шийдвэр зэргийг үндэслэн хоригдлын үсийг албадан хусах явдлын хууль зүйн үнэлгээг хийнэ. Үүний дараа Монгол Улсын үндэсний хууль тогтоомж, шүүхийн практик, Хүний эрхийн Үндэсний Комиссын байр суурийг судалж,

² Х.Болор., (2019). “Хорихын эмнэлэг ба төсөөллийн зөрүү.” Dardas.mn.

³ Н. Марал., (2019, January 11). “Өсвөр насны хоригдол 9 хүүхдийг хорих ял эдлэхээс хугацааны өмнө суллажээ.” <https://toimnews.mn/post/16654>

манай орны нөхцөлд уг асуудал хэрхэн зохицуулагдаж байгааг тайлбарлах болно. Гуравдугаарт, хоригдлын үсийг албадан хусах нь хүний нэр төр, хувийн халдашгүй байдал, шашин шүтэх эрх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх зэрэг суурь эрхүүдийг хэрхэн зөрчиж болохыг онолын хувьд авч үзэн, олон улсын гэрээ конвенцын холбогдох заалттай уялдуулан дүгнэлт гаргана. Дөрөвдүгээрт, ийм арга хэмжээний нийгэм, сэтгэл зүйд үзүүлэх үр дагавар, хүмүүжлийн орчинд бий болох сөрөг талуудыг жендэрийн мэдрэмжийн үүднээс шинжилнэ. Төгсгөлд нь дээрх дүн шинжилгээнд үндэслэн хорих ангиудад хоригдлын үсийг хусах практикийг өөрчлөх талаар санал, зөвлөмж дэвшүүлэх юм.

II. ҮНДСЭН ХЭСЭГ

Олон улсын хүний эрхийн баримт бичгүүдийн шаардлага ба олон улсын практик

Олон улсын гэрээ, пакт зохицуулалт: Монгол Улс нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт нэгдсэн бөгөөд тус пакт 7-р зүйлд хэнийг ч эрүүдэн шүүх буюу хэрцгий, хүнлэг бус буюу нэр төрийг нь доромжлон харьцах, шийтгэхийг хориглодог.⁴ Мөн 10-р зүйлд “эрх чөлөөг нь хассан бүх хүнийг хүнлэгээр бахархалтай нь (хүний төрөлхийн нэр төрийг хүндэтгэн) харьцах” үүргийг гэрчлэн заасан байдаг.⁵ НҮБ-ын Хүний эрхийн хороо (ХЭХ) уг 10-р зүйлийн талаарх Ерөнхий тайлбар №21 (1992 он) хоригдлуудыг хорих ялын зайлшгүй үр дагавраас гадуур аливаа нэмэлт хатуу нөхцөл, хүндрэлд оруулахгүй байхыг онцлон тэмдэглэсэн. Тус тайлбарт: “Хоригдож буй хүн эрх чөлөөгөө хасуулснаас өөр ямар ч нэмэлт бэрхшээл, дарамтад өртөх ёсгүй; хоригдлын нэр төрийг чөлөөтэй байгаа хүний нэгэн адил нөхцөлөөр хүндэтгэх ёстой” гэж заасан байдаг.⁶ Энэхүү зарчим нь ялангуяа хорих ангийн дотоод дэглэм, шийтгэлийг тогтоохдоо хоригдлын эрхэм чанарыг хадгалах шаардлагыг тавьдаг. Өөрөөр хэлбэл, хоригдлыг гэсгээх нэрийдлээр гадна

⁴ Нэр төрийг гутаасан харьцааны жишээнд дараах зүйлс орно: бусдын өмнө тухайн хүнийг ноцтойгоор доромжлон гутаах, эсхүл түүнийг өөрийн хүсэл зориг болон ёс зүйн ухамсрынхаа эсрэг үйлдэхэд албадан хүргэдэг харьцаа буюу шийтгэл [ECmHR, Greek case, above note 84, p. 186]; арьс өнгөөр ялгаварлан гадуурхахын ноцтой хэлбэрүүд [ECmHR, East African Asian Cases, above note 32, p. 76]; хоригдолд бохирдсон хувцсаа солихыг зөвшөөрөхгүй байх [ECtHR, Hurtado v. Switzerland, Judgment of 28 January 1994, Series A, No. 280-A, para. 12]; шийтгэл болгон үс, сахлыг хусах [ECtHR, Yankov. v. Bulgaria, Judgment of 11 December 2003, ECHR 2203-XII, paras.114, 121]; хүнийг бамбай болгон ашиглах [ICTY, The Prosecutor v. Aleksovski, above note 95, para. 229]; мөн хорихын зохисгүй нөхцөлд байлгах, боолчилсон шинжтэй дорд үйлдэл хийлгэх, хувцасныхаа дотор бие засахад хүргэх, эсвэл бие махбодын, сэтгэл зүйн эсхүл бэлгийн хүчирхийлэлд өртөх байнгын айдсыг туулах зэрэг үйлдлүүд [ICTY, The Prosecutor v. Kvočka and Others, above note 10, para. 173].

⁵ HRC General Comment No. 21: Article 10 (Humane Treatment of Persons Deprived of Their Liberty) | Global Health & Human Rights Database.

⁶ HRC General Comment No. 21: Article 10 (Humane Treatment of Persons Deprived of Their Liberty) | Global Health & Human Rights Database.

төрх байдлыг нь хүчээр өөрчлөх, илүүц доромжлол үүсгэхийг зөвшөөрөхгүй гэсэн үг юм.

Олон улсын пакт дээрх зарчмуудыг хэрэгжүүлэх хүрээнд НҮБ-аас гаргасан “Хоригдолтой харьцах тухай Нэгдсэн Үндэстний стандарт минимал дүрмүүд” (өнөөдөр Нельсон Манделагийн дүрэм хэмээн шинэчлэгдсэн, 2015) нь бүх хоригдлыг *“төрөлхийн нэр төр, үнэ цэнтэй хүн гэдгийг нь хүндэтгэн харьцах”* үндсэн зарчимтайг тунхагласан байдаг.⁷ Нельсон Манделагийн дүрмийн 1-р дүрэмд аливаа ялтанг ялгаварлахгүй, нэр төрийг нь хүндэтгэн харьцах ёстойг заасан бол 43-р дүрэмд (хуучин стандарт дүрмийн 31-д) сахилгын шийтгэлийн хүрээнд *“бие махбодын ямар ч шийтгэл, харанхуй камерт хорих буюу хэрцгий, хүнлэг бус буюу доромжлолтой аливаа шийтгэл оногдуулахыг”* бүрэн хориглосон байна.⁸ Хоригдлын үсийг хусах нь олон тохиолдолд сахилгын шийтгэлийн нэг хэлбэр шиг хэрэглэгддэг байсан түүхтэй тул энэ төрлийн шийтгэл нь дээрх дүрмээр шууд хориглогдсон доромж шийтгэлийн төрөлд хамаарна гэж үзэж болно. Түүнчлэн тус дүрмийн 20-р зүйлд хоригдолд хувийн ариун цэврээ сахих бололцоог хангах, үс, сахлаа арчлахад нь шаардлагатай хэрэгслийг олгох талаар дурдсан байдаг.⁹ Өөрөөр хэлбэл, хоригдлуудыг өөрийн үс сахлаа цэвэр авч явах нөхцөлийг бүрдүүлэхийг шаардахаас бус, тэдний үсийг бүгдийг нь хусах тухай заалт энэ стандарт дүрэмд байхгүй. Харин ч хоригдлыг цэвэр цэмцгэр, өөртөө итгэлтэй байхад нь туслах үүднээс үс арчилгааны боломж олгохыг зөвлөсөн байдаг.

Эмэгтэй хоригдлын хувьд олон улсын нэмэлт стандарт нь НҮБ-аас 2010 онд баталсан “Эмэгтэй хоригдлууд болон гэмт хэрэгт холбогдсон эмэгтэйчүүдтэй харьцах тухай дүрмүүд” (Бангкокийн дүрэм) нь хорих ял эдэлж буй эмэгтэйчүүдийн өвөрмөц хэрэгцээ, эрхийг хүндэтгэхийг гишүүн орнуудад сануулсан баримт бичиг юм. Тус дүрмийн 54-р зүйлд *“шашин соёлын өөр өөр суурьтай эмэгтэй хоригдлуудын онцгой хэрэгцээг хүлээн зөвшөөрч, ялгаварлан гадуурхагдах олон талт эрсдэлийг нь харгалзан үзэх”* талаар зааж, тэдгээр хэрэгцээнд нь нийцсэн цогц үйлчилгээ, хөтөлбөрийг хорих байгууллагаас үзүүлэхийг зөвлөсөн байдаг.¹⁰ Энэ нь зарим эмэгтэй хоригдлын хувьд үсний засалт нь шашин шүтлэг, соёлынх нь нэг хэсэг байж болох тул албадан үсийг нь авах нь давхар гэмтэл учруулж болохыг ойлгож, энэ төрлийн мэдрэмжтэй хандах шаардлагатайг онцолдог. Ерөнхийдөө олон улсын стандартууд эмэгтэй хоригдлын хувьд бие махбод, гадаад төрхийн хувьд эмзэг байдлыг илүү анхаарч үзэхийг улс орнуудаас хүсдэг. Тухайлбал, зарим оронд эрэгтэй хоригдлуудыг жигдэрсэн байдлаар үсийг нь авах уламжлал байвч эмэгтэй хоригдлуудад ийм үйлдэл хийх нь илүү ноцтой

⁷ Erna Athanasius, pp. (2020, pp. 29–30).

⁸ United Nations Office on Drugs and Crime, pp. (2015, pp. 14–15).

⁹ Coyle, pp. (2009, pp. 40–41).

¹⁰ United Nations Office on Drugs and Crime, pp. (2010, pp. 20–21).

доромжлолд тооцогдож, бараг хэрэгждэггүй. Энэ ч утгаараа Бангкокийн дүрэм нь жендэрийн мэдрэмжтэй, ялгаварлалгүй байдлыг хангахыг бүх шатанд (хорих ангид ч тэр) шаардаж байна.

Европын Хүний Эрхийн Шүүхийн практик нь Хоригдлын үсийг хүчээр хусах явдлыг хүний эрхийн зөрчил гэж үзсэн тодорхой жишээ бол Европын Хүний Эрхийн Шүүхийн 2003 оны “Yankov v. Bulgaria” хэрэг юм. Энэ хэрэгт ялан Янковт шоронгийн захиргаа сахилгын шийтгэлийн хүрээнд албадан үсийг нь хуссан нь Европын хүний эрхийн конвенцын 3-р зүйл (эрүүдэн шүүх болон хүнлэг бус, доромжлох харьцаанаас ангид байх эрх)-ийг зөрчсөн эсэх асуудал хөндөгджээ. Шүүх уг үйлдлийн шинж чанарыг нарийвчлан авч үзэхдээ “хоригдлын үсийг хүчээр хусах нь тухайн хүний хүсэл зоригийн эсрэг түүний гадаад төрхийг өөрчилж буй хэрэг бөгөөд үүний улмаас хоригдолд өөрийгөө дорд үзэх мэдрэмж төрж, улмаар нэр төрөө алдаж буй мэт сэтгэгдэл төрөх нь гарцаагүй” гэж онцолсон байдаг.¹¹ Мөн үсээ хусуулсан хоригдол тодорхой хугацаанд илт “танигдах тэмдэг”-тэй болж, тэр нь шоронгийн ажилтнууд, бусад хоригдол төдийгүй гаднын хүмүүсийн нүдэнд ил харагддаг тул тухайн хүн “өөрийнхөө энэ байдлаас болж нэр төрдөө сэв суусан мэт гутрах мэдрэмжтэй үлддэг” гэж тухайн шүүх үзсэн байна.¹² Шүүх дүгнэлтдээ, албадан үс хусах нь зарчмын хувьд хоригдлын хүн болохын чин үнэт чанарыг нь дордуулах буюу түүнд дорд орсон мэт мэдрэмж төрүүлж, улмаар хүнийг доромжлон гутаах үйлдэл мөн гэж цохон тэмдэглэсэн байдаг.¹³ Ялангуяа Янковын тохиолдолд уг шийтгэл нь ямар нэг практик хэрэгцээнээс биш, харин хоригдол тухайн үед шоронгийн захиргааг шүүмжилсэн бичиг үйлдсэнд нь өшөө авч, санаатайгаар доромжлох зорилготой байсан нөхцөл тогтоогдсон тул бүр ч ноцтой гэж үзжээ. ЕХЭШүүх эцэст нь “хоригдлын үсийг хусах шийтгэл нь тухайн нөхцөл байдалд ямар ч зөвтгөгдөх үндэслэлгүй, доромжлох шинжтэй хүнлэг бус харьцааны илрэл болсон” гэж үзэж, Конвенцын 3-р зүйлийн зөрчил гарсан хэмээн шийдвэрлэсэн.¹⁴

Энэхүү Yankov v. Bulgaria хэргээр тогтсон зарчим нь бусад улсад ч хамаатай ерөнхий стандарт болж байна. Өөрөөр хэлбэл, хоригдлын үсийг үндэслэлгүйгээр, тэр дундаа шийтгэлийн арга хэлбэр болгон хусах нь хүний нэр төрийг санаатайгаар гутаасан хэрэг болж, энэ нь хүнлэг бус буюу доромжлох харьцааны нэг хэлбэр гэж олон улсын эрх зүйд тооцогдох болсон байна. Үүнтэй уялдан, хэд хэдэн улсад шоронгийн албан тушаалтнуудыг хоригдлын шашин шүтлэгтэй холбоотой урт үс, сахлыг хүчээр хуссан үйлдэлд нь хүний эрхийг зөрчсөн хэмээн шүүхээр шийтгэж байсан тохиолдлууд гарсан байв. Тухайлбал, АНУ-ын зарим мужид лам шашинтан хоригдлын үсийг хусах нь

¹¹ Council of Europe(case of yankov v. bulgaria)), (2003, p. 20, c.112).

¹² Council of Europe(case of yankov v. bulgaria)),(2003, p. 20, c.113).

¹³ Council of Europe(case of yankov v. bulgaria)), (2003, p. 20, c. 114).

¹⁴ Council of Europe(case of yankov v. bulgaria)), (2003, p. 20, c. 114).

Үндсэн хуулиар хамгаалагдсан шашин шүтэх эрхийг зөрчсөн гэх маргаан гарч байв.

Эдгээрээс үзэхэд олон улсын түвшинд тогтсон нийтлэг зарчим нь хоригдлын үсийг албадан хусах нь зөвхөн нэн шаардлагатай, бодит үндэслэлтэй / хоригдож байх хугацаандаа гэмт хэрэг дахин үйлдэх, шоронгийн дотоод журмыг ноцтойгоор зөрчсөн гэх зайлшгүй нөхцөл/ тохиолдолд л байж болох, харин шийтгэл шиг журам байдлаар энгийн практик болгох нь хүний эрхийн зөрчил гэж үзэх хандлагатай байна. Олон улсын гэрээ, дүрэм журмууд болон жишиг хэрэг шийдвэрүүд энэ байр суурийг тодорхой илэрхийлдэг.

Монгол Улсын хууль тогтоомж, практик дахь зохицуулалт

Монгол Улсын Үндсэн хуулиар Хүний эрх, нэр төр, алдар хүндийг хуулиар тогтоон хамгаална гэж тунхагласан (МУҮХ-ийн 16-р зүйлийн 17) болон “Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй” (МУҮХ-ийн 16-р зүйлийн 13) хэмээн заасан байдаг. Түүнчлэн, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй (МУҮХ-ийн 16-р зүйлийн 15) болон *ялгаварлан гадуурхалтаас ангид байх* зарчим Үндсэн хуулийн тулгуур үзэл баримтлалд багтдаг.¹⁵ Эдгээр үндсэн эрхийн хүрээнд, хорих ял эдэлж буй иргэн нь зөвхөн эрх чөлөөгөө хасуулсан хууль ёсны шийтгэлийн хатуу байдлыг эдлэхээс бус, түүнээс давсан аливаа доромжлол, үндэслэлгүй шаардлагад өртөх ёсгүй юм.

Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд /шинэчилсэн найруулга/ *Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, хүний эрх, эрх чөлөөг зөвхөн хуульд зааснаар хязгаарлах, энэрэнгүй, шуурхай байх* зарчимд үндэслэн хэрэгжүүлэх ёстойг энэ хуулийн 4.1-р зүйлдээ тунхагласан байдаг.¹⁶ Тус хуульд зааснаар хоригдол нь хорих ял эдлэх хугацаандаа хуульд заасан зарим эрхээ хязгаарлуулсан ч хүний үндсэн эрх, нэр төрийг хүндэтгэх зарчим чанд мөрдөгдөх ёстой. Жишээлбэл тус хуулийн 210, 211 дугаар зүйлд хоригдлын эрх, үүргийг тодорхойлохдоо *эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг сахих, хувийн аюулгүй байдлаа хамгаалуулах, шашны зан үйл үйлдэх, хорих байгууллагын алба хаагч, эрх бүхий албан тушаалтны зүгээс хүнлэг харьцах, эсхүл хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг нь доромжилж харьцахгүй байхыг шаардах гэсэн бусад үндсэн эрхээс нь зөвхөн хуульд заасан хүрээнд хязгаарлалт хийх зэрэг зарчмуудыг тусгасан* байдаг.

Мөн хуулийн 48 дугаар зүйлд (*Шийдвэр гүйцэтгэгч эд хөрөнгөд үзлэг, нэгжлэг хийх ажиллагааг явуулахдаа энэ хуульд заасны дагуу тэмдэглэл хөтөлж, хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд аюулгүй арга, хэрэгсэл ашиглаж, хүний нэр төрд хүндэтгэлтэй хандана*), тус хуулийн 251 дугаар

¹⁵ Төрийн мэдээлэл эмхэтгэл, (1992, №1, х. 6–7).

¹⁶ Төрийн мэдээлэл эмхэтгэл, (2017, №24, х. 1479-1480).

зүйлд (хоригдолтой хүнлэг бус, хэрцгий, нэр төрийг нь гутаан доромжилж харьцах) үйл ажиллагаанд хэрэгжүүлэхийг тусгасан байна.

Хоригдлын хувийн ариун цэврийн хэрэгцээг хангах талаар мөн хорих ангийн дотоод журамд тусгасан байдаг. (Жишээ нь, “Хорих ангийн дотоод журам”-д эрэгтэй хоригдол сахал, халимагтай /0.3 см-ээс ихгүй/ байх, хэлбэр, дүрс үүсгэж захлах, эмэгтэй хоригдол үсээ задгай тавихыг тус тус хориглоно гэж заасан байдаг). Гэвч эдгээр дүрэм нь Хорих анги бол төрийн байгууллага, хоригдол бол төрийн хяналтад байгаа иргэн. Тэгэхээр “эрэгтэй хоригдол ийм байдлаар үс, сахлаа заавал тайрсан байх” гэж илүү хатуу шаардаж, харин “эмэгтэй хоригдолд ийм хязгаарлалт тавихгүй” гэж өөр стандарт тогтоох нь хүйсийн шинжээр ялгаварлан харьцаж байна. Энэ нь Монгол Улсын Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 5 дугаар зүйлд (ялгаварлан гадуурхахгүй байх зарчим: эрэгтэй, эмэгтэй хүн бүр нас, хүйс, ажил, албан тушаал, үзэл бодол, гэрлэлтийн байдал, боловсролын ялгаа зэргийг үл харгалзан ялгаварлан гадуурхалт, хязгаарлалтгүйгээр хүний эрх, эрх чөлөөг эдлэх), мөн хуулийн 6 дугаар зүйлд (Улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд жендэрийн ялгаварлан гадуурхалтыг хориглоно) заасан ялгаварлан гадуурхахгүй байх зарчимтай зөрчилдөж байгаа юм.

График 1.Манай улсын хорих ангид хүмүүжиж буй хоригдол



Эрэгтэй хоригдолд тавьж буй шаардлага (“үс, сахал нь 0.3 см-ээс урт байх ёсгүй”, “хэлбэржүүлэхийг хориглоно”) нь эрэгтэй гэсэн шинжээр онцгойлж, эрх чөлөөг нь илүү хязгаарласан тусгай, тусдаа хорио юм. Эмэгтэй хоригдолд ийм түвшний хязгаарлалт тавиагүй байна. Энэ нь Жендэрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд (жендэрийн ялгаварлан гадуурхалт” гэж улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд болон аливаа бусад салбарт

эрэгтэй, эмэгтэй хүнийг хүйсийн шинж, гэрлэлтийн байдлаар ялгаварлах, үгүйсгэх, хязгаарлах үйлдэл, эс үйлдэхүйг) хэлнэ гэж заасан байдаг.

Тухайлбал “Хорих ангийн дотоод журам” гэдэг нь бүх хоригдол заавал дагаж мөрдөх дотоод эрх зүйн акт, дэг журам мөн. Тэр журамд “эрэгтэй хоригдол” гэж заагаад илүү хатуу, биед (үс, сахалд) шууд нөлөөлөх албадлагыг тавьж байгаа нь эрэгтэй хоригдолд эмэгтэй хоригдлоосоо илүү хязгаарлалт ногдуулж байна. Энэ нь жендэрийн эрх тэгш байдлыг дордуулж байгаа тул Монгол Улсын Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 2.3-т заасан хоригийг зөрчинө гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл хоригдлуудыг ялгавартайгаар удирдлагын хяналтад байлгаж байна. Өөрөөр хэлбэл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын дотоод дүрэм, журам нь олон улсын пакт болон Монгол Үндсэн хууль, Монгол Улсын Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцээгүй гаргасан хууль тогтоомжоор практикт хорих ангийн захиргаанаас нийт хоригдлуудын үсийг богиносгох буюу хусах чиглэл баримтлан хэрэгжүүлж иржээ.

Албан ёсны түвшинд батлагдсан хорих ангийн дүрэм, журамд хоригдлыг хүйсээр нь ялгаварлан гадуурхалтаас ангид байлгах, хүний нэр төр, алдар хүндийг хуулиар тогтоон хамгаалж, нэр төрийг нь доромжилж болохгүй зэрэг үндсэн зарчмуудад нийцүүлэн нарийвчилсан өөрчлөх шаардлагатайг харуулж байна. Гэвч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын хэмжээнд журмын дагуу нэг хэв маягаар “эрэгтэй хоригдлуудыг товч хөдөлгөөнтэй, нэгэн жигд үстэй байлгах” журамлагдсан хэвшил тогтсон байдаг. Тухайлбал хэвлэлүүдэд дурдсанаар хорих ангиудад тусгай үсчид ажилладаг, тэд хоригдлуудад үйлчилж үсийг нь богиносгодог аж. Eguur.mn сайтын 2023 оны нэгэн нийтлэлд урьдчилан хорих 461-р ангид саатуулагдсан нэгэн сэжигтний үсээ засуулагдсан байдлаар шүүхэд ирсэн нь “урьдчилсан хориход угаасаа үсчин байдаггүй, түр саатуулагдсан хүмүүсийн үс засалт зохицуулагдаагүй байдаг атал уг хүн яаж үсээ засуулав” гэсэн агуулгаар шүүмжилжээ.¹⁷ Үүнээс үзэхэд урьдчилан хоригдож буй хүмүүсийн хувьд хүртэл үс засалтын асуудал анхаарал татдаг, ялгавартай нөхцөл үүсгэдэг гэж ойлгогдоно.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс нь хорих ангиудад хийх хяналт шалгалтын хүрээнд хоригдлын эрхийн нөхцөл байдлыг тогтмол үнэлж, тайлан гаргадаг. Комиссын илтгэлүүдэд хорих ангиуд дахь эрүүдэн шүүлт, хүнлэг бус харьцааны талаар ерөнхий дүгнэлтүүд бий. 2023 оны Комиссын илтгэлд “эрүүдэн шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандлагын өнөөгийн нөхцөл байдал”-д үнэлгээ хийсэн талаар дурдсан байдаг. Гэтэл хоригдлын үсийг хусах асуудлыг тусгайлан онцолсон мэдээлэл нийтэд ил болоогүй байна. Энэ нь уг асуудал хараахан олны анхаарлын төвд бүрэн орж судлагдаагүй ч Комиссын зүгээс хүнлэг бус, доромжлох харьцааг таслан зогсоох тухай ерөнхий шаардлагад хамруулан үзэх ёстой асуудал


¹⁷ Ж.Мядагбадам (2023).

хэмээн ойлгож болох юм. Өөрөөр хэлбэл, хоригдлын үсийг хүчээр хусах нь хэрэв хоригдлын өөрийн зөвшөөрөлгүй, шаардлагагүй хийгдэж байгаа бол ХЭҮК-ын мандатад хамаарах “хүнлэг бус, нэр төрийг гутаасан харьцаа”-ны нэг илрэл мөн. Цаашид энэ асуудлаар ХЭҮК тодорхойлон дүгнэлт гаргах, зөвлөмж өгөх шаардлага байгаа мэт судлаачийн зүгээс санагдана.

Манай улсад хоригдол өөрийн үсийг хүчээр хусуулсны улмаас эрх нь зөрчигдсөн тухай гомдол шүүхэд гарсан жишиг хэрэг олдоогүй. Энэ нь нэг талаас хоригдлууд шүүхэд хандах боломж хязгаарлагдмал байдаг, нөгөө талаас ийм практикийг олонх нь “жам ёсны зүйл” мэт хүлээн зөвшөөрдөгтэй холбоотой байж болно. Харин сүүлийн жилүүдэд ял эдлэгчдийн эрхийн талаар иргэний нийгмийн идэвхтэй хэлэлцүүлгүүд өрнөж, хорих ангиуд дахь нэр төрийн асуудал хөндөгдөх болсон. Хэрэв хоригдол шашны шалтгаанаар үсээ хусуулахгүй байх хүсэлт гаргавал түүнийг хүлээн авах зохицуулалт одоогоор байхгүй байна. Тухайлбал Монголд Буддын шашны улааны урсгалын гэцэл санваартан хүн үсээ хусуулахгүй байх тангараг өргөдөг ч хоригдох үеэр энэ эрхийг нь харгалзсан эсэх тодорхойгүй. Үндэстэн, соёлын онцлогтой бүлгийн (жишээ нь, бөө мөргөлтэй холбоотой үс өсгөх зан үйлтэй хүн гэх мэт) хоригдлуудын хувьд ч адил. Иймээс, цаашид шүүх дээр маргаан үүсвэл Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийнхээ хүрээнд шийдэх ёстой болох нь дамжиггүй.

Эдгээрээс дүгнэхэд манай улсын хууль тогтоомж нь хоригдлын нэр төр, халдашгүй байдлыг хамгаалах үүрэг хүлээдэг ч практикт хоригдлын үсийг дотоод журмын дагуу албадан хусах явдал түгээмэл хэвээр байна. Энэ нь хууль дахь энэрэнгүй байх зарчим, хүний эрхийг хүндэтгэх үүрэг-тэй зөрчилдөх магадлалтай тул эрх зүйн нарийвчилсан зохицуулалт, заавар шаардлагатай байгааг харуулж байна.

График 2. Шүүхээр ял шийтгүүлсэн хүний тоо хүйс, жилээр



III. ХҮНИЙ НЭР ТӨР, ХАЛДАШГҮЙ БАЙДЛЫН ЭРХ БОЛОН ШАШИН ШҮТЭХ ЭРХИЙН ЗӨРЧИЛ: ОНОЛЫН ШИНЖИЛГЭЭ

Хоригдлын үсийг албадан хусах явдал нь хүний хэд хэдэн суурь эрхийг ноцтой хөнддөг. Үүнд юуны түрүүнд хүний нэр төрийн эрх болон бие махбодын халдашгүй байдлын эрх хамаарна. Мөн тухайн хүний итгэл үнэмшил, шашны уламжлалтай холбоотой бол шашин шүтэх эсэхийн эрх шууд хөндөгдөнө. Улмаар, хоригдлуудыг бусад хүн амын бүлгээс гадуур дүр төрхөөр нь ялган нэг загварт хүчлэх нь нийгмийн харилцаанд ялгаварлан гадуурхах өнгө аясыг агуулна. Эдгээр эрхийн зөрчлийг онолын үүднээс авч үзье.

Хүний нэр төр, алдар хүнд ба хувийн байдлын халдашгүй эрх

Хүний нэр төрийн эрх нь Үндсэн хуулиар хамгаалагдсан, хамгийн тулгуур эрхийн нэг. Хоригдол гэм буруутай нь шүүхээр тогтоогдож, тодорхой хугацаагаар эрх чөлөөгөө хасуулсан боловч түүний хүний хувьд эзэмших ёстой нэр төр, хувийн ариун байдал хэвээр хадгалагдах учиртай. Хүний нэр төрийг хамгаалах олон улсын зарчмуудыг дээр дурдсан байдлыг үндэслэн үзэхэд хоригдлын бие махбодод зөвшөөрөлгүй халдаж, түүний хүсэл эрмэлзэлд үл нийцэх байдлаар гадаад төрхийг нь өөрчлөх нь нэр төрийг нь гутаах үйлдэл мөн. Ялангуяа үс бол хүний биеийн нэг хэсэг, өөрийн цогцолборын бүрэлдэхүүн. Хүний үсийг дур зоргоор авна гэдэг нь биеийн халдашгүй байдлын зарчим зөрчигдөж буйн илрэл.

Хуулийн онолд биед халдашгүй байх эрх нь хувь хүний бие махбод, сэтгэл санааны бүрэн бүтэн байдлыг төр хамгаалах, хүний өөрийн зөвшөөрөлгүй ямар ч халдлагаас ангид байх баталгаа гэж тодорхойлогддог. Хоригдлыг хүч хэрэглэн үсийг нь авах нь угтаа тухайн хүний бие махбодод халдсан хэрэг юм. Мэдээж, үс авах нь шууд гэмтэл учруулахгүй ч, хүний биеийн бүрэлдэхүүн хэсгийг (үсийг) түүний эсэргүүцэлтэй байгаа нөхцөлд хүчээр өөрчилж байна гэсэн үг. Энэ нь мөн хүний хувийн амьдралд халдахгүй байх эрхтэй холбоотой. Хүний хувийн имиж, гадаад төрхийг дур мэдэн өөрчлөхийг Европын хүний эрхийн конвенцын 8-р зүйл (хувийн ба гэр бүлийн амьдралд хүндэтгэлтэй хандах эрх)-ийн үүднээс ч сөргөөр үнэлж болох юм. Өөрөөр хэлбэл хоригдлын үсийг авах нь түүний хувийн орон зай, өөрийгөө илэрхийлэх орон зайд үндэслэлгүйгээр нэвтэрч буй хэрэг юм.

Нэр төрийг гутаан доромжлох хэмжээ, үр нөлөө

Үсийг хусуулах нь гаднаасаа бол бага зүйл (*журамд заасан эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага*) мэт боловч тухайн хүнд үзүүлэх сэтгэхүйн нөлөө асар их байдаг. Шоронгийн орчинд бүх хоригдлыг нэгэн хэвийн халзан болгосноор хувь хүний онцлог шинжийг арилгаж, “бүхнийг адилхан болгож жигдрүүлэх” сэтгэлзүйн арга хэрэглэж байна гэж үздэг. Ингэснээр хоригдолд өөрийгөө үнэ цэнгүй мэт, төрийн эрхшээлд бүрэн орсон, эсэргүүцэл үзүүлэх чадамжгүй болсон мэт мэдрэмж төрдөг нь сэтгэл судлалын шинжлэх ухаанд тэмдэглэгдсэн

байдаг.¹⁸ Yankov v. Bulgaria хэргийн шийдвэрт дурдсанчлан, үсээ хусуулсан хоригдол толгой дээрээ “хар тамгатай” мэт адил сэтгэгдэлтэй болж, энэ нь түүний дотооддоо мэдэрч буй дорд үзэгдлийн сэтгэгдлийг байнга сэргээж байдаг. Нэр төрийг ингэж системтэй гутаах нь эрүүдэн шүүх мэт илт яргалал биш боловч урт хугацаандаа хүний сэтгэл санааг дарангуйлдаг, өөрийгөө үнэ цэнгүйд тооцох үзлийг төрүүлдэг аюултай. Тиймээс үс хусах практикийг зарим судлаачид “бэлгийн хүчирхийлэлтэй адил сэтгэл санааны доромжлол төрүүлдэг” гэж хүртэл хэлдэг (*ялангуяа эмэгтэй хүний хувьд үсийг нь авна гэдэг бол үнэхээр ичгүүртэй, гутамшигтай мэдрэмж төрүүлдэг үйлдлийн нэг*). Үүнээс үүдэн хоригдол хүний хувьд авч үлдэх ёстой өөрийн үнэ цэнээ алдах нь түүний засрал хүмүүжилд ч харин сөргөөр нөлөөлөх талтай (*дор дурдах нийгмийн сэтгэл зүйн анализын хэсэгт үүнийг гүнзгий авч үзнэ*).

Шашин шүтэх эрхийн зөрчил

Хэрэв хоригдол шашны итгэл үнэмшлийн улмаас үс, сахлаа авхуулахгүй байх шаардлагатай бол төр энэ эрхийг хүндэтгэх үүрэгтэй. Олон улсад шашны зан үйл, уламжлалтай холбоотой хувцас, гадаад төрхийн элементүүдийг (өмсгөл, үсний засалт гэх мэт) хорих ангид хэрхэн зохицуулах тухай маргаан олон гарч байв. НҮБ-ын Хүний эрхийн хорооны практикт, шашны ялгаатай шинжийг хоригдлуудад зөвшөөрөлгүй хасах нь шашин шүтэх эрхийн 18-р зүйлийн зөрчил болж болзошгүйг анхааруулсан байдаг. Тухайлбал хорооноос гаргасан Ерөнхий тайлбар №22 (1993 он) нь шашин шүтэх эрхэд хуулиар зөвшөөрөгдөх хязгаарлалтыг тогтоохдоо төрийн аюулгүй байдал, нийтийн дэг журмыг ноцтой зөрчсөн тохиолдолд л хязгаарлаж болно гэсэн. Хэдийгээр хорих ангийн дэглэмийг сахиулах шаардлагатай ч шашны зүй ёсны үйлчлэлийг таслан зогсоох хэмжээний хязгаарлалт хийх нь буруу болов уу. Монгол Улсын нөхцөл байдалд Буддын шашны жонон буюу улааны урсгалын сахил хүртсэн лам нар үсээ авхуулахыг цээрлэдэг, эсвэл Христийн шашны зарим урсгал урт үс, сахлаа үл авна гэх мэт тохиолдлууд байж болно. Мөн үндэстний цөөнхийн хувьд (жишээ нь Казах үндэстний зарим уламжлал, эсвэл өвөг дээдсийнхээ үсэнд хүндэтгэл үзүүлэх ёс гэх мэт) үс, гээг нь бэлгэ тэмдгийн утгатай байж болно. Ийм тохиолдолд тухайн хоригдлын үсийг авах нь түүний шашин, соёлын эрхийг зөрчиж буй хэрэг юм. АНУ-д гарсан нэг жишээ дурдахад Луизиана мужийн шоронд Растафари¹⁹ шашинтай хоригдлын олон жилийн өсгөсөн үсийг хүчээр хуссан явдлыг холбооны шүүхэд авч үзэхдээ энэ нь тэр хүний шашны эрхийг ноцтой зөрчсөн гэж дүгнэжээ.²⁰

¹⁸ Council of Europe(case of yankov v. bulgaria)), (2003, p. 20, с.112).

¹⁹ Растафарианизм нь 1930-аад онд Ямайкт үүссэн шашин-сүсгийн хөдөлгөөн бөгөөд Эфиопийн сүүлийн эзэн хаан Хайле Селассие I-ийн шүтээн, түүний эргэн тойрон дахь үзэл санаанд тулгуурладаг. Тэрээр хаан ширээнд суухаасаа өмнө рас Тафари Маконнен (Тэфэри Мэконнын) хэмээн нэрлэгдэж байв. Энэ хөдөлгөөний дагагчид Хайле Селассие-г Бурхны (Жа) биелэл буюу газар дээрх дүр төрх гэж үздэг.

²⁰ Knight v. Thompson, No. 1211926 (АНУын 11р тойргийн Апелляцийн шүүх, 2015). Хоригдлууд

Монгол Улсад Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд (шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй) гэж шүтэх эрх нь баталгаажсан тул хорих байгууллага уг эрхийг онцгой нөхцөл шаардлагагүйгээр хязгаарлах ёсгүй. Одоогийн практикт хоригдлуудын дийлэнх нь буддын шашинтай манай улсын эрэгтэйчүүд байдаг тул энэ сэдэв ил гардаггүй байж мэднэ. Гэвч зарчмын хувьд, төр ямар ч шашинтай иргэнийг ялгаварлахгүй байх үүрэгтэй тул, хэрэв хоригдол шашныхаа зан үйлийн дагуу үсээ авч болохгүй бол уг хүсэлтийг хүндэтгэн үзэх механизм байх ёстой. Харамсалтай нь одоогоор ийм зохицуулалт манай улсад тодорхой тогтоогүй байна.

Ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх

Шоронгийн орчинд бүх хоригдлыг нэг загварт хүчлэх нь гаднаа тэгш мэт боловч үнэндээ нэг бүлэг эрэгтэй хүмүүст онцгой хатуу нөхцөл ногдуулж буй хэрэг гэж үзэж болно. Нийгэмд чөлөөтэй амьдарч байгаа хүмүүс өөрийн үс засалтаа сонгох эрхтэй байдаг, харин эрэгтэй хоригдлууд тийм эрхээ эдэлж чадахгүй байна. Энэ утгаараа гэмт хэрэг үйлдэж, зарим эрхээ тодорхой хэмжээнд хасуулсан хүмүүс (хоригдол, ялтан) гэсэн статустай хүмүүсийг бусад иргэдээс дорд үзэж буй ялгаатай харьцаа гэж үзэх үндэслэл бий. Мөн хоригдлын үсийг хусах журам нь ихэвчлэн эрэгтэй хоригдлуудад л хэрэгждэг, эмэгтэйчүүдэд тэр бүр үйлчилдэггүй. Манай улсын эмэгтэйчүүдийн хорих ангид хоригдлуудыг халзан болгодоггүй, тодорхой урттай үсээ задгай тавихыг хориглон авч үлдэх боломжийг олгодог. Эдгээрээс үзэхэд эрэгтэй, эмэгтэй ялтнуудыг өөр байдлаар харьцаж буй хэрэг болж байна. Эрэгтэй хүнд үсээ хусуулах нь “хэвийн, хүнд гэм хоргүй” мэт ойлгогддог, эмэгтэй хүнд хориотой мэт ялгавартай байдал үүсэх нь өөрөө жендэрийн асуудал юм. Нэг талдаа, эмэгтэйчүүдийг илүү “иргэний” нөхцөлөөр хандаж, үсийг нь хусахгүй байгаа нь зөв хэрэг мэт боловч нөгөө талдаа эрэгтэйчүүдийн хувьд энэ үйлдлийг ноцтойд тооцохгүй байгаа нь эрчүүдийн сэтгэлзүй, нэр төрийг дутуу үнэлсэн хандлага юм. Үнэн чанартаа, эрэгтэй хүн ч гэсэн үсээ хүчээр хусуулахад гутрал, доромжлол мэдэрдгийг дээр эш татсан олон баримтууд харуулсан. Иймд зөвхөн эрчүүдэд ийм журмыг хамааруулж байгаа нь жендэрийн тэгш байдлын үүднээс эргэцүүлж бодох сэдэв мөн.

Нөгөө талаас, хоригдлын үсийг хусахыг “бүгдэд тэгш үйлчилж буй журам” гэж өмгөөлж болох ч, тухайн журам өөрөө хүний эрхийг хөндөж байгаа нөхцөлд тэгш үйлчлэх эсэх нь хоёрдогч асуудал. Гол асуудал нь хүн амын тодорхой бүлэг болох ялтан хүмүүсийг нийгмээс тусгаарлахдаа нэмэлтээр гадна дүр төрхийг нь нэг хэв маягт оруулан “тамгалах” мэт үйлдэл нь тэднийг бусдаас илүү доод зэрэглэлд ангилах хандлага бий болгодог. Энэ

Religious Land Use and Institutionalized Persons Act (RLUIPA)ийн дагуу шашны шалтгаанаар үсээ ургуулах эрхээ зөрчсөн гэж Албама мужийн шоронгийн үс богиносгох журмыг эсэргүүцэж шүүхэд хандсан. Шүүх уг журмыг хамгаалах нь төрийн сонирхлыг хангах хамгийн бага хязгаарлагч арга зам гэж үзэн, урьдчилсан шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн.

нь нийгмийн ялгаварлалыг бүтээх нэг нөхцөл болдог. Тухайлбал шоронгоос суллагдаж гарч ирэхдээ хүртэл хоригдол хэсэг хугацаанд хусуулсан халзан толгойтой байна – түүнийг харсан хүмүүс тэр даруйд “шоронгоос ирснийг” мэдэх ба энэ нь тухайн хүнд давтагдсан гутаан доромжлох тэмдэг мэт санагдана. Ингэж ялгаварлан таних боломж үүсгэж байгаа нь хүний эрхийн олон баримт бичигт заасан “шаардлагатайгаас илүүгээр хоригдолд дарамт, доромжлол учруулахгүй” гэх зарчмыг зөрчиж байна. Нельсон Манделагийн дүрэмд ч үүнийг хориглосон (44-р дүрэм: хоригдолд ялгавартай буюу илүү дарамт учруулах аливаа заалтыг дэглэмд тусгахгүй байх тухай).

Дээрх онолын шинжилгээнээс үзэхэд, хоригдлын үсийг албадан хусах нь хүний нэр төрийг гутаах, бие махбодын халдашгүй байдлыг зөрчих шинжтэй тул манай улсын нэгдэн орсон ICCPR буюу Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын пакт 7, 10-р зүйл болон Эрүүдэн шүүлт, хэрцгий доромжлох шийтгэлийн эсрэг конвенцын үзэл санаанд нийцэхгүй. Мөн уг үйлдэл нь шашин шүтэх эрх, ялгаварлалгүй байх зарчмыг зөрчих нөхцөл болдгийг дүгнэж болно. Иймээс ч олон улсын байгууллагууд хоригдлын эрхийг хангах чиглэлээр гишүүн орнуудад зөвлөмж өгөхдөө “хоригдлын гадаад төрх, үсний засалт зэргээр нь доромжлон ялгаварлах практикийг зогсоох”-ыг зөвлөдөг (Хүний эрхийн хорооны дүгнэлт, Эрүүдэн шүүлтийн эсрэг хорооны зөвлөмжүүдэд энэ талаар дурдсан байдаг). Манай улсын хувьд ч энэ практикийг хүн төвтэй, энэрэнгүй засаглалын хүрээнд эргэн харах шаардлага урган гарч байна.

IV. НИЙГМИЙН СЭТГЭЛ ЗҮЙ, ХҮМҮҮЖЛИЙН ОРЧИН БА ЖЕНДЭРИЙН ҮР ДАГАВРЫН ШИНЖИЛГЭЭ

Хоригдлын үсийг хусах практик нь зөвхөн хууль эрх зүйн хүрээнд асуудал үүсгээд зогсохгүй, хорих анги дахь нийгмийн сэтгэл зүй, хүмүүжлийн орчинд сөргөөр нөлөөлдөг. Мөн жендэрийн мэдрэмжгүй арга хэмжээний нэг жишээ болж, эрэгтэй хоригдлуудад үзүүлэх сэтгэлзүйн хор уршиг нь дутуу үнэлэгдэж ирсэн талаар авч үзэх нь зүйтэй.

Нийгмийн сэтгэл зүй ба өөрийн үнэлэмж

Хоригдлуудыг бүгдийг нь үсгүй, адилхан дүр төрхтэй болгосноор хорих байгууллага дотор нэг төрлийн “нэргүй масс” үүсгэнэ. Өөрөөр хэлбэл, хувь хүний онцлог шинжийг арилгаж, тэднийг зөвхөн дугаар, дүрэмт хувцас, адилхан халзан толгойгоор нь төлөөлүүлдэг. Энэ нөхцөлд хоригдол хүн өөрийгөө өрөөлтэй адил, “ханхүү ч байсан нэг мөр болжээ” гэх мэдрэмж авч, улмаар өөрийн гэсэн давтагдашгүй үнэ цэнээ үгүйсгэх хандлагад автдаг. Сэтгэл судлалын үүднээс, хүнийг ижилсүүлэн жигдрүүлэх нь түүний өөрийгөө үнэлэх үнэлэмжид хүчтэй цохилт өгдөг бөгөөд цаашлаад бусдын даган дуурайх хандлагатай, санаачилгагүй, идэвхгүй хүн болж төлөвшихөд хүргэдэг.

Хорих ангийн гол зорилго нь хоригдлыг засарч хүмүүжихэд чиглэх ёстой байтал, харин бүхнийг адилхан болгож жигдрүүлэх нь тэдний хувь хүний өөрчлөлт, өсөлтөд саад учруулж магадгүй. Хүн аливаа эерэг өөрчлөлтийг хийхийн тулд эхлээд өөрийгөө үнэ цэнтэй, дахин нийгэмд хэрэгтэй хүн болж чадна гэсэн итгэлтэй байх шаардлагатай. Гэтэл үсээ хүртэл өөрийн мэдлээр авч чадахгүй, өөрийн бие дээр бүрэн эрхгүй болсон мэт мэдрэмж нь хоригдлуудыг идэвхгүй, гутрангүй төлөвт шилжүүлдэг. Зарим судалгаагаар шоронгийн хатуу, дүрэмтэй орчин дахь “Ономатофоби” буюу нэр, дүр төрхөөр нь дуудуулах эрхээ алдах айдас нь хоригдлуудын дунд түгээмэл байдгийг тэмдэглэсэн байдаг. Үүний илэрхийлэл нь үс хусах явдал бөгөөд энэ нь хоригдлуудын дунд далд эсэргүүцэл, үзэн ядалт, эсвэл эсрэгээрээ дөжирсөн хайхрамжгүй байдлыг бий болгодог. Ямар ч байсан, хүнийг хүчээр ижил байдалд оруулах нь сэтгэл зүйн эрүүл бус орчин бүрдүүлдэг нь тодорхой байна.

Хүмүүжлийн зорилготой харшилдах нь

Хорих ялын үндсэн зорилго нь зөвхөн шийтгэх биш, нийгэмшүүлэх буюу дахин хүмүүжүүлэх, гэмшүүлэхэд оршдог гэж Монгол Улсын Эрүүгийн хууль болон холбогдох бодлогод заасан байдаг. Гэтэл хүмүүжлийн үйл явц зөвхөн сахилга батыг албадуулах замаар хэрэгждэггүй, харин хоригдолд өөрийгөө хөгжүүлэх, алдаагаа ухамсарлах, өөрийн зан үйлээ өөрчлөх боломж олгох замаар хэрэгжинэ. Хэрэв хорих ангийн орчинд хоригдлуудыг байнгын ёс суртахуунгүй доромжлолын байдалд байлгавал тэдний дотоод өөрчлөлт хийх, эерэг зан үйлийг төлөвшүүлэх хүсэл сонирхол нь буурдаг. Жишээлбэл: өдөр бүр гараараа хүрэх, толинд харахад өөрийн хүсээгүй халзан толгойгоо харж, мэдэрч, хүртэх мэдрэмжийг авч буй хоригдол уг байдлаа өөрчлөх ямар ч аргагүйдээ гутарч, ингэх тусам шоронгийн захиргааны эсрэг дургүйцэл, үзэн ядалт тээж болно. Ингэснээр хүмүүжүүлэх гэж оролдсон ч үр дүнгүй болж, хоригдол суллагдсаны дараа ч нийгэм, төрийн эсрэг хандлагатай үлдэж магадгүй.

Хүмүүжлийн эерэг орчин бүрдүүлэхийн тулд харин ч хоригдлын өөрийгөө хүндлэх мэдрэмжийг сэргээх, өөрчлөгдөхөд нь дэм өгөх шаардлагатай гэж шинжээчид зөвлөдөг. Үүний тулд хоригдолд тодорхой хэмжээний сонголт хийх эрх, хувийн орон зайг мэдрэх боломж олгох нь чухал. Жишээлбэл хорих ангийн дэглэм дотор хүрээндээ хоригдолд үсээ өөрөө авах уу, эсвэл бага зэрэг урт үлдээх үү гэдгээ сонгох боломжийг олгоход ямар хохирол учирч болох вэ? Үндсэндээ ямар ч ноцтой гэмгүй, харин хоригдолд өөрийгөө хүн гэж мэдрэх, өөрийн бие дээр бага ч гэсэн шийдэх эрхтэй гэдгээ ойлгоход нэмэр болох байв. Энэ мэт хүний үнэ цэнийг мэдрүүлэх жижиг алхмууд нь эргээд хоригдлын зан төлөвт эергээр нөлөөлж, хүмүүжлийн ажлын үр дүнд сайнаар нөлөөлнө. Тиймээс үс хусах шиг өнгөц “сахилга бат” шаардах практик нь алсдаа хүмүүжлийн зорилготой зөрчилдөж, илүү хор хөнөөлтэй.

Жендэрийн мэдрэмжийн асуудал болох нь

Өмнөх онолын шинжилгээд дурдсанчлан, хоригдлын үсийг хусах практик нь голдуу эрэгтэйчүүдэд ноогддог. Энэ нь Жендэрийн асимметр үүсгэдэг бөгөөд нийгэмд “эрэгтэй хүн бол гадаад үзэмжээрээ доромжлуулахад тэтглээ эмзэг биш” гэсэн буруу ойлголтыг давхар хэвшүүлдэг. Үнэндээ, хүний нэр төрийн асуудалд жендэр хамаарахгүй – эрэгтэй ч бай, эмэгтэй ч бай хүн бүр доромжлол мэдрэх мэдрэмжтэй. Гэтэл манай уламжлалт соёлд эмэгтэй хүний урт үсийг гоо үзэсгэлэнгийн бэлгэ тэмдэг гэж үзэж, түүнийг хүчээр авахыг маш аймшигтай доромжлол гэж үздэг атлаа эрэгтэй хүний хувьд үс нь “хамаагүй зүйл” мэт өрөөсгөл ойлголт байсаар иржээ. Үүнд нэг жишээ дурдахад Монголын уламжлалд эрэгтэй хүн үсээ урт ургуулах нь харьцангуй ховор байсан тул халзан байх нь энгийн мэт болсон байж магадгүй. Харин орчин үед олон эрэгтэйчүүд үс засалт, гадаад төрхдөө анхаардаг болсон бөгөөд тэдэнд ч бас үсээ хүсээгүй байхад нь хусуулах нь гутамшигтай санагдаж болно. Иймд жендэрийн мэдрэмжтэй засаглалын зарчмын дагуу хорих байгууллагад аливаа журмыг мөрдөхдөө эрэгтэй, эмэгтэй хүний сэтгэлзүйд хэрхэн нөлөөлөхийг адил тэгш авч үзэх хэрэгтэй. Эрэгтэй хоригдлын нэр төрийг ч эмэгтэй хоригдлын нэгэн адил хүндэтгэх учиртай. Жендэрийн ялгаа гаргаж буй өөр нэг тал нь эмэгтэй хоригдлын хувьд үс хусах нь нийгмийн зүгээс ил тод шүүмжлэл дагуулах нь гарцаагүй тул шоронгийн захиргаа анхаардаг. Харин эрчүүдийн эрхийн асуудал төдийлөн хөндөгддөггүй тул уламжлал нэрийн дор хадгалагддаг явдал юм. Энэ нь эрэгтэйчүүдийн эрхийн асуудлыг орхигдуулж буй нэг хэлбэр гэж хэлж болно.

Нийгэмд шошголох нөлөө

Өмнө нь хөндсөнчлөн, судалгаанд дурдсантай адил хоригдлуудыг бүгдийг нь халзан болгосон байдал нь нийгэмд ч өөрийн нөлөөг үзүүлдэг. Шоронгоос суллагдаад ирсэн хүнийг гаднаас нь хараад л таних боломжтой байх нь тэр хүнийг нийгэмд дахин дасан зохицоход сөргөөр нөлөөлнө. Жишээлбэл суллагдсан хүн ажлын ярилцлагад ороход дөнгөж шоронгоос ирсэн нь илт байвал ажил олгогчийн хандлага сөрөг болж магадгүй. Энэ утгаараа хорих ангийн үс хусах дүрэм нь хоригдолд насан туршийн шошго хадах үйлчилгээг үзүүлж байна. Нийгэмшүүлэх зорилготой хорих ялын хувьд, ял эдэлсэн хүн эргэн нийгэмдээ уусах ёстой байтал бие махбод дээр нь ийм түр зуурын ч болов “тамга” мэт дарж байгаа нь тэр зорилготой харшилж байна. Улмаар хоригдлуудыг нийгэм үл ойшоох, гадуурхах үзлийг улам дэврээж мэднэ. Энэ нь гэмт хэргээ давтан үйлдэх магадлалыг ч нэмэгдүүлдэг сөрөг үр дагавартай.

Эдгээрийг дүгнэхэд хоригдлын үсийг албадан хусах явдал нь нийгэм-сэтгэлзүйн талаас ч сөрөг нөлөөтэй, хоригдлын өөрийн үнэлэмжийг унагаж, засрал хүмүүжилд саад болж, нийгэмд тэднийг шошготой мэт ялгаварлах хандлагыг дэвэргэдэг. Мөн энэ практик нь жендэрийн тэгш бус ойлголтыг хүчтэй болгож, эрэгтэй хоригдлын нэр төрийг хамгаалахад хангалттай анхаардаггүй явдлын илрэл юм. Иймээс зөвхөн хууль зүйн талаас зөрчилтэйгөөс гадна нийгмийн

бодлогын хувьд ч үр ашиггүй, хор уршигтай арга хэмжээ гэж дүгнэж болох байна.

V. ДҮГНЭЛТ

Манай улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих ангиудад хоригдлын үсийг заавал хусах уламжлалт практик нь олон улсын хүний эрхийн гэрээний шаардлагууд болон Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжийн зохицуулалттай нийцэхгүй болохыг дээрх судалгаагаар тогтоолоо. Олон улсын хэмжээнд, хоригдлыг хүнлэг, нэр төртэй нь харьцах ёстойг тунхагласан ICCPR-ийн 10-р зүйл, Нельсон Манделагийн дүрэм зэрэг баримт бичигт хоригдлын гадна төрхийг үндэслэлгүйгээр албадан өөрчлөх, доромжлохыг хориглосон санааг агуулдаг. Европын Хүний Эрхийн Шүүх ч ялтанг хүчээр халзан болгох нь хүний нэр төрийг доромжилсон, хэрцгий харьцаа мөн²¹ гэж хэрэгтээ эцэслэн шийдсэн байдаг. Монгол Улсын хууль тогтоомжид хоригдлын эрхийг хамгаалах зарчмуудыг тунхагласан ч практикт байгууллагын дотоод журмаар үс хусах явдал нь энэхүү зарчмуудын хэрэгжилтийг алдагдуулж байна.

Хоригдлын үсийг хусах нь түүний хувь хүний халдашгүй байдлыг үл хүндэтгэсэн, нэр төрийг нь гутаасан шинжтэй тул Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.13 дэх хэсэг, Монгол Улсын олон улсын гэрээ Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын 1, 16 дугаар зүйл заалттай зөрчилдөж байна.²² Мөн хэрэв тухайн хоригдол шашны итгэл үнэмшлийн улмаас үсээ авхуулахыг хүсэхгүй бол түүний шашин шүтэх эрхийг зөрчиж буй хэрэг болно. Уламжлал болсон гэх энэ арга хэмжээ нь эрэгтэй, эмэгтэй ялтнуудад өөрөөр нөлөөлдөг нь жендэрийн тэгш байдлын зарчимд ч нөлөөлж болох юм. Нийгэм, сэтгэл зүйн хувьд, хоригдлыг халзан болгох нь түүнийг дотооддоо дорд үзэх сэтгэгдэлтэй үлдээж, хүмүүжих итгэл найдварыг нь бууруулж, суллагдсаны дараа ч “шоронгийн” тамгатай мэт харагдуулан нийгмийн ялгаварлалд өртөх шалтгаан болдог. Эдгээр нь хорих ялын зорилго болох нийгэмшүүлэх, дахин төлөвшүүлэх зорилгод нийцэхгүй, харин ч тэр зорилгыг ухраадаг сөрөг үр дагавар юм.

Иймд манай улс хорих ангийн дотоод дүрэм, журам, практиктайгаа олон улсын хүний эрхийн стандартыг уялдуулан сайтар нягтлах шаардлагатай хэрэгцээ тулгарч байна. Хүний эрхийг дээдэлсэн ардчилсан нийгэмд ялтан хүний ч гэсэн үл хөндөгдөх өөрийн үнэ цэн, нэр төр бий гэдгийг мартаж болохгүй. Хоригдлуудыг хүмүүжүүлэх нэрээр ил болон далд аргаар доромжлох, хувийн онцлогийг нь үгүйсгэх аливаа үйл ажиллагааг хязгаарлах учиртай.

²¹ European Court of Human Rights (ECHR). (2003). Yankov v. Bulgaria, no. 39084/97. Judgment of 11 December 2003. Strasbourg: ECHR.

²² Нэгдсэн Үндэстний Байгууллага, (1984, х. 1, 3)

VI. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Дүн шинжилгээнд үндэслэн дараах санал, зөвлөмжийг дэвшүүлж байна:

1. *Хууль, журамд өөрчлөлт оруулах тухай*

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон холбогдох дүрэм, журамд хоригдлын үсний засалтын талаар тодорхой зохицуулалт оруулж, “хоригдож байх хугацаандаа гэмт хэрэг дахин үйлдэх, шоронгийн дотоод журмыг онц ноцтойгоор зөрчсөн гэх зайлшгүй нөхцөлөөс бусад тохиолдолд хоригдлын үсийг түүний зөвшөөрөлгүйгээр авахыг хориглоно” гэсэн утга бүхий заалт оруулах нь зүйтэй. Мөн дүрэмд хоригдолд өөрийн үс, сахлаа өөрөө арчлах, тохируулан засах боломжийг олгох тухай тусгах хэрэгтэй. Ингэснээр хорих ангийн практик олон улсын стандартад ойртоно.

2. *Шашны эрхийг хангах тухай*

Хорих байгууллага нь ялтан хүний шашин шүтэх эрхийг хангах үүрэгтэй тул, хэрэв хоригдол шашны шалтгаанаар үсээ авхуулахгүй байх хүсэлт гаргавал тусгай журам гарган зохицуулдаг байх хэрэгтэй. Үүнд тухайн хоригдлыг ариун цэвэр, эрүүл ахуйгаа сахих нөхцөлийг нь бүрдүүлж байвал үсний уртыг нь зөвшөөрөх, шашны зан үйлд хэрэглэх алчуур, толгойн өмсгөл зэргийг хорих ангид зөвшөөрөх гэх мэт арга хэмжээг багтааж болно.

3. *Хүмүүжлийн арга барилыг сайжруулах тухай*

Хоригдлуудын сахилга батыг хангах нэрийдлээр хэрэгжүүлдэг боловч үнэндээ хүмүүжилд сөргөөр нөлөөлдөг арга хэмжээнүүдийг дахин хянах шаардлагатай. Үс хусах зэрэг практик нь сахилга баттай огт холбоогүй, харин ч хоригдлын эсэргүүцэл, үл хүндэтгэлийг дэвэргэдэг тул оронд нь хоригдлын эерэг оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээ (сургалт, зөвлөгөө, хөдөлмөр эрхлэлтээр дамжсан хүмүүжлийн ажлууд г.м) авах нь үр дүнтэй.

4. *Жендэрийн мэдрэмжтэй хандлага*

Эрэгтэй хоригдлын сэтгэл зүйн хэрэгцээ, нэр төрийн асуудалд ч эмэгтэй хоригдлын адил анхаарах нь чухал. Хорих ангийн ажилтнуудад жендэрийн мэдрэмжийн сургалт явуулж, “эрэгтэй хүн тэсвэртэй байх ёстой” гэх мэт хэвшмэл ойлголтоос үүдсэн хэт хатуу арга барилыг халан, бүх хүн (хоригдол) адилхан эмзэг гэдгийг ухамсарлах шаардлагатай.

5. *ХЭҮК болон хөндлөнгийн хяналт*

Хүний эрхийн Үндэсний Комисс нь хорих ангиудад энэ чиглэлээр мониторинг хийж, хоригдлын нэр төр, хувийн хэрэгцээ хангагдаж буй байдалд үнэлгээ өгөх нь зүйтэй. Тухайлбал, хоригдлууд үсээ хүсээгүй байхад нь хусуулж буй талаар гомдол, саналаа илэрхийлэх боломжтой

эсэх, үсээ өөрчлөхийг хүссэн тохиолдолд ямар дэг журам үйлчилж буйг шалгаж, дүгнэлт гаргах хэрэгтэй. Энэ үндсэн дээр холбогдох байгууллагад зөвлөмж хүргүүлж, залруулах арга хэмжээ авхуулах нь үр дүнтэй.

6. *Нийгэм, олон нийтийн ойлголт*

Олон нийтэд хоригдлын эрхийн асуудлаар зөв ойлголт түгээхдээ хүний нэр төр нь ямар ч нөхцөлд хүндэтгэгдэх үнэт зүйл болохыг таниулах шаардлагатай. Хоригдлын үсийг хусах тухайд олон хүн “юун сүртэй юм, шоронд байгаа хүн шорондоо таарсан байдалтай л байх ёстой” гэх хандлагатай байж магадгүй тул, энэ нь илүү өргөн утгаараа хүнийг дорд үзэх үзлийг дэвэргэж байдгийг тайлбарлах хэрэгтэй. Ингэснээр бодлогын өөрчлөлтийг олон нийт дэмжих суурь бүрэлдэх юм.

Эдгээр зөвлөмжийг хэрэгжүүлснээр Монгол Улс Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын практикийг ардчилсан, хүмүүнлэг нийгмийн зарчимд нийцүүлэн шинэчилж, хоригдлын эрхийг хамгаалах чиглэлд ахиц гаргах боломжтой. Хүний эрхийг хүндэтгэдэг нийгэмд ямар ч хүн, бүр ял эдэлж буй хүн ч гэсэн үндсэн эрх, нэр төрөө гээх ёсгүй. Хоригдлын үсийг албадан хусах уламжлалт аргаасаа татгалзаж, оронд нь хувь хүний ялгамж чанарыг нь хүндэтгэн нөхөн сэргээх бодлого баримтлах нь нийт нийгмийн эрх ашгийн төлөө юм. Энэ нь хорих ангиас суллагдсан хүмүүсийн нийгэмд дахин идэвхтэй, эерэг гишүүн болох боломжийг нэмэгдүүлэх сайн талтайгаас гадна Монгол Улсын олон улсын өмнө хүлээсэн хүний эрхийн үүргээ биелүүлэх явдал болно.

VII. НОМ ЗҮЙ

Монгол эх сурвалж

1. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс., Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл, 2024.

Гадаад эх сурвалж

1. Droege, C. (2007). “In Truth the Leitmotiv”: The Prohibition of Torture and Other Forms of Ill-Treatment in International Humanitarian Law.”, *International Review of the Red Cross*, 89(867), 515–541.
2. Coyle, A. (2009). *Handbook for Prison Staff: A Human Rights Approach*. Second edition.
3. European Court of Human Rights (ECHR). (2003). *Yankov v. Bulgaria*, no. 39084/97. Judgment of 11 December 2003. Strasbourg: ECHR.
4. United Nations Human Rights Committee. (1992). General Comment No. 21: Humane Treatment of Persons Deprived of Liberty. U.N. Doc. HRI/GEN/1/Rev.1.
5. United Nations General Assembly. (2015). *United Nations Standard Minimum Rules*

for the Treatment of Prisoners (Nelson Mandela Rules).A/RES/70/175.

6. United Nations General Assembly. (2010). United Nations Rules for the Treatment of Women Prisoners and Non-custodial Measures for Women Offenders (Bangkok Rules).
7. International Covenant on Civil and Political Rights (ICCPR). (1966). United Nations.
8. United Nations. (1983). Convention against Torture and Other Cruel, Inhuman or Degrading Treatment or Punishment.

Эрх зүйн эх сурвалж

1. Монгол Улсын Үндсэн хууль. (1992).
2. Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль (шинэчилсэн найруулга). (2017).
3. Монгол Улсын Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль. (2011).
4. Хорих ангийн дотоод журам. (2017). ХЗДХЯ-ны сайдын тушаалаар баталсан.

Цахим эх сурвалж

1. Болор, Х. (2019). “Хорихын эмнэлэг ба төсөөллийн зөрүү.” Dardas.mn.
2. Мятагбадам, Ж. (2023). “Урьдчилсан хориход 9 сар саатуулагдаж буй Б.Ганхуягийн үсээ засуулсан байдлаас ямар мессеж харж болох вэ.” Eguur.mn.
3. Н. Марал. (2019, January 11). “Өсвөр насны хоригдол 9 хүүхдийг хорих ял эдлэхээс хугацааны өмнө суллажээ.” <https://toimnews.mn/post/16654>
4. HRC General Comment No. 21: Article 10 (Humane Treatment of Persons Deprived of Their Liberty) | Global Health & Human Rights Database. (n.d.).

UIH.MN
СУДАЛГААНЫ САН



ФЕРНАНДА ПИРИЕ, ЭРХ ЗҮЙН АНТРОПОЛОГИ¹
FERNANDA PIRIE., THE ANTHROPOLOGY OF LAW, 2013

ХУУЛЬ БА ТӨР

Нэгдүгээр бүлэгт би төрийн хуулийн загвар эрх зүйн гүн ухаанд ноёрхох болсон хэмээн дэвшүүлсэн. Хууль бол захирагчийн тушаалын асуудал гэж Остин нотолсон нь нөлөөтэй байсан бөгөөд уг үндэслэл нь Гоббсын засгийн газрын эрх мэдлийг зөвтгөдөг үзэлд үндэслэдэг. Энэхүү загвар нь эрх зүйн антропологи дахь дэг журмыг сахиулах, маргааныг шийдвэрлэх, төрийн бус хуулийн мөн чанарын талаархи асуултуудыг мөн тодорхойлсон. Гэхдээ энэ номонд авч үзсэн олон жишээнүүдийн цөөхөн нь л муж улсын хууль гэж нэрлэгддэг зүйлтэй холбоотой. Легализмын нийгмийн сэтгэл татам байдал, ач холбогдлыг ойлгохын тулд албадлагын механизм, эрх мэдлийн бүтцээс цааш харах шаардлагатай байгаа нь ойлгомжтой. Ингэснээр бид эрх зүйн онолчдыг аль нэг улсын удирдлага, гүйцэтгэх эрх мэдлээр дэмжигдээгүй учраас удаан хугацаанд зовоож байсан олон улсын эрх зүйн “асуудал”-ыг эргэн харж болно. Бусад антропологичдын нэгэн адил би олон улсын эрх зүй нь орчин үеийн улс орнуудын хууль гэж юу байдгийг харуулсан парадигматик жишээтэй дүйцэх статустай байх ёстой хэмээх саналыг дэвшүүлж байна.

Энэ бүлэгт би орчин үеийн ертөнц дэх эрх зүйн хэлбэрийн хүч чадал, сонирхлыг судлахын тулд хүний эрхийн талаарх баримт бичиг, үзэл санааг багтаасан орчин үеийн олон улсын хууль тогтоомжийг авч үзсэн боловч хэдийгээр үндэстэн дамнасан хууль бол эртний феноменон гэдгийг санал болгож байна. Түүхийн жишээг авч үзэх замаар тайлбарлах боломжтой. Нэгдүгээрт би төр, төвлөрсөн засгийн газрын өсөлт, түүний доторх эрх зүйн байр суурийн талаарх социологийн зарим судалгааг авч үзэх болно. Энэ нь захирагчдын эсрэг баталсан эсвэл уриалсан хуулиудын судалгаанаас ялгаатай юм: хууль ба захирагчдын хоорондын харилцаа олон янз байдаг.

УЛС ГҮРНҮҮД БА ХУУЛИУД

Бид хуулийг төрийн монополь гэж үзэх болсон нь төрийг байгуулах төсөл, түүнийг дэмжсэн үзэл суртлын үзэл баримтлал амжилттай хэрэгжсэний гэрч юм (Таманаха 2008: 379). Орчин үеийн үндэсний эрх зүй нь Фицпатрик

¹ Монголын Криминологичдын холбооноос санаачилан Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс, МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Археологи, антропологийн тэнхим, Монголын Антропологийн холбоо хамтран хэрэгжүүлж байгаа “Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн хууль зүйн антропологийн судалгаа” хэмээх төслийн хүрээнд “Fernanda Pirie, The Anthropology of Law, Clarendon Law Series, Oxford university press, 2013” хэмээх номын орчуулгыг цувралаар хүргэж байна. Энэхүү номыг дараах холбоосоор орж үзнэ үү.

https://books.google.mn/books?id=SbbDAQAAQBAJ&printsec=frontcover&source=gbs_ge_summary_r&cad=0#v=onepage&q&f=false

(1992: 114)-ийн тайлбарласнаар жам ёсны хууль, гэгээрлийн объектив, бүх нийтийг хамарсан зарчмуудын эсрэг шинжтэй байдаг. Улмаар тухайн улсын хууль нь дүрэм журмын дээд хэлбэр болох домогт хэмжүүр болж, түүнийг орлож, эсвэл түүнд захирагдах багахан бөгөөд хэсэгчилсэн эрх зүйн хэм хэмжээг хамардаг. Төрт улсын хувьд засаглал ба хууль нь нийгмийн зорилгод хүрэх хэрэгсэл болгон бүтээгдэж, ашиглагдаж, хууль нь хамтын зорилгод хүрэх, засгийн газар болон түүний үйл хэргийг зохион байгуулж, эмх цэгцтэй байлгахад чиглэгдсэн эрх мэдлийн институцичлэгдсэн аппаратыг хөгжүүлдэг (Таманаха 2008: 381). Энэ нь мөн захиргааг аливаа зүйлийн мөн чанар хэмээн үзэж, баталгаажуулдаг (Фицпатрик 1992: 163). Түүхийн судалгаа нь эдгээр үйл явц дахь эрх зүйн онцгой үүрэг болон түүнийг эрх мэдэл, төрийг барих хэрэгсэл болгон ашиглахад юу тустай болохыг тодруулах боломжтой.

Хууль ба эрх зүйн нарийн төвөгтэй байдлын талаарх түүхэн тоймдоо Таманаха хууль ба үндэстэн хоорондын холбоог 9-р зуунд үр дүнд хүрсэн үндэстэн байгуулах төслүүдийн бүтээгдэхүүн хэмээн тодорхойлжээ. Гэхдээ энэ нь нийгмийн дүрэм журмын бусад хэлбэрийг захирах буюу орлох хуулийг хэрэгжүүлж байсан өмнөх хөгжилд үндэслэсэн юм. Келлигийн (2002: 301) тайлбарласнаар XVIII зууны хууль тогтоох парадигм хөнгөвчлөгдсөн деспотизм, эмхтгэлийн хэлбэрийг авсан: Прусс, Австри, Францад Ромын хуулиар загварчилсан эмхтгэлүүд нь бүх хувийн хуулийг нэг тогтолцоонд оруулж зохион байгуулах зорилготой байв. Наполеоны *Иргэний хууль* нь Ромын эрх зүйн баялаг дээр үндэслэсэн бөгөөд ард түмэндээ хууль, дэг журмыг авчирч цэргийн ололт амжилтаа ахиулах зорилготой байсан нь энэхүү алсын харааны хамгийн олонд түгсэн биелэлт байв. Түүний төрөлжсөн хууль 1804 онд буюу түүнийг өөрийгөө Эзэн хаан Наполеон гэж тунхаглахаас ердөө хоёр сарын өмнө хэвлэгдсэн. Юстинианы нэгэн адилаар Наполеон хунтайжийн хүсэл бол хууль хэмээх хуучин үзэл санааг нухацтай авч үзэж, төрөлжсөн хуулиудын тогтолцоогоор дамжуулан институци болгон хувиргахаар шийдсэн: Келлигийн хэлснээр (2002: 289) тэрээр ертөнцийг эзэмших, эрэмбэлэх ер бусын эрхэм зорилгодоо автаж, энэ нь Юстиниан адилаар харьяат иргэдийнхээ амьдралыг өлгийнөөс булш хүртэл захирах гэсэн үг байв.²

Европ дахь эрх зүйн хөгжлийн хүрээнд зан заншлын болон шашны хуулиуд аль хэдийн хувийн салбар руу хөөгдөж хуулийн хүчин чадалгүй болсон байв (Фицпатрик 1992: 115; Таманаха 2008: 381). Дараагаар нь барууны эрх зүйн тогтолцоо хүн төрөлхтний зан үйлийн бүх хэлбэрийг зохицуулах эрх мэдэлтэй, харьяалагдах нийгэмлэгийнхээ хүрээнд өргөн цар хүрээтэй, дээд зэргийн чанартай болсон (Раз 1979: 116–21; Финнис 1980: 148). Татварын төслийг хэрэгжүүлэх, нөөцийг төвлөрүүлэх, цэрэгт элсүүлэх ажлыг зохион

² Келлигийн нэгтгэн дүгнэснээр (2002: 300) хүн бүр эрин үеийн мэргэн ухааныг нэгэн тогтолцоонд багтааж, түүхэн үйл явцыг эцэслэхийг хүсч байсан; тус бүрдээ бүх түвшинд хадгалагдах хууль, дэг журмын тухай төсөөлөлтэй байв.

байгуулах гэсэн дүрмийн хэрэгслээр хангахаас гадна тэдэнд хууль ёсны эрх мэдэл өгөхийн тулд бусад дүрмүүд, норматив зохицуулалтыг 'баталж' өгөх эрх мэдлийн туслах хэлбэрүүдийг сонгосон (Даймонд 1973: 327). Жишээлбэл Английн нийтлэг хууль нь нутгийн зан заншлыг хүлээн зөвшөөрөх үйл явцыг аажмаар хязгаарлаж, ойн эрх зүй, худалдааны эрх зүйн хүчин төгөлдөр байдлыг үнэлэх болсон (Иббетсон 2007: 167 дахь талаас). Францад коутюм зан заншлуудыг бүтээсэн нь Наполеоны иж бүрэн төрөлжүүлсэн нэгтгэлтээс ч өмнө төв шүүхийн харьяалалд хамруулсан. Ийнхүү хуулийн талаарх ерөнхий ойлголт нь захирагчийн төлөвлөгөөг нэгтгэхэд үзэл суртлын дэмжлэг үзүүлэх боломжтой юм. Энэ нь улсын дэмжлэггүй байсан ч тохиолдож болно: Исламын *шариа* нь нутгийн ёс заншил болох урфыг материаллаг эх сурвалж, өөр бусад хуулийн хэлбэрээс ч илүүтэй үйл баримт хэмээн үздэг. Дрешийн (2012: 14) хэлснээр 'нийтлэг эрх зүй ба шариа нь ертөнцийн өөр бусад үзэл бодлыг захирах буюу хязгаарлах арга барилыг өөрчилсөн' юм.

Хууль тогтоомж нь нийгмийн дэг журмын бусад хэлбэрийг тогтоохоос гадна системчлэх зорилго агуулж болох нь зарим эртний төрөлжүүлсэн хуулиудаас илэрхий байдаг. Гуравдугаар бүлэгт дурдсанчлан Витман (1996) зах зээлийг хянахын тулд Месапотами, эртний Грек, Герман төрөлжүүлсэн хуулиудтай холбогдуулан тайлбар хийхдээ үнэ цэн, үнэ, нөхөн олговрын төлбөрийн нарийн жагсаалтуудын онцлогийг тодорхойлсон. Үүнтэй ижил зорилго VII зууны Төвдийн бичиг баримтуудад илт байдаг нь эрт үеийн эзэн хаад тоо бүртгэл болон төрөлжүүлсэн хууль бүтээж, талбаруудыг хуваарилж, шагнал, шийтгэл, жин, хэмжүүрийн тогтолцоо бий болгосон тухай тэмдэглэсэн байдаг (Бэкот нарын хамтарсан бүтээл 1940; Стэйн 1986); эзэн хаад баян, ядууг гурван удаа тэнцүүлсэн хэмээгддэг (Петех 1977: 35-36). Энэтхэгийн *дхармашастирууд* дээр үндэслэсэн эрх зүйн эмхтгэл болох Тайландын *таммасатын* нарийн бөгөөд нарийвчилсан дүрмүүд нь хувь хүн ба төр хоорондын харилцааг тодорхойлж, хүмүүсийн хоорондын харилцааг зохицуулах зарчмуудыг тодорхойлсон байдаг (Энгел 1975: 3).

Эдгээр төрөлжүүлсэн нэгтгэлтийн системчилсэн зорилго нь захирах боломжтой нутгийг бүтээх зүгт хийж буй алхмууд бололтой. Тухайлбал нөхөн олговрын төлбөрийн дүрмүүд хувь хүмүүсийг тодорхой зэрэглэл, ангилал дотроо тэгш эрхтэйгээр цогцлоосон. Фицпатрикийн (1992: 166) санал болгосноор орчин үеийн эрх зүй субъектийг үр дүнтэй оролцогчдын хувиар бүрэлдүүлсэн нь захиргааны субьекттэй ихээхэн нийцдэг; хувь хүний хууль ёсны эрхийн тархалтыг засгийн газрын хяналтыг хурдасгахтай хослуулдаг (Фицпатрик 1992: 125). Грэбер (2011) -ийн хэлснээр дүрмийг мөнгөний нэгэн адил тэнцүү байдлыг бэлгэдэхэд ашиглаж болох боловч хүмүүс болон хүн хоорондын харилцаан дахь хувь хүний чанарыг алдагдуулдаг. Хэн нэгэн хүн бусдад туслахдаа өөрийн ах, дүү, эсвэл ижил насны бүлэг, клубийн гишүүн учраас туслахын оронд хэмжиж солилцох замаар бусдад ямар нэгэн зүйл өгдөг;

дүрэм таныг хамгаалагч, дэмжлэг үзүүлэгчийн үүргийг тодорхой бус ч гэсэн хариуцлагын дагуу гүйцэтгэдэг ивээн тэтгэгч гэхээсээ илүү худалдан авагч, хохирогч, гүйцэтгэгч, ажил олгогч, газрын эзэн хэмээн тодорхойлдог.³ Гэрээ болон гэрээ байгуулж буй хувь хүний талаарх санааг улсын хууль тогтоомж боловсронгуй болгохтой холбогдуулан авч үзэх боломжтой байв (Фокс 1993: 96–97). Фоксын хэлснээр төрийн эрх мэдлээр дэмжигдсэн гэрээний эрх зүйн засаглал нь эцэстээ бусад бүх хүмүүсийн ач холбогдлыг булаан авсан бөгөөд үүнд гол зүйл нь гэр бүлийг эрх зүйн үндсэн нэгж болгон сольсон явдал байв. Улс хувь хүмүүсийг хааяа хавчиж мөрддөг эсэхээсээ үл хамааран нэгж байдлаар удирдахад хялбар байдаг тул хамаатан садангийн бүлгүүдээс илүү нэгж хувь хүмүүс байдлаар оршиход нь илүү баяртай байдаг (1993: 184).

Фокс (1993: X) -ын хэлснээр ураг төрөл ба төр хоорондын, ураг төрөл ба гэрээ хэлцэл, ураг төрөл ба индивидуализмын хоорондох дайн нь түүхэн дэх хамгийн том хөдөлгөгчдийн нэг байсан.⁴ Энэ нь нөхөн үржихүйн болон залгамжлалын асуудлыг зохицуулдаг хууль тогтоомжийг батлахад, хэрэглэхэд одоо хүртэл тулгардаг тэмцэл юм. Үүнд Стрэтэрн (2004) -ий тайлбарласан Папуа Шинэ Гвиней дэх 'нөхөн олговор'-ын үүднээс охиноо гэрлүүлэх, тээгч эхийн асуудал (Фокс 1993: 2-р бүлэг), эсвэл охиноо гэрлүүлэхээр бэлэг болгон өгдөг гэх мэт уламжлалт зан үйлийг хянах асуудал багтана. Потэж, Мүнди хоёрын (2004) засварласан боть орчин үеийн дэлхийн улс орнуудын хууль тогтоомж, тэдний өмч, хүний ангиллыг ихэвчлэн хүнд хэцүү нийгмийн харилцааг хамардаг болохыг олон янз байдлаар харуулсан болно.

Тиймээс улсын хууль нь нийтлэг алсын харааг бий болгож, дэг журмын талаарх бусад алсын харааг амжилттай захирч чадна; энэ нь хувь хүмүүсийг захиргааны субъект болгон бүрдүүлэх боломжтой; хэдий тийм ч энэ нь нийгмийн харилцаа, ялангуяа хүмүүс, ураг төрлийн оролцоотой холбоотой өөр өөр хэлбэрүүдтэй тулгарч магадгүй юм. Хэдий амжилттай Засгийн газрын зохицуулалтын төлөвлөгөөнүүд байсан ч олон удирдагч эрх мэдлээ хуулиар автократ шинж чанартай хэрэгжүүлж байсан ч эрх зүйн түүх нь захирагч хууль тогтоох эрх мэдлийг хязгааргүй хэрэгжүүлэх боломжтой байх ёстой гэх үзэл санааг байнга эсэргүүцдэг болохыг харуулж байна.

³ Энэ нь нөхөн олговрын хүснэгт хувийн шинж чанаргүй эдийн засгийн харилцаа, түүн дотроо зээл, өрийн боломж руу шилжих нэг хэсэг болж, улмаар баян хүмүүс ядуучуудын давуу талыг ашиглаж болзошгүй гэсэн таагүй нөхцөл байдлыг бий болгож байна. Грэбер (2011: 191) -ийн хэлснээр, ивээн тэтгэгч-үйлчлүүлэгчийн харилцаа нь үүргээ тасралтгүй биелүүлэхийг шаардаж, зээл нь албан ёсны эрх зүйн тэгш байдлыг хангадаг ч үүнтэй зэрэгцэн хэрцгийг авир, хүчирхийлэлд өртөх боломжтой байдаг.

⁴ Түүний дэвшүүлж буй үзэл дагуу төрөл төрөгсөд ба улсын хуулийн хоорондох урт тэмцэл нь хууль ёсны эрх мэдэл хэрэглэх монополчлол бүхий Креон хууль, түүнийг сахиулах цагдаатай байсан домогт Тебийн хуулийг зөрчсөн Антигоны хувь заяагаар үлгэр жишээ болгон үзүүлсэн юм. Креоны тушаалыг эсэргүүцэн ахыгаа оршуулах гэж зүтгэснээр Антигона гэр бүлийнхээ өмнө хүлээсэн үүргээ төрийн өмнө хүлээсэн үүргээс дээгүүр тавьж байв (Фокс 1993: 3-р бүлэг).

ЗАХИРАГЧИЙН ДЭЭРХ ХУУЛЬ

Тавдугаар бүлэгт дурдсанчлан Хятадад эзэн хаад өөрсдийгөө эрхэм дээд, хуулиас дээгүүр гэж үздэг байв. Гэвч тэд мөн Тэнгэрийн даалгаврыг итгэмжлэн авсан гэдгээ хүлээн зөвшөөрч, түүний хуулиудыг болон өвөг дээдсийнхээ хэм хэмжээ тогтоосон актуудыг хүндэтгэх үүрэгтэй гэдгээ хүлээн зөвшөөрч байсан юм. Өвөг дээдэс, бурхны сургаалыг хоёуланг нь эш татсанаар Хятадын эзэн хаадын эрх мэдэл, давуу байдлыг хууль ёсны болгож, хэлбэрийн төдий байх эсэхээс үл хамааран өвөг дээдсийнхээ хуулийг хүлээн зөвшөөрч, дагаж мөрдөх үүрэг хүлээлгэсэн юм. Эртний грекчүүд мөн хуулиа идеалжуулж, еврипидууд уг хуулийг үндсэндээ нийтийн асуудал хэмээн тунхагладаг байжээ. Захирагчид практик дээр хууль тогтоомжоор хязгаарлагдаж байсан эсэхээс үл хамааран захирагч хуулийг заавал дагаж мөрдөх ёстой гэсэн санааг тодорхой хэмжээнд илэрхийлсэн байв.

Ромд Юстинианы Дигест *quod principi placuit legis habet vigorem* буюу хунтайжид таалагдах зүйл хууль ёсны хүч чадал байдаг хэмээн тунхагласан нь нэрд гарсан. Энэхүү максимыг дундад зууны Европт Наполеоноос өмнө ч захирагчийн үнэмлэхүй хязгааргүй эрхийг зөвтгөхийн тулд өргөнөөр ашиглаж байсан (Николас 1962: 17). Гэсэн хэдий ч Ромын эзэн хааны хууль тогтоох эрх мэдлийн баталгаа нь тодорхой бус эхлэлтэй байв. Дээрх максимыг хэлсэн хэмээгдэх хуульч Ульпиан эзэн хаан бүрийн хууль тогтоох эрх мэдлийг үнэн хэрэгтээ хаанчлалынх нь эхэнд ард түмэн өгсөн хэмээн тайлбарласан (Стейн 1999: 59). II зуунд Гайус эзэн хааны *constitutiones* нь *lex*-ийн хүч чадалтай байсан ч хэд хэдэн эрх зүйн эх сурвалжуудын зөвхөн нэг нь байсан хэмээн баталж байв. Юстинианы үед хуульчид эзэн хаан нь хуулиас ангид байдаг гэх *princeps legibus solutus est* санааг гаргаж ирсэн. Гэхдээ Юстинианы хуульд сэргээн толилуулсан Теодосиусын хуульчилсан актад эзэн хаан эрх мэдлийн шинж тэмдэг болох хууль тогтоомжид захирагддаг гэдгээ зарлах ёстой хэмээн заасан байдаг (Стейн 1999: 60). Хууль ямар нэгэн байдлаар тэнгэрлэг эсвэл сансар огторгуйн эрх мэдэлтэй холбоотой гэх ойлголт байсан: Дигестийн эхний гарчигт хууль бол 'жинхэнэ философи' бөгөөд түүнийг хэрэгжүүлэгчид 'хуулийн санваартнууд' хэмээн баталдаг (Келли 2002: 291). Өөр нэг хэсэг нь эрх зүй судлалыг 'хүн болон бурханлаг зүйлсийн тухай мэдлэг' гэж тодорхойлдог (Стейн 1999: 46). Ромын эзэн хааны эзэнт улсдаа тогтоосон үнэмлэхүй хязгааргүй эрх мэдэл нь ард түмний бүрэн эрхт байдлын шинж тэмдэг болох хууль, хуульч нарын бурханлаг эрх мэдэл бөгөөд хуулийг дагаж мөрдөх бол эзэн хааны нэр төрийн үйлдэл байсан гэх ойлголтуудтай зэрэгцэн оршиж байв.

ЗҮҮН ӨМНӨД АЗИ ДАХЬ ЭНЭТХЭГИЙН ХУУЛЬ

Захирагч, хууль хоорондын нарийн төвөгтэй, тодорхойгүй харилцаа давтамж олонтой байдаг. Жишээлбэл зүүн өмнөд Азийн хууль ба улс төрийн

эрх мэдлийн хоорондын харилцаа нь нэлээд их тайлбар, хэлэлцүүлгийн сэдэв байсаар ирсэн. Санскрит хэл дээрх бичвэрүүд болон Хиндү үзэл нь өнөөгийн Тайланд, Бирма, Камбож, Ява улсын хууль тогтоомжийн хөгжилд ихээхэн нөлөөлсөн (Хоокер 1978). О'Коннор (1981: 225)-ын тодорхойлсноор Тайландчууд Буддын шашны *дхармагийн* хэлбэрийг нутагшуулж, тайлбарлаж, хялбарчилж, түгээмэл болгосноор Тайландын *тамма* буюу сансрын хуулийн тухай нэгдсэн ойлголтыг бий болгожээ. Энэ нь хувь хүн, захирагчдын үйлдлээс дээгүүрх бүх зүйлийн ёс суртахууны дэг журам байв. Тайландын эрх зүйн бичвэр болох таммасат хувь хүн ба муж хоорондын харилцааг тодорхойлохын сацуу захирагчийн засаглах ёстой хэм хэмжээнүүдийг тогтоож байсан (Энгель 1975: 4-5). Тайландад дор хаяж XIII зуунаас эхтэй, хааны хуультай зэрэгцсэн уламжлал байсан бөгөөд эртний хаад өөрсдийгөө сансрын ертөнцтэй зохицолтойн учраас хууль тайлбарлагч, бүх нийтийн хаад хэмээн танилцуулж байв. О'Коннор (1981: 22-28)-ын дэвшүүлж буй саналын дагуу Гурван тамганы хууль гэж нэрлэгддэг таммасатын 1805 оны шинэчилсэн найруулгад хуультай төстэй хэд хэдэн зарлиг, хааны шийдвэрийг багтаасан байх бөгөөд үүний үр дүнд Тайландын хууль хятад хайрцагнуудын багц шиг болсон: сансрын хууль нь өөрөө хааны буюу позитив хуулийг агуулсан таммасат хэмээх байгалийн хуулийг баталсан.

Ерөнхийдөө эдгээр бүс нутгуудын хаад зарлиг гаргаж байсан боловч үндсэн болон тогтвортой хууль тогтоомжийг албан ёсоор танилцуулж чадаагүй юм. Лингат (1950: 4)-ын хэлснээр тэд нэгэн зэрэг хуулийн тогтолцооны бүтээл, бүтээгч, хамгаалагч байжээ. Тайландын хааныг сансрын хуулийн бэлгэ тэмдэг хэмээн үзэж байсан (О'Коннор 1981: 226); эсвэл Гийрц (1983: 200)-ийн хэлснээр 'эзэн хааны тушаалууд зүй ёсны үйлдлүүд агуулж байвал хуулийн илэрхийлэл болдог' байв. Иймд дармашастирууд болон Тайландын Таммасат нь нийгмийн зан үйлийн дэг журмыг сахиулах хааны үүргийг зөрчсөн хүмүүсийг шийтгэн хуульчилсан боловч захирагч бусад хүмүүсийн адил дармагийн зарчимд захирагддаг байв.⁵ Төрийн эрх мэдлийг ариун хүмүүс удирдан чиглүүлэх шаардлагатай байв (Гийрц 1983: 202, н. 51). Мэдээжийн хэрэг Лингат (1950: 11)-ын тайлбарласнаар олон хаад практик дээр үнэмлэхүй захирагчид байсан бөгөөд хуулин дахь шашны заалтуудаас гажсан байх бүрэн боломжтой юм. Гэвч хууль ядаж онолын хувьд тэдний эрх мэдлийг хязгаарлаж, үйлдлийг нь хэлбэржүүлж байсан юм.

ДУНДАД ЗУУНЫ ЕВРОП

Европ сэтгэлгээнд хуулийн мөн чанар, гарал үүсэл, физис ба номос хоорондын харилцаа, тэнгэрлэг хууль, жам ёсны эрх, учир шалтгаан, хааны эрх мэдлийн

⁵ Тайландад хаанчлал ба хуулийн хоорондын харилцааг 19 -р зууны сүүл ба 20 -р зууны эхэн үед хууль ёсны дагуу засаглал хуулийн дор орших тухай гадаад үзэл санааны нөлөөн дор нээлттэй хэлэлцэж байсан бөгөөд Энгел (1975) эдгээр санаанууд дараагийн жилүүдэд практикт хэрхэн хэрэгжсэн талаар дэлгэрэнгүй тайлбарласан байдаг.

талаарх урт хугацааны маргаантай түүхийг Аристотель (Келли 1990; Мурфи 2005, 2007) -аас эхтэй байдаг. Дундад зууны үед Фриц Керн (1939: 69–81) -ийн тайлбарласнаар хаан ширээнд залгамжлагдах салшгүй эрхийн тухай санаа хараахан гараагүй байв.

Хуулийг хэрэгжүүлэхийн тулд төр оршин тогтнож байдаг гэсэн Макиавеллигийн үе хүртэл эсэргүүцэлгүй байсан зарчмуудын талаар Германы болон сүм хийдийн санал нэгдмэл байв; төрийн эрх мэдэл бол хэрэгсэл, хууль бол эцсийн зорилго юм; хаан нь өөрөөс дээгүүр, өөрийн оршихуйн үндэс болсон хуулиас хараат байдаг Германы төрийн эрх зүй нь зан заншлын эрх зүй байж, 'эцэг өвгөдийнхөө эрх зүй', өмнө нь байсан, объектив байж, эрх зүйн нөхцөл байдал нь олон тооны субъектив эрхүүдийн цогц байсан Германы улс төрийн үзэл санааны дагуу төрийн зорилго нь хуучин дэг журам, хуулийг засаад, хадгалж үлдэх явдал байв (1939: 70).

Дундад зууны хожуу үед хаан нь жам ёсны эрх зүйгээс доогуур боловч позитив эрх зүйгээс дээгүүр, өөрөөр хэлбэл заншлын эрх зүйн харилцаанаас ангид байсан гэсэн санаа Тайландын хаадтай гайхалтай зэрэгцэн оршиж байв. Хэдий тийм ч эрх мэдлийн шатлан захирах ёс тодорхой бус байв. Кернийн тайлбарласнаар хаан шударга ёс, тэгш байдлын аль алинд нь үүрэг хүлээх ёстой гэж үздэг бөгөөд эдгээр нь заншил, жам ёсны эрх зүйгээс бүрддэг байв. Түүгээр ч үл барам учир шалтгааны хуулийг зөвхөн позитив эрх зүйгээр илэрхийлэх боломжтой байсан тул хаан нь тэнгэрлэг хуулийг хэрэгжүүлж, наад зах нь сүм хийдийн үзэл бодлоор позитив эрх зүйг дагаж мөрддөг байв (1939: 72).⁶

Түүнчлэн ард түмний бүрэн эрхт байдлын тухай ойлголт байв: 'Хууль бол олон нийтийн бодит итгэл үнэмшил байсан бөгөөд хаангүйгээр хүчин төгөлдөр бус боловч хаанаас дээгүүр байр суурь эзэлж байсан тул хууль бус "дарангуйлал" руу шилжин доройтуулалгүйгээр олон нийтийн итгэл үнэмшлийг үл тоомсорлох боломжгүй байв. Франкийн хаад хууль боловсруулсан боловч эдгээр нь ерөнхийдөө ардын аман зохиол байдалтай үлдэж, ард түмэн олж, хаан томилж байв (1939: 73). Дундад зууны үеийн сайн засаглалын стандарт шинж чанар нь хууль тогтоомж, шударга ёсны үзэл санааг дээдэлж байсан бөгөөд энэ нь хүмүүсийг өөрсдийн хуулийн дагуу захирах гэсэн үг байв (Дунбабин 2001: 117). Бодит байдал дээр ч тэр дундад зууны үеийн ноёд хуулинд захирагдаг болохоо үргэлж хүлээн зөвшөөрдөг байсан бөгөөд энэ тухай тангаргийг шинэ захирагчид байнга өгдөг байж, эцэст нь шашны нөлөөгөөр титмийн тангараг өргөдөг байжээ. Коэн (1993: 39–42) тайлбарласны дагуу дундад зууны хожуу үед Францын хойд хэсэгт

⁶ Дундад зууны үеийн сэтгэлгээний түүх нарийн төвөгтэй. Дунбабин (1965: 2001) XIII зууны захирагчийн харьяатуудтайгаа харилцах харилцааг хууль бус харин сайн санаа, боловсролоор хэрхэн хянаж байсныг дүрсэлжээ. Иргэний хууль нь их дээд сургуулиудад заасны дагуу нэр хүндтэй байсан боловч захирагчийн эрх мэдлийг хязгаарлах арга техник хэмээн үзэгдэж байсангүй.

хийсэн титмийн тангараг нь заншлын тухай сайн, хуучин санааг давтсаар байв. *Custumals* зохиогчид ёс заншил нь үйл явцтай, өөрчлөгддөг бөгөөд захирагчид шинэ хууль тогтоомжид байнга хамрагдаж байдаг гэдгийг ухамсарладаг байсан ч цэвэр, хуучин, сайн ёс заншлын эрх зүйн идеал хүчтэй хэвээр байсан. Энгийн ойлголт нь хууль юуны түрүүнд шударга байх ёстой гэж шаарддаг байв. Хаан өөрийн бүтээсэн хуулийг бус ард түмэндээ хуваалцсан хууль, ёс заншлыг хэрэгжүүлснээр шударга захирагчийн статусыг олж авч байсан юм (1993: 47).

Англид 1312 онд шүүгч Лорд Берефордын тавьсан нэгэн алдарт илтгэл дагуу хууль тогтоомж бол хааны захиргаанд хэрэглэгддэг ёс заншилд оруулсан нэмэлт өөрчлөлт бөгөөд үүнээс өөр юу ч биш хэмээн дурджээ (Милсом 1981: 177). Хууль тогтоомж нь хааны захиргаанд ихэвчлэн хэрэглэгддэг заншлыг давж байгааг шууд хүлээн зөвшөөрөөгүй юм (Плукнетт 1922). Милсом (1981: 25)-ын дэвшүүлж буй үзлээр хэрэв бид дэлхийн ухамсрын институци, дундад зууны үнэмлэхүй эрхийн талаарх дундад зууны үеийн төсөөт талыг эргэн санавал, хууль тогтоомжийг чанд сахиулах арга хэрэгсэл болох тэгш эрхийн дараагийн өсөлт нь тодорхой. Гоббсын үзэж буйгаар захирагчийн тушаал эсвэл ёс заншил, хууль тогтоомж, улс гүрний шүүхүүд хэрэгжүүлдэг мэргэжлийн тайлбар хэлбэрээр төр хуулийг бий болгодог байх боломжтой гэдгийг нэлээд хожуу хүлээн зөвшөөрсөн юм. Энэ нь эцэстээ хууль, ёс суртахуун, *ius* -ийг *lex* -ээс, эсвэл *le loi* -аас *le droit* -г онолын хувьд салгахад хүргэсэн юм (Финнис 1980: 208). XVIII зуунд ч гэсэн 'өөрөө хууль дээдлэх ёсонд захирагдаж байсан эрх баригч ангийн дүр төрхийг харуулахын тулд асар их хүчин чармайлт гаргасан' (Томпсон 1975: 263). Хуулийг захирагчийн тушаалаар эсвэл хууль тогтоогчийн гаргасан тогтоолоор тодорхойлж болно гэсэн санаа нь хар цагаан түүхтэй (Мерфи 2005).

ӨМНӨД БАПТИСТУУД

Жинхэнэ хуулийн ямар нэгэн давамгайлсан эрхийн холбоо нь орчин үеийн баруунд ч арилаагүй байна. Эрх зүйн онол судлаачид 'позитив эрх зүй' гэсэн үзэл санаанд эвгүй байсаар ирсэн бөгөөд энэ нь тусгаар тогтнолын тушаалуудыг нэг эх сурвалжаас олж авсан, эсвэл Милсомын (1981: 25) хэлснээр хууль ба ёс суртахууны хоорондын уялдаа холбоог анги танхимд авч үзэж байх ёстой гэж үзэж байв. Дворкин (1986), Уолдрон (1995) нарын өөр өөр хэлбэрээр санал болгосны дагуу жам ёсны эрх зүйн онолууд (1980 оны Финнис) болон норматив бүртгэлд хавсаргасаар байна.

Жинхэнэ хууль ёс суртахуун, жам ёсны эрхээс эхтэй гэсэн үзэл баримтлалыг дагаж мөрдөх нь эрх зүйн онолчдоор хязгаарлагдахгүй. Грийнхаус (1986) АНУ-ын Жоржиа мужийн баптист нийгэмлэгийн талаар хийсэн судалгаандаа тус мужийн дутуу дулимаг хууль тогтоомжийг дамжуулж буй дээд зэргийн буюу тэнгэрлэг хуулийн талаарх ойлголтынх нь талаар авч хэлэлцсэн. Түүний

хэлснээр (1986: 120) Баптистууд сөргөлдөөнөөс зайлсхийхийг чухалчилж, авралд хүрэхийн тулд үүнийг даван туулах шаардлагатай гэж үздэг. Маргааныг бүрэн эрхтэйгээр шийдвэрлэхэд шаардагдах шүүх эрх мэдэл нь Баптист сургаалын нутгийн ойлголттой зөрчилддөг: тэдний эв найрамдлын үзэл нь цэвэр байдлыг илэрхийлж, хүний эрх мэдлийн хэрэгцээг үгүйсгэдэг (1986: 195–96). Түүний үзэж буйгаар Баптистууд Токвилийн хэлсэнтэй адилаар америк мөрөөдөл гэж нэрлэгддэг ямар нэгэн зүйлийг, өөрөөр хэлбэл дуулгавартай байдал дээр бус харин оролцоонд суурилсан, хүний эрх мэдлийг ил тод хэрэглэдэггүй нийгэмд хүрсэн юм. VII бүлэгт дурдсан Армянчууд болон Бербер тосгоны хүмүүсийн нэгэн адил Баптистууд ёс суртахууны хэм хэмжээг, ялангуяа эв найрамдлын идеалыг дагаж мөрддөг бөгөөд энэ нь тэднийг ёс суртахууны өргөн ертөнцтэй, энэ тохиолдолд Христийн шашинтнуудтай холбож, тэдгээрийг Христэд сүсэггүй хөршүүд болон улс төрийн удирдагчдаас ялгадаг (1986: 196). Грийнхаус (1982)-ын тайлбарласнаар Баптистууд өөрсдийгөө Библийн хэм хэмжээ, үзэл баримтлал, үнэт зүйлээ хуваалцдаг гэж үзэж, эдгээр хэм хэмжээг дагаж мөрдөх нь тэдэнд өөртөө ногдуулсан төрийн дүрэм журмыг дагаж мөрдөхөөс огт өөр зүйл хэмээн үздэг. Энэ нь тэд муж улсын хуулийг хүндэтгэдэггүй гэсэн үг биш, харин олон нийтийн үнэт зүйл, амлалтаа сэргээхийг эрэлхийлж шүүхийн үйл явцаас зайлсхийдэг. Тиймээс тэдний нийгэмд утга учиртай хэм хэмжээ нь тухайн муж улсын эрх зүйн тогтолцооны хэм хэмжээ биш харин тэдний шашин шүтлэгийн хэм хэмжээ юм (1982: 63).

Грийнхаусын үзэж буйгаар хуулийн талаарх Америкийн санаа бодлыг ерөнхийд нь тусгаснаар хуулийг нэг талаараа 'нийгмийн үйл ажиллагааны болон органик чанаруудын нийлбэр' гэж үздэг (1989: 266); Баптистуудын хувьд энэ нь хүмүүст амар амгалан амьдрахад тусалдаг бөгөөд оюун ухаан, Бурхан, байгаль дээр оршдог (1989: 257). Эсрэгээрээ албан ёсны хуулийг америкчууд хүн бүтээсэн гэж үздэг бөгөөд элит байгууллагуудын гаднаас тогтоосон дүрмийн асуудал байдаг (1989: 269). Баптистуудын шүүхийн хэрэглээ нь ялгаатай, хүсээгүй зүйл бөгөөд энэ нь иргэд, итгэгчдийн тэгш эрхийг зөрчдөг (1989: 258). Хуулийн тухай хоёр ойлголт байдаг бөгөөд энэ нь олон нийт, бурханлиг чанар, шударга ёсны тухай үзэл санаатай холбоотой хуулийн ерөнхий ойлголт байж, хууль тогтоомж, төрийн эрх зүй нь хүний хүчин чармайлтын төгс бус бүтээгдэхүүн хэмээдэг. Гринхаус ерөнхийдөө америкчууд, тэр дундаа баптистууд, тэр тусмаа шашин шүтлэгээрээ бол тухайн муж улсын дүрэм, журмаас дээгүүр оршдог жинхэнэ хуулийн тухай ойлголттой болохыг тайлбарласан.

Зөвхөн захирагчид хууль тогтоох эрх мэдлийг хязгааргүй хэрэгжүүлэх боломжтой гэсэн санааг эсэргүүцэж байгаа хэрэг биш юм. Хууль нь төрийн эрх мэдэл, нэр нөлөөг дээд зэргээр хамгаалдаг үзэл санааг баталдаг гэж үздэг.

ТӨВД

Дөрөвдүгээр бүлэгт хэлэлцсэн Хиндү ертөнцийн эрх зүйн сэтгэлгээний хүрээнд захирагч нь хуулийг тусгаж, удирдан чиглүүлэх ёстой; тэрээр эрүүгийн хууль тогтоомж, шийтгэлийг түгээх, хэрэгжүүлэх замаар уламжлалт хүн амын дунд биелэлтийг хангах боломжийг баталгаажуулах ёстой байв (Дэвис 2010: 116). Энэ нь захирагчийн *дарма* байсан бөгөөд үүнийг *артасашастир* гэх бичвэрүүдэд нарийвчлан бичсэн болно. Хаан сул доройг хүчтэйгээс хамгаалахын тулд шийтгэгдэх ёстой хүмүүст өөрийн *данда* хүчийг тулгах ёстой байв (Зиммерман 2006: 214–16).

Буддын шашин Энэтхэгт МЭӨ 500-аад оноос үүсч хөгжсөн бөгөөд Хиндү шашны үзэл бодол, санаатай нягт холбоотой байсан боловч хүчирхийллийг ёс зүйгүй гэж үзэн няцаажээ. Буддын шашны бичвэрүүд хаанчлалын өөр өөр үзэл санааг боловсруулсан: Буддын шашинт хаан *кафравартин*, харьяат иргэдээ Буддын шашны зарчмуудын дагуу амьдрахыг ятгах замаар шийтгэх, хүчирхийлэх шаардлагагүйгээр дэлхийг захирах ёстой. Гэвч энэ нь засаглалын эрэлт хэрэгцээтэй тулгарсан захирагчдын хувьд практик идеалыг бараг харуулаангүй. Зиммерман (2006: 216–17)-ы тайлбарласнаар Энэтхэгийн Буддын шашны сэтгэгчид хүчирхийлэл үйлдэхгүй байх шаардлагыг бие махбодын шийтгэлийг хэрэгжүүлэх практик болон онолын аль аль нь хааны хэрэгцээ, үүрэгтэй нийцүүлэхийн төлөө тэмцэж байв. Буддын шашны бичвэрүүд хааны хууль ёсны үүрэг нь угаасаа асуудалтай байсан гэж үздэг бөгөөд зарим нь Буддын шашны сайн хаан байх боломжгүй гэх үзэл бодлын жишээг Жатака үлгэрүүдээр илэрхийлсэн (Коуэлл, Роуз 1907: № 538; Хопкинс ба Ринбүүчи 1975: 66–67; Зиммерман 2006: 218–23). Сэтгэл хөдөлгөсөн шийтгэлийн санаанд нийцсэн зөрчилдөөнтэй үүрэг даалгавруудыг эвлэрүүлэх гэсэн бусад оролдлогыг Төвдийн буддизмын үндэс суурийг тавьсан Махаяна бичвэрүүдээр боловсруулсан байдаг (Зиммерман 2000). Гэхдээ тэд хэзээ ч бүрэн итгэл үнэмшил төрүүлж байгаагүй бөгөөд хаанчлалын идеалын үр дүн нь Шмитхаузены (1999: 62) тайлбарласнаар зөрчилдөж буй хоёр үнэт зүйлсийн хоорондох хоосрол байв.

Эдгээр бичвэрүүдийн олонх нь XI болон түүнээс хойшхи зууны үед Энэтхэгээс авчирсан Буддын шашны бусад материалын асар том цогцолбортой хамт Төвд хэл рүү орчуулагдсан.⁷ Энэ нь Төвдийн эзэнт гүрэн нуран унасны дараа Төвдийн өндөрлөгт улс төрийн олон янз байдал, хуваагдал үүссэн үе байв. Бараг VI-IX зуун хүртэл үргэлжилсэн эзэнт гүрний үед шүүхийн тогтолцоог хууль тогтоох, төвлөрүүлэх үйл ажиллагаа явагдаж байсан (Томас 1936; Ричардсон 1989; Ричардсон 1990; Дотсон 2007). Үлдсэн бичвэрүүд нь нөхөн төлбөр, шийтгэлийн практик жагсаалтаас бүрддэг. Эзэнт гүрний сүүл үеэс эхэлсэн түүх судлалын уламжлал нь эртний эзэн хаан Сонгцан Гампогийн

⁷ Капстейн (2007) уг цаг үеийн улс төрийн дэвшлүүдийн талаар ерөнхий төсөөлөл сайн өгсөн.

бүтээсэн буддизмын хуулиуд байж, эртний уламжлалт хууль тогтоомжийг орлох зорилгоор Буддизмаар дамжуулан Төвдөд соёл иргэншлийг авчрах төслийн нэг хэсэг болсон юм (Бакот нарын бүтээл 1940).

Энэхүү түүхэн уламжлал нь Энэтхэгээс буддын шашны бичвэрүүдийг орчуулах явцад болон дараагаар нь улам бүр хөгжиж байв. Эзэн хаадын бүтээсэн Буддын шашны тухай хууль тогтоомжуудаас бүрдсэн байх боломжтой зүйлийг тууштай бичдэггүй байв. Зарим бичвэрүүд нь буддын шашны ёс зүй, зарчимтай ямар ч холбоогүй эзэнт гүрний хэлтэрхий мэт санагдуулдаг бол зарим нь эрх зүйн сайн тогтолцоог бүрдүүлэхийн тулд өгсөн уриалгын жагсаалтыг илүү тодотгож өгдөг (Урэй 1972; Toussaint 1978; Стейн 1986; Соренсен 1994; Дотсон 2006). Хэдийгээр тэдгээр нь хоорондоо уялдаатай биш ч гэсэн бичвэрүүд нь хаад, тэр байтугай тэдний үүрэг хариуцлагаас хамаарч, харьяатуудаа удирдан чиглүүлэх хуулийг боловсруулж өгөх ёстой байсан бөгөөд шийтгэлийн хуулиуд ёс суртахуунгүй байсныг харуулж байна. Эзэнт гүрний хууль тогтоомжийг буддын шашны ёс суртахуун, шийтгэлийн талаарх Хиндү үзэл санааг нэгтгэсэн асуудлуудаар сольсон нь гаднаас нэвтрүүлсэн эх бичвэрүүд дэх хурцадмал байдлаас үүдэлтэй байв. Дараагийн хэдэн зууны турш түүхийн уламжлал нь эзэн хааны хуулийг буддын шашны төлөвлөгөө гэж дүрсэлсээр ирсэн боловч ёс суртахууны зан үйлийн ерөнхий дүрслэл, сайн зохион байгуулалттай нийгмийн талаарх алсын харааны дагуу бичвэрүүд нь тодорхой бус, хууль бус шинж чанартай байв. Эцэст нь хэлэхэд нэгэн алдартай өгүүллэгт Сонгцан Гампогийн ял шийтгэлийн хуулиуд нь зөвхөн хуурмаг зүйл байсан бөгөөд хүн амын дунд айдас, хүсэл тэмүүллийг өдөөх зорилгоор бүтээгдсэн хэмээгдэж байв (Урэй 1972; Дотсон 2006; Миллс 2012). Энэтхэгийн эх бичвэрт дурдсанчлан Төвдийн уламжлал нь шашныхаа ёс суртахууны шаардлагыг хангасан хууль тогтоомжийн тогтолцоог боловсруулж чадаагүй мэт байна.

Хожим Түвдийн хууль гэж үзэх болсон зүйлийг XIV зуунд боловсруулсан эх сурвалжид оруулсан байдаг.⁸ Энэхүү хууль тогтоомж нь хууль тогтоох үйл ажиллагаа орчин үеийн түүхэн өгүүллэгүүдэд мэдэгдэж байсан Сонгцан Гампогийн эзэнт гүрний хуулиас гаралтай гэж тодотгосон юм. Энэ нь хэсэг бүрийн эхэнд буддын шашны тодорхой дүрслэл, зүйрлэлийг багтаасан бөгөөд цэргийн дарга, захирагч, шүүхийн ажилтнуудын зан байдал, янз бүрийн гэмт хэрэг, зөрчил гарсан тохиолдолд нөхөн төлбөр, шийтгэл оногдуулах заалтуудыг агуулсан болно (Вайт 1894; Мейсезал 1973, 1992).⁹ Буддын шашны энэрэнгүй хуулиудын үзэл санаа биелээгүй хэвээр байв. Энэхүү эмхтгэлийг 20-р зуун хүртэл Түвдэд хадгалж, хуулбарласан боловч түүний дүрмийг амьдрал дээр хэрэгжүүлж байсан гэх нотолгоо байхгүй байна. Үүний оронд

⁸ Хамгийн эртний хадгалагдаж үлдсэн хуулбар нь XVII зуунд хамаарах боловч хуулиудыг XIV зууны захирагч Чанчуб Гялцаны эрин үетэй холбон тайлбарладаг.

⁹ Британийн албаны хүн Чарльз Беллд зориулж 1917 онд бэлтгэсэн хэвлэгдээгүй орчуулга Британийн номын санд байдаг.

тэд бэлгэдлийн шинж чанартай, уялдаа холбоотой бичвэрүүд болж ХХ зууны шүүхийн танхимд гарч ирэн, процедурын хүнд хэцүү асуудлын талаар ёслол төгөлдөр зөвлөлдсөн (Дава Норбу 1974). Тэд эзэнт гүрний уламжлал болон Төвдийн засгийн газрын буддын гарал үүслийн бэлгэдэл болж байлаа. Хуулийн үзэл суртал, эсвэл бидний шүүх гэж нэрлэж болох зүйл нь хууль тогтоох үйл ажиллагааг хязгаарлаж, саад болох боломжтой.

Төвдийн оюуны ертөнцөд буддын шашны ёс зүй ба хааны үүрэг хариуцлагын хоорондох зөрчилдөөнийг гаднаас нэвтрүүлсэн бичвэрүүдэд оруулсан бөгөөд хууль нь үндсэндээ захирагчийн ял шийтгэлийн асуудал байсан гэсэн ойлголт хүчирхийлэлгүй байх шашны үзэл баримтлалтай хэзээ ч бүрэн нийцэж чадаагүй юм.

ОРЧИН ҮЕИЙН ТӨР

Идеалист зорилго нь орчин үеийн ертөнцөд ч гэсэн хууль тогтоомжийг эш татах, бүтээхэд илт харагдаж байна. Комаровуудын орчин үеийн нийгэм дэх хууль тогтоомжийн талаарх өргөн хүрээний судалгаанд, ялангуяа колончлолын дараах ертөнцөд 'хуулийн фетишизаци' гэх зүйлийг тодорхойлсон байдаг (Комаров ба Комаров 2006).¹⁰ 1989 оноос хойш дахин бичигдсэн нь шударга ёс суртахууны үндэслэлтэй, энх улс төрийг бий болгох чадварт итгэх итгэлийг төрүүлэв. Эдгээр шинэ үндсэн хуульд итгэх нь үндсэн хуулийн шүүх байгуулахтай адил шинэ эхлэл, өнгөрсөн үеийг эрс таслах амлалтад тулгуурлаж магадгүй гэж тэд үзэж байна. Бид дайны дараах болон коммунизмын дараах Европ, арьс өнгөөр ялгаварлан гадуурхалтын дараах Өмнөд Африкт хүний эрхийн үндсэн тунхаглалыг харьцуулж болох юм. Дэлхийн хоёрдугаар дайны дараах деколонизациас хэдэн арван жилийн турш бий болсон үндсэн хуулиудыг тодорхойлсон парламентын бүрэн эрхт байдал, гүйцэтгэх эрх мэдэл, хүнд суртлын эрх мэдэлд анхаарал хандуулахаас эхлээд хууль ба эрхийн давуу байдлыг тодотгон үзсэнээр Үндсэн хуулийн агуулга өөрчлөгдсөнийг Комаровчууд дурджээ (2006: 23). Хэдий тийм ч бидний харж байгаачлан захирагчийг холбосон хуулийн үзэл санаа нь эртний, наад зах нь эртний Грекчүүд парламентын бүрэн эрхт байдлыг батлахтай адил хуучин юм. Хууль нь засгийн газраас давсан гэсэн ойлголт тодорхойгүй байсан ч хууль ёсны дэглэмд үйлчилдэг бөгөөд түүхийн хувьд ихэнхдээ хааны хууль тогтоох эрх мэдлийн талаарх нотолгооны ард байх нь элбэг.

Комаровчуудын тайлбар дагуу эдгээр үндсэн хуулиудыг боловсруулж, дагаж мөрдөхдөө үзэл суртал, практик хоёрын хооронд үл нийцэх байдлын талаар 'тэр хуулийн амин сүнс, үг үсэг аль аль нь зөрчигдсэн, гомдсон, алслагдсан, нухацтай хандсан' (2006: 23). Гэхдээ Комаров (2006:24)-ын тайлбарласнаар¹¹

¹⁰ Тэд яагаад 'колончлолын дараах байдал' -д анхаарлаа хандуулахаар шийдсэн нь бүрэн ойлгомжтой биш байна. Учир нь тэдний тайлбарлаж буй зүйлийн ихэнх нь ерөнхий хамааралтай мэт сэтгэгдэл төрүүлдэг.

¹¹ Өмнөд Африкийн үндсэн хууль нь үндэстний ард түмний популист дүр төрх болж,

хэрэв бид Герман, Төвдийн хуулийн дүрмийг авч үзвэл орчин үеийн үндсэн хуулиуд нь үзэл суртлын үүднээс батлагдаж байгаа нь гайхмаар зүйл биш юм.

Комарофууд энэхүү 'шүтээнжүүлэлт'—ийг тайлбарлахдаа хуулийг үндэслэлгүйгээр шүүмжилсэн өнгө аясыг баримталж, эрх мэдлийн төлөөх маск, элит буюу зүгээр л хүчирхэг хүмүүсийн үйл ажиллагааг 'хууль ёсны байдал, ёс зүй, эд хөрөнгийг эрх мэдлийн угаалгаар бүрхэх' чадварыг онцлон тэмдэглэсэн. (2006: 31). Гэвч хэзээд ч ийм байгаагүй гэж үү? Бид 'хуулийг шүтээнжүүлэх'—ийг урьд өмнө хэзээ ч байгаагүй орчин үеийн үзэгдэл гэж тайлбарлаж, учир шалтгааныг орчин үеийн улс төрийн хүчнүүдийн неолиберал мөрийн хөтөлбөрөөс хайх шаардлагагүй. Берман (1983: 45) хэлснээр барууны уламжлал нь улс төрийн дээд эрх мэдлээс гадуур, бурханлаг эсвэл жам ёсны эрх зүй юмуу сүүлийн үед хүний эрхээс үл хамааран хуулийн цогц байх итгэл үнэмшлээс үргэлж хамааралтай байсаар ирсэн. Энэ бол эртний, олон талт үзэгдэл бөгөөд Юстинианы хууль тогтоомж, Хятадын эзэн хаадын эрх, Ромын дараах Европ дахь Германы хаадын хүсэл эрмэлзэл зэрэгтэй ижил төстэй байдаг.

ТӨРИЙН ЭСРЭГ БОЛОН ГАДНА

Комаровчууд 21—р зууны 'соёл иргэншлийн номлол' гэж нэрлэгддэг хуулийн чиг баримжаатай төрийн бус байгууллагуудын эрс өсөлтийн талаар тайлбарласан. Эрх зүйн хэл хаа сайгүй байдгийг тэд онцлон тэмдэглэсэн; албадлагын бүх арга хэрэгсэл байхгүй байсан ч гэсэн хуулийг чин сэтгэлээсээ хүндэтгэн үзэж, дэг журмыг сэргээх шүүхийн байгууллагад удаа дараа ханддаг (2006: 25—26). Хожим нь тэд 'хууль ёсны эрх мэдэл' —ийн өсөлт, иргэд, субъектууд, корпорациуд, засгийн газрууд бие биенээ шүүхэд өгөх хандлага, хүний болон үндсэн хуулийн эрхийг зөрчсөн гэж тайлбарлах талаар тайлбар өгдөг. Ийм нотолгоо нь маргаантай сонгууль, үйлдвэрлэлийн гамшиг, колоничлолын 'гэмт хэрэг', оюуны өмчийн төлөөх тэмцэл гэх мэт олон улсын үйл ажиллагаа, хууль ёсны үйл ажиллагаатай холбоотойгоор үүсдэг (2006: 26-31). Гэхдээ хуулийн хэл яагаад ийм сэтгэл татам байна вэ? Өнөөгийн улс төрийг шүүхээр шийдвэрлэж байх бөгөөд өнгөрсөн үе нь хууль, эмх замбараагүй байдлын диалектикт автдаг болсон тул колоничлолын засгийн газрууд өөрсдийнхөө 'хууль журмыг' ашигласан гэж шүүмжилдэг.

XX ба XXI зуунд хүний эрхийн өсөлтийн талаарх өргөн хүрээний антропологийн ном зохиолууд энэхүү ажиглалтыг бататгаж байна. Эдгээр үйл явдлын талаар Вилсон (2007: 352) тайлбарлахдаа: 'Төр нь нийгэм, эдийн засгийн асуудлыг шийдэж чадна гэсэн хуурамч хүлээлт үүсгэж байгаа тул эрхийг хууль ёсны болгох нь нууцлаг юм.' Үүнийг хуулийн зорилго, ач

Арменчуудын үндэстний бэлгэдэл болсон дундад зууны үеийн төрөлжүүлсэн хуулийг харьцуулахыг уриалсан (Томсон 2000).

холбогдлыг зохицуулах чадавхитай нь холбон тайлбарлаж болох юм. Өмнөх хэсэгт болон энэ номонд орсон бусад олон зүйлийн жишээнд дурдсанаар хууль нь өөрөө ёс суртахууны хүчтэй үзэл бодлыг илэрхийлэх боломжтой. Энэ нь албадлагагүйгээр эмх замбараагүй байдал, шударга бус байдлын дунд дэг журам, ёс суртахууны хариултыг олгож болох юм. Комаровын онцолж хэлснээр заримдаа хэсэг эсвэл бүх иргэдийнхээ эсрэг үйлдэл хийх нь 'хууль ёсны байдлыг бий болгодог'. Гэвч хууль мөн сул дорой хүмүүсийн зэвсэг болж, хүч чадал, хүлээн зөвшөөрөлт, дуу хоолой, бүрэн бүтэн байдал, бүрэн эрхт байдлын талаар нэхэмжлэл гаргах шүүхийн шийтгэлийг даалгах байдлаар эрх мэдлээ эргүүлэн авах боломжтой (2006: 30–31). Сул дорой, ядуу хүмүүс баян, хүчирхэг хүмүүсийн адил хууль, шүүхэд хандахад бид яагаад гайхах ёстой вэ? Хууль нь засаглалын эрх мэдлээс давсан хэм хэмжээг тогтоож, захирагч, эрх мэдэлтэн, албан тушаалтны эсрэг ашиглаж болох хэл яриа, үндэслэгээг гаргаж өгсөн нь түүхийн туршид хэрэглэгдсээр ирсэн.

Хууль нь хатуу, формалист, эзотерик байж болох ч АНУ -ын доод шатны шүүхээр хянан шийдвэрлэгдэж буй хэргийн талууд албан тушаалтнуудыг практик шийдэл хайж олохыг ятгаж байснаас үл хамааран гомдол, асуудлаар эрх зүйн ангилалд оруулдаг (Мэрри 1990). Үнэн хэрэгтээ хуулийг эрэлхийлж буй хүмүүсийн нэр төрөл нь өөр өөр цаг үед олон удаа давтагддаг (Дреш 2012: 22).¹² Битти (1986), XVII-XVIII зуунд Английн гэмт хэрэг, шүүхийн талаар хийсэн судалгаагаар үүнийг олж тогтоосон байна. Дундаж ангиуд эрүүгийн хэргийг шүүхэд шилжүүлэх үүрэгтэй байсан бөгөөд үүнд гар урчууд, ажилчид олонтой байж, тэдгээрийн өртөг өндөр байв. Тэрбээр 'уг хуулийг маргаан шийдвэрлэх, олон нийтийн гомдол арилгах хэрэгсэл болгон нийгэмд хүлээн зөвшөөрсөн бололтой. Шүүхүүд хулгай, хүчирхийлэлд өртсөн олон төрлийн хохирогчдод нөхөн олговор санал болгодог байсан' хэмээн дүгнэсэн (1986: 622). Мэрри (2010: 1068)-ийн тайлбарласнаар Европын колоничлолын эрин үед ч гэсэн эзэнт гүрнүүдийн бий болгосон шинэ шүүхүүдийг ашиглах гэж улайрсныг дүрсэлжээ. 'Ихэнх тохиолдолд' энэ урам зоригийг харьцангуй хүчгүй хүмүүс удирддаг байсан ... олон хүмүүс шинэ институтэд ураг төрлийн холбоо, эрх чөлөөт байдлаасаа гарах боломжийг олж харсан'.

Босси энэ үзэгдэл орчин цагийн Европын эхэн үед тохиолдсонд гайхсан: 'Хуулийн дүр төрх, эсвэл төр, титэм хэрхэн ариун байдлыг олж авч чадсан, энэ дэг журмын ёс суртахууны хүчин зүйл асуудалтай санагдаж байна' (1983 : 291). Хэдий тийм ч хүн бүр хууль, шүүхийг төр эсвэл титэмтэй холбон тодорхойлж байсан гэж сэтгэж болохгүй. Тэд мөн Мэрригийн санал болгосноор эрх мэдлийн харилцаанд өрсөлдөх боломжийг санал болгосон

¹² Хамфрес (2007: 3-р бүлэг) Ромын сүүл үед эрх зүйн туслалцаа авах боломжтой хэд хэдэн асуудлыг тайлбарласан. Smail (2003) XIV-XV зууны Марсель хотод мөрдөгдөж байсан шүүх ажиллагааны тоо хэмжээг тайлбарласан бөгөөд энэ нь энгийн тайлбарыг үгүйсгэдэг. Харин Босси XVII зуунд 'хүмүүсийн маргааныг титмийн шүүхэд оруулах' тухай тайлбарласан байдаг (1983: 291).

байж магадгүй. XIII зуунд Франц улсад сегнориал харилцаа нь хууль зүйн үүднээс илэрхийлэгдэх болсон тул энэ нь хүчирхэг хүмүүсийг эсэргүүцэх боломжийг олгосон: 'Тосгоны оршин суугчид, хотын консулууд, бага, том аль аль нь ноёд, бүгд хаант улсын өгсөн шүүхийн механизмыг олж мэдсэн... ямарваа нэгэн ноёрхол тулгасан хүмүүстэй тулалдах боломжийг тэдэнд олгосон.' (Чейетте 1970: 290).

Шүүх дээр эсэргүүцэл үзүүлэхийн тулд л хуулиудыг эш татаж болно гэсэн үг биш юм. Түүхэн жишээнүүдээс харахад зарим тохиолдолд хүмүүс хуулийг эрх чөлөөтэй, өөрөөр хэлбэл дур мэдэн эрх мэдэл авах эрх чөлөөтэй зүйрлэдэг. Энэ нь ялангуяа феодалын буюу квифеодалын хүрээнд тодорхой харагдаж байна. 'Дундад зууны бүтээн байгуулалт'-даа Соутерн (1953: 104–107) хэмээх сонгодог судалгаандаа эрчүүд ноёрхлоос айж, дургүйцэж байсан зүйл нь түүний захиргаа биш, харин хэрцгий байдал, тэднийг дүрмээр бус харин хүсэл зоригоороо захирч байсан явдал гэж үздэг. Эрх чөлөө нь хүсэл зориг гэхээсээ илүү хуулинд захирагдахыг хэлдэг байсан: 'баатар цэрэг жирийн чөлөөт хүнээс зүгээр олон биш бүр маш олон дүрмийг дагаж мөрддөг байсан; Чөлөөт эрийг үйлчлэгчээс дутуугүй, харин өөр, илүү оновчтой байдлаар хязгаарладаг байв. Хамгийн өндөр онцгой эрхтэй нийгэмлэгүүд нь хамгийн их хууль тогтоомж бүхий хүмүүс байсан бол үйлчлэгч нь дээд албан тушаалтнуудынхаа дур зоргоор авирлахын эсрэг хуулинд хамгийн бага ханддаг байсан.¹³ Лукас (1977: 94) энэ нь юу гэсэн үг болохыг тоймлон харуулсны дагуу 'хууль намайг эрх чөлөөтэй байлгадаг, учир нь энэ нь онцгой тохиолдлуудад дээд удирдлагад юу ч хэлэхгүйгээр юу хийхээ өөрөө мэдэх боломжийг олгодог. Энэ нь намайг олон нийтийн бүрэн эрхт гишүүн болгож, нийтийн хэм хэмжээг өөрийн үйлдлүүдэд тусгаж, бусдын үйлдлийг хүлээн зөвшөөрөх чадвартай болгодог.'

